

MONGOLIA

MONITORING THE SITUATION OF CHILDREN AND WOMEN

“CHILD AND DEVELOPMENT 2005”
survey (MICS-3)



MONGOLIA 2007

“CHILD AND DEVELOPMENT 2005” SURVEY (MICS-3)

MICS



unicef 

 MICS

«Child and development 2005» survey (MICS-3)
Mongolia, 2007

МОНГОЛ УЛС

“ХҮҮХЭД ХӨГЖИЛ 2005” судалгаа
(Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа-3)

ҮНДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2007 он

Монгол эхийг хянасан:
Рэндэндэвийн Ойдовданзан
(Монгол Улсын гавъяат эдийн засагч)

Тайланг эмхэтгэсэн:
О.Байгалмаа
Э.Мөнхзул

Тайлбар: Энэ тайлан нь англи хэлээр хэвлэгдсэн бөгөөд тайланд гарч байгаа үнэлэлт, дүгнэлтүүд нь зөвхөн бичсэн хүмүүсийн санал болно.

Тайлангийн талаар санал хүсэлт байвал доорх хаягаар холбоо барина уу.
Үндэсний Статистикийн Газар
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот
Монгол Улс

И-мэйл: nso@magicnet.mn
Факс: 976-11-324518
Утас: 976-51-264554, 976-51-266414

Монгол Улсын Хүүхэд хөгжил 2005 судалгаа (Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа-3)-г Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран явууллаа. Энэхүү судалгаа нь дэлхийн 50 гаруй оронд 2005-2006 онд зохион байгуулж явуулсан гурав дахь удаагийн ОУБТС-ны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өмнө нь 1995, 2000 онуудад явагдсан юм. Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны талаарх нэмэлт мэдээллийг www.childinfo.org вэб хуудаснаас үзнэ үү.
Ишлэл: Үндэсний Статистикийн Газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2007 он. Хүүхэд хөгжил 2005 судалгаа (ОУБТС-3)-ны үндсэн тайлан, Улаанбаатар хот, Монгол Улс

Хавтасны зургийг Б.Рэнцэндорж

Үндэсний Статистикийн Газраас эрхлэн гаргав.
Улаанбаатар хот, Монгол Улс 2007 он

АГУУЛГА

Өмнөх үг	iii
Талархал	iv
Хүснэгтийн жагсаалт	v
Зургийн жагсаалт	vii
Товчилсон тэмдэглэл	viii
Ашигласан материал	ix
Үр дүнгийн нэгтгэл хүснэгт	x
Нэгдсэн дүгнэлт	xiii
I. Танилцуулга	
Судалгааны талаар	1
Судалгааны зорилго	2
II. Судалгааны түүвэрлэлт, арга зүй	
Түүвэрлэлт	3
Асуулга	3
Сургалт, мэдээлэл цуглуулалт	4
Мэдээлэл боловсруулалт	4
III. Судалгааны хамралт, өрх хүн амын байдал	
Хамралт	5
Өрх, хүн амын байдал	5
Мэдээллийн ангилал	7
IV. Хүүхдийн эндэгдэл	8
V. Хүүхдийн хоол тэжээл	
Хоол тэжээлийн байдал	12
Эхийн сүүгээр хооллолт	14
Иоджуулсан давсны хэрэглээ	16
Эрдэс, аминдэмээр баяжуулсан гурилын хэрэглээ	17
А аминдэм	18
Бага жинтэй төрөлт	19
VI. Хүүхдийн эрүүл мэнд	
Дархлаажуулалт	20
Шингэн сэлбэх эмчилгээ	22
Уушигны хатгалгааны антибиотикийн эмчилгээ, тусламж авсан байдал	24
Хатуу түлшний хэрэглээ	25

VII. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж	
Ундны усны хангамж	26
Ариун цэврийн байгууламж	27
VIII. Нөхөн үржихүйн эрүүл мэнд	
Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгсэл	29
ЖХАХ-ийн дутагдаж буй хэрэгцээ	29
Жирэмсэн үеийн хяналт	30
Төрөх үеийн тусламж	31
IX. Хүүхдийн хөгжил	33
X. Хүүхдийн боловсрол	
Сургуулийн өмнөх боловсрол	35
Бага болон дунд сургуульд хамрагдалт	36
Хүн амын бичиг үсгийн мэдлэг	38
XI. Хүүхэд хамгаалал	
Төрсний бүртгэл	39
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	39
Хүүхдийн хүмүүжил	41
Эрт гэрлэлт	42
Гэр бүлийн хүчирхийлэл	43
Хөгжлийн бэрхшээл	44
XII. ХДХВ/ДОХ	
ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг	45
ХДХВ/ДОХ-ын халдвар илрүүлэх шинжилгээ	47
ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТ	49
Хавсралт I. Түүвэрлэлт	119
Хавсралт II. Судалгаанд оролцогчдын нэрс	123
Хавсралт III. Түүвэрлэлтийн алдаа	126
Хавсралт IV. Мэдээллийн чанар	135
Хавсралт V. Хүүхэд хөгжил судалгааны үзүүлэлт	146
Хавсралт VI. Асуулгын хуудас	154

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад гурав дахь удаагийн Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа “Хүүхэд хөгжил 2005”-г Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан хамтран санхүүжүүлж, Үндэсний статистикийн газар зохион байгуулж явууллаа.

Судалгааг амжилттай зохион байгуулж явуулахын тулд НҮБ-ын Хүүхдийн Сангаас судалгааны үе шат бүрт техник, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласаны зэрэгцээ 4 удаагийн сургалт семинарыг тусгайлан зохион байгуулж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой байсныг онцолж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлан бичих ажлыг хийж гүйцэтгэн, судалгааны үр дүнгийн тайланг монгол, англи хэлээр хэвлүүлж, нийтийн хүртээл болгох зорилгодоо бид нэгэнт хүрлээ.

Энэхүү судалгааг зохион байгуулан явуулах, асуулга боловсруулах, тайланг бичих ажилд үнэтэй санал зөвлөмж өгч, судалгааны салбар дундын Удирдлагын зөвлөл болон хамтарсан ажлын хэсэгт орж ажилласан Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төв, Цагдаагийн ерөнхий газар болон Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

Энэ судалгааны гол зорилго нь 2000 онд явуулсан өмнөх судалгаанаас гарсан өөрчлөлт, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц баримт бичиг болон Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэх явцад гарсан ололтуудыг үнэлж дүгнэх явдал юм. Уг судалгааг явуулснаар Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх бусад улс орнуудтай харьцуулагдахуйц тоо мэдээллийг үндэсний хэмжээнд бүрдүүлж, энэ талын мэдээллийн санг шинэчлэн баяжуулах боломж бүрдэх юм.

Түүнчлэн энэхүү судалгааны үрдүн нь Монгол Улсын төр, засгаас хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ахуй нөхцлийг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглагдах суурь мэдээлэл болохын зэрэгцээ судлаач, эрдэмтдийн зүгээс тодорхой чиглэлээр тусгайлсан, гүнзгийрүүлсэн шинжилгээ судалгааны ажил явуулахад мэдээллийн үндсэн гол эх үүсвэр болж чадна гэдэгт итгэлтэй байгаа болно.


П.БЯМБАЦЭРЭН
Монгол Улсын Үндэсний
статистикийн газрын дарга


БЭРТРОН ДЭЙМҮҮЛАН
НҮБ-ын Хүүхдийн Сангийн
суурин төлөөлөгч

ТАЛАРХАЛ

“Хүүхэд хөгжил” судалгаа (ОУБТС)–г Үндэсний статистикийн газраас Монгол Улсад Э дахь удаагаа амжилттай эрхлэн явууллаа.

Энэ удаагийн судалгааны зорилго нь Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судлах, түүнчлэн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр болон Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх, үнэлгээ өгөх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулахад шаардлагатай тоо мэдээллийг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно.

“Хүүхэд хөгжил 2005” судалгааны үр дүн нь “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” баримт бичгийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг бэлтгэхэд чухал ач холбогдол бүхий мэдээллийн эх үүсвэр болохоос гадна судлаач, хэрэглэгчдийг хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх баялаг мэдээллээр хангахад зохих хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

Дэлхийн 50 гаруй оронд явагдаж байгаа энэ удаагийн “Хүүхэд хөгжил” судалгааг Монгол Улсад олон улсын жишгийн дагуу, мэргэжлийн түвшинд, амжилттай зохион байгуулж явуулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан судалгааны Удирдлагын зөвлөл, ажлын хэсгийн гишүүд, үр дүнгийн тайлан бичихэд оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

“Хүүхэд хөгжил 2005” судалгааг явуулахад техник, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн НҮБ–ын Хүүхдийн Сан, түүний Зүүн Ази, Номхон далайн бүсийн байгууллага, Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын хамт олон болон судалгааны тайланг боловсруулж гаргахад хувь нэмэр оруулсан НҮБ–ын Хүүхдийн Сангийн зөвлөх хатагтай Гитте Робинсон нарт гүн талархал илэрхийлж байна.



Г.ГЭРЭЛТ–ОД

Судалгааны Удирдлагын зөвлөлийн дарга,
Үндэсний Статистикийн газрын дэд дарга

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт НН.1:	Өрхийн болон ганцаарчилсан асуулгын дүн	50
Хүснэгт НН.2:	Өрхийн хүн амын тоо, насны бүлгээр, хүйсээр	51
Хүснэгт НН.3:	Өрхийн бүтэц	52
Хүснэгт НН.4:	Эмэгтэйчүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр	53
Хүснэгт НН.5:	Хүүхдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтээр	54
Хүснэгт СМ.1:	Хүүхдийн эндэгдэл	55
Хүснэгт СМ.1:	Төрүүлсэн болон амьд байгаа хүүхдийн тоо, хүүхдийн эндэгдлийн харьцаа	56
Хүснэгт NU.1:	Хүүхдийн хоол, тэжээлийн дутал	57
Хүснэгт NU.2:	Хүүхдээ амлуулсан байдал	58
Хүснэгт NU.3:	Эхийн сүүгээр хооллолт	59
Хүснэгт NU.4:	Нялхсын зохистой хооллолт	60
Хүснэгт NU.5:	Иоджуулсан давсны хэрэглээ	61
Хүснэгт NU.5A:	Эрдэс аминдэмээр баяжуулсан гурилын талаарх мэдлэг, хэрэглээ	62
Хүснэгт NU.6:	Өндөр тунт А аминдэмийн бэлдмэл уусан хүүхэд	63
Хүснэгт NU.7:	Хүүхэд төрүүлсний дараа өндөр тунт А аминдэмийн бэлдмэл уусан эхчүүд	64
Хүснэгт NU.8:	Бага жинтэй төрсөн хүүхэд	65
Хүснэгт СН.1:	Нэг нас хүрэхийн өмнөх дархлаажуулалтанд хамрагдалт	66
Хүснэгт СН.2:	Дархлаажуулалтанд хамрагдалт, сонгосон үзүүлэлтээр	67
Хүснэгт СН.3:	Шингэн сэлбэх эмчилгээ	68
Хүснэгт СН.4:	Суулгалт өвчний гэрийн эмчилгээ	69
Хүснэгт СН.5:	Уушигны хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн үед тусламж авсан байдал	70
Хүснэгт СН.6:	Антибиотик эмчилгээ	71
Хүснэгт СН.6A:	Уушигны хатгалгаа өвчний 2 аюултай шинж тэмдгийн талаарх мэдлэг	72
Хүснэгт СН.7:	Түлшний хэрэглээ	73
Хүснэгт СН.8:	Хатуу түлшний хэрэглээ, зуухны төрлөөр	74
Хүснэгт СН.9:	Антибиотик авсан эх үүсвэр ба түүний үнэ	75
Хүснэгт СН.10:	Шингэн сэлбэх давс авсан эх үүсвэр ба түүний үнэ	76
Хүснэгт EN.1:	Сайжруулсан ундны усны хэрэглээ	77
Хүснэгт EN.2:	Өрхийн ундны усаа цэвэршүүлдэг аргууд	78
Хүснэгт EN.3:	Ундны ус авахад зарцуулдаг хугацаа	79
Хүснэгт EN.4:	Усанд явдаг хүн	80
Хүснэгт EN.5:	Ариун цэврийн байгууламжийн хэрэглээ	81
Хүснэгт EN.6:	Хүүхдийн ялгадсыг зайлуулж буй байдал	82
Хүснэгт EN.7:	Ундны усны сайжруулсан эх үүсвэр, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хангамж	83
Хүснэгт RH.1:	Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн хэрэглээ	84

Хүснэгт RH.2:	Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн дутагдаж байгаа хэрэгцээ	85
Хүснэгт RH.3:	Жирэмсний хяналт үзүүлсэн хүн	86
Хүснэгт RH.4:	Жирэмсний хяналтын үйлчилгээ	87
Хүснэгт RH.5:	Төрөх үеийн тусламж	88
Хүснэгт CD.1:	Суралцахад гэр бүлийн зүгээс үзүүлсэн дэмжлэг	89
Хүснэгт CD.2:	Сургалтын хэрэглэгдэхүүн	90
Хүснэгт CD.3:	Хүүхдээ ганцааранг нь эсвэл бусад хүүхэдтэй үлдээсэн байдал	91
Хүснэгт ED.1:	Сургуулийн өмнөх боловсрол	92
Хүснэгт ED.2:	Бага сургуульд элсэлт	93
Хүснэгт ED.3:	Бага сургуульд хамрагдалтын цэвэр жин	94
Хүснэгт ED.4:	Дунд сургуульд хамрагдалтын цэвэр жин	95
Хүснэгт ED.4A:	Дунд сургуулийн насны бага сургуульд суралцаж байгаа хүүхэд	96
Хүснэгт ED.5:	5-р анги хүртэл суралцсан хүүхдүүд	97
Хүснэгт ED.6:	Бага сургууль төгсөлт болон дунд шатны сургуульд дэвшилт	98
Хүснэгт ED.7:	Боловсрол дахь жендерийн тэгш байдал	99
Хүснэгт ED.8:	Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэг	100
Хүснэгт CP.1:	Хүүхдийн төрсний бүртгэл	101
Хүснэгт CP.2.1:	5-14 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	102
Хүснэгт CP.2.2:	5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	103
Хүснэгт CP.3.1:	Хөдөлмөр эрхэлдэг суралцагч ба хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ суралцдаг хүүхэд (5-14 нас)	104
Хүснэгт CP.3.2:	Хөдөлмөр эрхэлдэг суралцагч ба хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ суралцдаг хүүхэд (5-17 нас)	105
Хүснэгт CP.4:	Хүүхдийн хүмүүжил	106
Хүснэгт CP.5:	Эрт гэрлэлт	107
Хүснэгт CP.6:	Эхнэр, нөхрийн насны ялгаа	108
Хүснэгт CP.7:	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх хандлага	109
Хүснэгт CP.8:	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	110
Хүснэгт НА.1:	ХДХВ-ийн халдвараас сэргийлэх мэдлэг	111
Хүснэгт НА.2:	ХДХВ/ДОХ-ын талаарх ташаа ойлголтууд	112
Хүснэгт НА.3:	ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх цогц мэдлэг	113
Хүснэгт НА.4:	ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд халдах ойлголтын талаарх мэдлэг	114
Хүснэгт НА.5:	ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүнд хандах хандлага	115
Хүснэгт НА.6:	ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдлэг	116
Хүснэгт НА.7:	Жирэмсний хяналтын үеийн ХДХВ-ийн шинжилгээ	117
Хүснэгт НА.8:	Хүүхдийн амьдралын нөхцөл, өнчин хүүхэд	118

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг III.1:	Судалгаанд хамрагдсан өрх, 15-49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдийн тоо, хамрагдалтын хувь	5
Зураг III.2:	Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүд, насны бүлгээр, хувиар	6
Зураг III.3:	Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар	6
Зураг IV.1:	Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, сонгосон үзүүлэлтээр	8
Зураг IV.2:	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, эх үүсвэрээр, 1984-2005 он	9
Зураг V.1:	Тураал, өсөлтийн хоцролттой болон туранхай хүүхдийн эзлэх хувь	13
Зураг V.2:	Тураал, өсөлтийн хоцролттой болон туранхай хүүхдийн эзлэх хувь, хүүхдийн насаар	13
Зураг V.3:	Тураал болон өсөлтийн хоцролттой болон туранхай хүүхдийн эзлэх хувь, хүүхдийн тоогоор	14
Зураг V.4:	Төрсний дараах 1 цаг ба 1 өдрийн дотор хөхөө амлуулсан эхчүүд, бүс нутгаар, хот, хөдөөгөөр	15
Зураг V.5:	Нэг хүртэлх насны хөхүүл хүүхдийн хооллолт, сараар	16
Зураг V.6:	Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь, бүс нутгаар, хот, хөдөөгөөр	17
Зураг V.7:	Баяжуулсан гурил хэрэглэдэг өрхийн эзлэх хувь, бүс нутгаар	18
Зураг V.8:	Тав хүртэлх насны хүүхдийн А аминдэмжүүлэлтэнд хамрагдалт, хувиар, бүс нутгаар	19
Зураг VI.1:	Судалгааны өмнөх хугацаанд вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь	21
Зураг VI.2:	Нэг нас хүрэхээс өмнө болон судалгааны өмнөх хугацаанд вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь	21
Зураг VI.3:	Суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн 0-59 сартай хүүхдийн хувь	22
Зураг VI.4:	Суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ үргэлжлүүлэн хооллож, ердийнхөөс илүү шингэн уусан 0-59 сартай хүүхдийн хувь	23
Зураг VI.5:	Хоолоо хийхдээ хэрэглэдэг түлшний төрөл	25
Зураг VI.6:	Хатуу түлшний хэрэглээ, бүс нутгаар	25
Зураг VII.1:	Хүн амын ундны усны хангамж, эх үүсвэрээр	26
Зураг XI.1:	5-17 насны нийт хүүхдэд гэрийн ажилд тусалж байгаа хүүхдийн эзлэх хувь	40
Зураг XI.2:	5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хот хөдөөгөөр	41
Зураг XI.3:	18 нас хүрэхээс өмнө гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болсон 20-49 настай эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр	43
Зураг XII.1:	ХДХВ/ДОХ-ын халдварын талаар цогц мэдлэгтэй эмэгтэйчүүдийн хувь, боловсролын түвшингээр	46

ТОВЧИЛСОН ТЭМДЭГЛЭЛ

БСШУЯ	Боловсрол соёл, шинжлэх ухааны яам
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖХАХ	Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгсэл
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НҮЭМС	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ-ын ХС	НҮБ-ын Хүүхдийн Сан
НҮБЕАТЧ	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаарх тусгай чуулган
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
СЯ	Сангийн яам
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СХХТ	Сахуу, хөхүүл ханиад татран
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ОУБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
УБ	Улаанбаатар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ХХС	Хүүхэд хөгжил судалгаа
ХХС 2000	Хүүхэд хөгжил судалгаа 2000
ХХС 2005	Хүүхэд хөгжил судалгаа 2005
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМСҮТ	Эрүүл мэндийн статистикийн үндэсний төв
ШСД	Шингэн сэлбэх давс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

НҮБ-ын ХС, 2006. Хүүхэд, эмэгтэйчүүдийн байдалд өгөх үнэлгээ, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны гарын авлага, Нью-Йорк хот

С.О.Руцтэйн, К.Жонсон, 2004. Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа: аж байдлын индекс. харьцуулсан тайлан No.6

ҮСГ, НҮБХС, 2001 он. “Хүүхэд, хөгжил -2000” судалгаа (ОУБТС-2), Үндэсний тайлан

Монгол Улсын Засгийн газар, Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилт, Үндэсний илтгэл. Улаанбаатар, 2004

Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр. Улаанбаатар, 2002

ҮСГ, НҮБ-ын ХАС, 2004. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа 2003 он

ҮСГ, НҮБ-ын ХАС, 2001. Нялхас, хүүхдийн нас баралтад нөлөөлж байгаа хүчин зүйлс

НҮБХХ, Монгол Улсын Засгийн газар, 2003. Монголын хүний хөгжлийн илтгэл

ҮСГ, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага, 2004. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан

НҮБ, 1983, Гарын авлага Х, Хүн ам зүйн тооцооны шууд бус арга (НҮБ-ын хэвлэл)

НҮБ, 1990а. QFIVE, Хүүхдийн нас баралтын тооцооны НҮБ-ын программ, Нью-Йорк хот, НҮБ-ын Хүн амын хэлтэс

www.childinfo.org

ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ ХҮСНЭГТ

Олон үзүүлэлтийн Бүлгийн Түүвэр Судалгаа (ХХС) болон
Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ)-ын үзүүлэлт, Монгол улс, 2005

Сэдэв	ХХС- ын үзүүлэлт	МХЗ- ын үзүүлэлт	Үзүүлэлт	Утга
ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ				
Хүүхдийн эвдэгдэл	1	13	5 хургаан эмнэлэг хүүхдийн эвдэгдэл	51 1000 өсөх төрөлөгч хүүхэд
	2	14	Нарингол эвдэгдэл	40 1000 өсөх төрөлөгч хүүхэд
ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДАЛ				
Хатагтайн бичиг	6	4	Туркитай хүүхэд	6.3 кран
	7		Өмнөгийн хурдтай хүүхэд	20.9 кран
	8		Туркитай хүүхэд	2.2 кран
	45		Хурдтай нь хүүхэд өмнөгийн хүүхэд	77.5 кран
	15		Хатагтай дунд өмнөгийн хүүхэд	51.2 кран
Хатагтай өмнөгийн	16		12-15 өр	82.3 кран
			20-25 өр	64.9 кран
Индустриал дунд	17		Нарингол эмнэлэг хатагтай хүүхэд	57.4 кран
	18		Нарингол эмнэлэг дунд	21.8 кран
	19		Эмнэлэг өмнөгийн хатагтай хүүхэд	40.0 кран
	41		Индустриал дунд хатагтай	83.1 кран
А өмнө дунд	42		А өмнө дунд хатагтай хатагтай хатагтай (5 хурдтай эмнэлэг хатагтай)	64.7 кран
	43		А өмнө дунд хатагтай хатагтай хатагтай (хатагтай хатагтай хатагтай)	56.2 кран
Бичиг хатагтай хатагтай	9		Бичиг хатагтай хатагтай хатагтай	5.5 кран
	10		Хатагтай хатагтай хатагтай хатагтай	98.3 кран
ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД				
Дунд хатагтай хатагтай өмнөгийн	25		Сүрьеэгийн хатагтай хатагтай хатагтай	97.6 кран
	26		Сүрьеэгийн хатагтай хатагтай хатагтай	99.0 кран
	27		Сүрьеэ, хатагтай хатагтай, хатагтай хатагтай хатагтай хатагтай	92.0 кран
	28	15	Уламжлалын хатагтай хатагтай хатагтай	76.1 кран
	31		1 хурдтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай	67.5 кран
	33		Шинэ хатагтай хатагтай хатагтай хатагтай	62.8 кран
	34		Суурь хатагтай хатагтай хатагтай хатагтай	20.9 кран
Өмнөгийн үзлийн хатагтай	35		Шинэ хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай	46.6 кран
	23		Уламжлалын хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай хатагтай	62.6 кран

Сэдэв	ХХС- ын Үзүүлэлт	МХЭ- ын Үзүүлэлт	Үзүүлэлт	Утга	
	22		Урьдчилж нийгэмлэгийн өндөр гэмтэл хийсэн хүүхдийн тоогийнхний хувьцаа	71.1	арьс
Хатуу туслах	24	29	Хатуу туслах	76.5	арьс
	96		Энэ үүсвэр (улам)		
			Аюулгүйнх	33.4	арьс
			ШСД	51.3	арьс
			Үзэл		
			Аюулгүйнх		
			улам	1151	төгсөж
			арьс	1400	төгсөж
Энэ үүсвэр, үзэл	97		ШСД		
			улам	251	төгсөж
			арьс	350	төгсөж
УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ					
	11	30	Ундны усны байгуулалтын эл үүсвэрээр зохиогдох	71.6	арьс
	13		Ундны усны байгуулалтад	97.9	арьс
Ундны ус, ариун цэврийн байгуулалт	12	31	Сайн дуурайсан ариун цэврийн байгууламжуудын зохиогдох	77.2	арьс
	14		Хүүхдийн аюулгүйнхний өндөр түвшинд байгуулалт	99.5	арьс
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД					
БХАХ ба бусад БХАХ-ийн дуурайсан буй байгуулалт	21	19	Нягт өгч БХАХ харгалзах байгуулалтад	66.0	арьс
	98		БХАХ-ийн дуурайсан буй байгуулалт	13.7	арьс
	99		БХАХ-ийн зохиогдох байгуулалт	62.8	арьс
	20		Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйлдвэр зохиогдох байгуулалт	98.9	арьс
	44		Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохиогдох		
			Цусны өвчлөлийнхний өндөр	89.1	арьс
			Даралтын үйлдвэрлэл	98.2	арьс
			Шинэчилж зохиогдох өндөр	89.2	арьс
			Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	88.1	арьс
Энгийн ариун цэвэр	4	17	Мэргэжлийн үйлдвэрлэлийнхний өндөр түвшинд байгуулалт	99.2	арьс
	5		Энгийн ариун цэвэр	98.6	арьс
ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ					
	46		Гэр бүлийнхнийхний өндөр түвшинд байгуулалт	55.4	арьс
	47		Суралтынхнийхний өндөр түвшинд байгуулалт	43.8	арьс
Хүүхдийн өсөлт	48		Суралтынхнийхний өндөр түвшинд байгуулалт: Хүүхдийн өсөлт	26.2	арьс
	49		Суралтынхнийхний өндөр түвшинд байгуулалт: Хүүхдийн өсөлт бус өсөлт	53.1	арьс
	50		Суралтынхнийхний өндөр түвшинд байгуулалт: төгсөж	6.0	арьс
	51		Нягт өгч хүүхдийнхний өндөр түвшинд байгуулалт	13.1	арьс
ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ					
Хүүхдийн боловсрол	52		Суралтынхнийхний өндөр түвшинд байгуулалт	37.3	арьс

Сэдэв	ХХС- ын ҮҮҮАЛАТ	МХЭ- ын ҮҮҮАЛАТ	Үгүүлэлт	Утга	
	53		Сургуулийн өмнөх бэлтгэлээр хөгжсөн хүүхдийн тоо	80.5	хувь
	54		Бусад сургуульд амжилтын дүрээр хэлт	79.7	хувь
	55	6	Бусад сургуульд амжилттай дүрээр хэлт	95.3	хувь
	56		Дунд сургуульд амжилттай дүрээр хэлт	85.4	хувь
	57	7	5-р өмнө хурттай суралдаж хураах	96.4	хувь
	58		Дунд сургуульд дэвсгэлтэй түрэмэг	98.4	хувь
	59	7ь	Бусад сургуульд тэнцэлтэй дүрээр хэлт	93.6	хувь
	61	9	Хүйтний тэгш байдлын мэдээлэл Бусад сургууль	102	хувь-аар
			Дунд сургууль	107	хувь-аар
Бусад үзлийн мэдээлэл	60	8	Нэгдсэн хуралдааны бусад үзлийн мэдээллийн түрэмэг (15-24 жилийн амжилттайрууд)	94.5	хувь
ХҮҮХЭД ХАМГААЛЛА					
Төрсний бүртгэл	62		Төрсний бүртгэл	98.3	хувь
	71		Хэдхэнээр дүрэмдэг хүүхэд (5-14 нас)	18.1	хувь
Хүүхдийн хэдхэнээр дүрэмдэг			(5-17 нас)	22.5	хувь
	72		Хэдхэнээр дүрэмдэг хүүхдийн хэдхэнээр суралдаж (5-17 нас)	82.1	хувь
	73		Хэдхэнээр дүрэмдэг суралдаж (5-17 нас)	21.3	хувь
Хүүхдийн хуралдааны	74		Сэтгэл санааны бэлтгэл бус хүүхдийн дүрээр хэлт бүртгэл хэлт	79.4	хувь
Эрт гэрээлэл	67		18 нас хүртэлх өмнө гэрээлэл	7.7	хувь
	68		Гэр бүлийн/хүүхдийн амьдралтай 15-19 жилийн амжилттайрууд	3.3	хувь
	69		Эцэст, өсөлийн насны үзлийн 15-19 жилийн амжилттайрууд	7.2	хувь
			20-24 жилийн амжилттайрууд	3.3	хувь
Гэр бүлийн хүрээлэн	100		Гэр бүлийн хүрээлэнд амжилт мэдээлэл	56.4	хувь
Хөгжлийн бүртгэл	101		Хөгжлийн бүртгэлтэй хүүхэд	16.6	хувь
ДОХ/ХДХВ-ЫН ХАЛДВАРЫН ТАЛААРХ МЭДЛЭГ					
	82	19ь	ХДХВ-ын халдварын сөрөгтэй таларх мэдээлэл мэдээлэл дүрээр хэлт	31.0	хувь
	86		ХДХВ/ДОХ-ын халдвар өмнө хурт мэдээлэл	13.5	хувь
ХДХВ/ДОХ-ын таларх мэдээлэл, мэдээлэл	87		ХДХВ-ийн халдвар мэдээлэл өмнөхөд амжилттайрууд	56.9	хувь
	88		ХДХВ-ийн халдвар мэдээлэл өмнөхөд амжилттайрууд	14.6	хувь
	89		ХДХВ мэдээлэл хуралдааны бусад гэрээлэл мэдээлэл	48.8	хувь
	90		Эцэст, өмнөхөд хуралдааны бусад ХДХВ-ийн халдварын сөрөгтэй таларх мэдээлэл өмнөхөд амжилттайрууд	62.1	хувь
	91		Эцэст, өмнөхөд хуралдааны бусад ХДХВ-ийн халдвар мэдээлэл өмнөхөд амжилттайрууд	34.9	хувь
Өмнөх хуралдааны	75		Өмнөх хуралдааны хуралдааны	7.9	хувь
	78		Эцэст, амжилттай өмнөхөд амжилттайрууд	3.8	хувь

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Хүүхэд, хөгжил–2005” судалгаа нь Монгол Улсад 3 дахь удаа явуулсан олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа юм.

Энэ удаагийн судалгааны зорилго нь “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалыг хэрэгжүүлэх үйл явцын талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судлах, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002–2010)” болон Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх, үнэлгээ өгөхөд оршино.

“Хүүхэд хөгжил 2005” судалгааны онцлог нь 2000 онд явуулсан 2 дахь удаагийн судалгаатай харьцуулах боломжтой мэдээллийг бий болгож байгаагийн зэрэгцээ өмнөх судалгааны бүлгүүдийг агуулга, тодорхойлолтын хувьд баяжуулж, хүүхдийн хөгжил, хүмүүжил зэрэг шинэ бүлгүүдийг нэмж, энэ талаарх мэдээллийг баяжуулсан явдал юм.

Хүүхдийн эндэгдэл

“Хүүхэд хөгжил 2005” судалгааны дүнгээс үзэхэд 2000 онд явагдсан судалгаанаас хойш, өнгөрсөн таван жилийн хугацаанд нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл мэдэгдэхүйц буурсан байна. Тухайлбал 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын нас баралт 2000 онд 64 байсан бол 2005 онд 40 болж даруй 36 хувиар буурчээ. Түүнчлэн 1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт 87 байснаа 51 болж бараг 41 хувиар буурсан байна.

Эндэгдлийн түвшинг хот, хөдөөгөөр авч үзвэл хөдөөд хотоос 2 дахин өндөр байна.

Хүүхдийн хоол тэжээл

- *Хоол тэжээлийн дутал*

Тав хүртэлх насны хүүхдүүдийн 6 орчим хувь нь дунд хэлбэрийн тураалтай, бараг таван хүүхэд тутмын нэг (21 хувь) нь дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой буюу тухайн насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй хэт намхан, үүнээс 6 хувь нь хүнд хэлбэрийн өсөлтийн хоцролттой байна. Харин 5 хүртэлх насны хүүхдүүдийн 2 хувь нь дунд хэлбэрийн буюу биеийнхээ өндөрт байвал зохих жингээс бага жинтэй буюу хэтэрхий туранхай байна.

Баруун бүсийн хүүхдүүдийг бусад бүсийнхтэй харьцуулахад тураал болон өсөлтийн хоцролт илүү их байна.

Тав хүртэлх насны 10 хүүхэд тутмын нэг нь илүү жинтэй, ялангуяа 6 хүртэлх сартай хүүхдийн 25 хувь буюу дөрвөн хүүхдийн нэг нь илүүдэл жинтэй байна.

- *Хөхөөр хооллолт*

Сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 78 хувь нь төрснөөс нь хойш 1 цагийн дотор, 91 хувь нь нэг өдрийн дотор хөхөө амлуулсан байна.

Зургаа хүртэлх сартай нялхсын 57 хувь нь дан хөхөөр хооллож байгаа бөгөөд хөдөөд (60 хувь) хоттой харьцуулахад (55 хувь) илүү байна. 6–9 сартай хүүхдүүдийн 57 хувь нь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол хэрэглэж байна. Түүнчлэн 12–15 сартай хүүхдүүдийн 82 хувь, 20–23 сартай хүүхдүүдийн 65 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байна.

6–11 сартай хүүхдүүдийн 22 хувь, 0–11 сартай хүүхдүүдийн 40 хувь нь зохистой хооллож байна.

- *“А” аминдэмийн хэрэглээ*

Судалгаанд хамрагдсан 6–59 сартай нийт хүүхдийн 65 хувь нь өндөрт тунт А аминдэмийг сүүлийн 6 сард уусан байна. Харин сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 56 хувь нь төрсний дараах саруудад “А” аминдэм уусан байна.

“А” аминдэмжүүлэлтэнд хамрагдалт Улаанбаатар хотод хамгийн өндөр байхад Баруун бүсэд хамгийн доогуур байна.

- *Бага жинтэй төрөлт*

Сүүлийн 2 жилд төрсөн нийт хүүхдийн 98 хувийг төрсөн даруйд нь жинлэжээ. Эдгээр хүүхдийн 6 хувь нь 2500 граммаас бага жинтэй төрсөн байна.

- *Иоджуулсан давсны хэрэглээ*

2000 оны байдлаар нийт өрхийн 45 хувь нь иоджуулсан давс хэрэглэж байсан бол 2005 онд 83 хувь болж өссөн байна. Улаанбаатар хотын өрхийн 97 хувь нь хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэж байхад Баруун бүсийн өрхийн 58 хувь, Хангайн бүсийн өрхийн 74 хувь нь хэрэглэж байна.

Хүүхдийн эрүүл мэнд

- *Дархлаажуулалтанд хамрагдалт*

Судалгаанд хамрагдсан 12–23 сартай хүүхдийн 98 хувь нь 1 нас хүрэхээс өмнө сүрьеэгийн вакциныг, 92 хувь нь сахуу, татран, хөхүүл ханиалгын эсрэг вакцины эхний тунд хамрагдсан байхад хоёр дахь тунд хамрагдалтын түвшин 93 хувь, гурав дахь тунд 92 хувь болж дараалан буурчээ. Үүнтэй төстэйгээр, саагийн вакцины 1–р тунд хүүхдүүдийн 97 хувь нь хамрагдаж байхад, гурав дахь тунд хамрагдалт 93 хувь болж буурсан байна. Улаанбурханы вакциныг хүүхдүүдийн 76 хувь нь 1 нас хүрэхээс өмнө хийлгэсэн байгаа нь бусад вакцинтай харьцуулахад хамгийн бага хамралттай байна.

Судалгааны дүнгээс үзэхэд, нэг хүртэлх насандаа зайлшгүй хамрагдах ёстой 8 төрлийн вакцинд 12–23 сартай хүүхдүүдийн 68 хувь нь 12 сартай болохоос өмнө буюу товлот хугацаандаа, 82 хувь нь судалгааны өмнөх хугацаанд бүрэн хамрагдсан байна.

- *Шингэн сэлбэх эмчилгээ*

Судалгаа явуулахаас өмнөх хоёр долоо хоногт 16 хүүхдийн нэг нь (7 хувь) суулгалт өвчнөөр өвчилжээ. Ялангуяа, 6–23 сартай хүүхдүүд хамгийн өртөмтгий байв. Суулгалт өвчнөөр өвдөх тохиолдол хөдөөд (8 хувь) хотоос (5 хувь) өндөр байна.

Энэ өвчнөөр өвчилсөн хүүхдүүдийн 38 хувь нь шингэн сэлбэх давсны уусмалыг, 30 хувь нь зөвлөмжийн дагуу гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэний эмчилгээ хийлгэсэн байна. Суулгалтаар өвчилсөн хүүхдүүдийн 63 хувь нь шингэн сэлбэх ямар нэг эмчилгээ хийлгэсэн байна.

- *Хатуу түлшний хэрэглээ*

Монгол Улсад хатуу түлшний хэрэглээ маш өндөр (77 хувь), ялангуяа хөдөөд (98 хувь) бараг бүх айл, өрх хэрэглэхээс гадна хотод (61 хувь) энэ хэрэглээ өндөр байна. Хатуу түлшний хэрэглээг төрлөөр авч үзвэл мод (33 хувь), аргал, хомоол зэрэг түлш (23 хувь), нүүрс (20 хувь) эзэлж байна.

Ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хангамж

Судалгааны дүнгээр нийт хүн амын 72 хувь, хотын хүн амын 91 хувь, хөдөөгийн хүн амын 46 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдаж байна. Улаанбаатар хотын хүн амын 95 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэртэй. Энэ үзүүлэлт Төвийн бүсэд хүн амын 65 хувь, Хангайн бүсэд 54 хувь байна.

Нийт хүн амын 77 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна. Энэ хувь хотод 95 хувь, хөдөөд 53 хувь байна.

Хүүхдийн хөгжил

Судалгааны өмнөх 3 өдөрт 5 хүртэлх насны хүүхдүүдийн 55 хувийнх нь гэр бүлийн гишүүд, томчууд хүүхдүүдийг сургах, сургуульд бэлтгэхэд 4 ба түүнээс дээш үйл ажиллагаа явуулж, дэмжлэг үзүүлсэн байна.

Судалгааны өмнөх 7 хоногт 5 хүртэлх насны хүүхдийн 12 хувийг гэрт нь 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжинд, 3 хувийг ганцааранг нь үлдээжээ.

Хүүхдийн боловсрол

- *Сургуулийн өмнөх боловсрол олголт*

36–59 сартай нийт хүүхдийн 37 хувь нь сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрт хамрагдаж байна. Хөдөөгийн хүүхдүүдийн 25 хувь нь энэ хөтөлбөрт хамрагдаж байхад хотынхны 50 хувь нь хамрагджээ. Улаанбаатарт хамрагдалт хамгийн хамгийн өндөр буюу 48 хувь байхад Баруун, Хангай, Төвийн бүсүүдэд 32 хувь байна.

- *Бага, дунд сургуульд хамрагдалт*

Судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан бага ангид суралцах насны хүүхдийн 95 хувь нь сургуульд хамрагджээ. Бага сургуульд суралцагчдын цэвэр жин охидын (96 хувь) хувьд хөвгүүдийнхтэй (94 хувь) харьцуулахад бага зэрэг өндөр байна. Баруун бүсэд бага ангид хамрагдалт 92 хувь байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага, хөдөөгийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 93 хувь байгаа нь Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төвийнхөөс доогуур байна.

Дунд сургуульд суралцах насны хүүхдийн 85 хувь нь зохих шатны сургуульд хамрагдан суралцаж байна. Нийслэлд амьдардаг хүүхдүүдийн 90 хувь нь дунд сургуульд хамрагдаж байгаа бол хөдөөгийн хүүхдүүдийн хувьд 76 хувьтай байна.

Жендерийн тэгш байдлын индекс бага сургуулийн хувьд 1.02, харин дунд сургуулийн хувьд 1.07 байна.

- *Бичиг үсгийн мэдлэгийн түвшин*

Судалгаанд хамрагдсан 15–24 насны эмэгтэйчүүдийн 95 хувь нь бичиг үсэг мэддэг байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд

- *Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгсэл*

Судалгаагаар гэр бүлтэй болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 66 хувь нь жирэмслэхээс хамгаалах ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь ерөндөг бөгөөд нийт эмэгтэйчүүдийн 29 хувь нь тус аргыг хэрэглэдэг байна.

Нийт эмэгтэйчүүдийн 14 хувьд нь ЖХАХ дутагдаж байгаа нь ажиглагдаж байна. ЖХАХ–ийн дутагдаж байгаа хэрэгцээтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь боловсрол багатай эмэгтэйчүүдийн дунд илүү өндөр байгаагаас гадна бүсүүдээс Баруун бүсэд хамгийн өндөр (16 хувь) байна.

- *Жирэмсэн үеийн хяналт*

Судалгаа явуулахаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтанд хамрагджээ. Тэдний 83 хувь нь их эмчийн, 13 хувь нь бага эмч/эх баригчийн хяналтанд хамрагдсан ажээ.

- *Төрөх үеийн тусламж*

Судалгаа явуулахаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудын хяналтанд хүүхдээ төрүүлсэн байна. Нийт төрөлтийн 70 хувь нь их эмчийн, 29 хувь нь бага эмч/эх баригчийн хяналтанд явагдсан байна. Их эмчийн хяналтанд хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн хувь Улаанбаатарт хамгийн өндөр буюу 80 хувь байхад Баруун бүсэд хамгийн бага буюу 58 хувь байлаа. Мөн хотын эмэгтэйчүүд их эмчийн хяналтанд төрөх нь илүү түгээмэл ажээ.

Хүүхэд хамгаалал

- *Төрсний бүртгэл*

12–59 сартай нийт хүүхдийн 99.8 хувь нь бүртгүүлж гэрчилгээ авчээ. Харин 1–2 сартай хүүхдийг авч үзвэл бүртгүүлж, гэрчилгээ авсан хүүхдийн эзлэх хувь 77 байна.

- *Хүүхдийн хөдөлмөр*

5–17 насны хүүхдийн 0.6 хувь нь гэрээсээ гадуур хөлстэй хөдөлмөр, 1.0 хувь нь хөлсгүй хөдөлмөр, 9 хувь нь өөрийн өрхийн аж ахуй, бизнесийн ажилд орлцож, 14 хувь нь долоо хоногт 28 ба түүнээс дээш цагаар гэрийн ажилд тусалдаг байна.

- *Хүүхдийн хүмүүжил*

2–14 насны хүүхдийн 79 хувь нь сэтгэл зүйн болон бие махбодийн ямар нэг шийтгэлийг эх/асрамжлагч болон өрхийн бусад гишүүдийн зүгээс хүлээсэн байна.

Судалгаанд хамрагдсан эх/асрамжлагчдын 15 хувь нь хүүхдийг зөв хүмүүжүүлэхийн тулд тэднийг бие махбодийн хувьд шийтгэж болно гэж үздэг боловч бодит байдал дээр тэдний 38 хувь нь хүүхдээ шийтгэх арга хэмжээ авсан байна.

ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 88 хувь нь ДОХ–ын талаар сонссон бөгөөд ХДХВ бэлгийн замаар халдварлахаас сэргийлэх үндсэн 3 аргыг зөв тодорхойлсон эмэгтэйчүүдийн хувь 56 байна.

ХДХВ халдварлахаас сэргийлэх 2 арга замыг мэддэг эмэгтэйчүүдийн хувь 66, ХДХВ–ийн талаарх 3 ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эмэгтэйчүүдийн хувь 38, харин энэ үзүүлэлтийг нэгтгэж гаргасан ХДХВ/ДОХ–ын талаар цогц мэдлэгтэй эмэгтэйчүүдийн хувь 31 байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 79 хувь нь ХДХВ эхээс хүүхдэд халдварладаг болохыг мэддэг ба эмэгтэйчүүдийн 57 хувь нь ХДХВ–ийн халдвар илрүүлэх шинжилгээг хаана хийлгэхийг мэддэг бөгөөд 15 хувь нь шинжилгээнд хамрагджээ.

Судалгаа явуулахаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 62 хувь нь жирэмсний хяналтын үед ХДХВ/ДОХ–оос сэргийлэх талаар мэдээлэл авсан бөгөөд 37 хувь нь ХДХВ–ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн байна.

I

Судалгааны талаар

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн газрын 2005–2006 онд зохион байгуулж хэрэгжүүлсэн “Хүүхэд хөгжил 2005” судалгаа (Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа-3)-ны үр дүнд үндэслэн энэхүү тайланг нэгтгэн гаргав.

НҮБ-ын гишүүн 191 орны төр, засгийн төлөөлөгчид 2000 оны есдүгээр сард баталсан “Мянганы тунхаглал”, 189 гишүүн орон оролцсон НҮБ-ын тусгай чуулганаар 2002 оны 5 дугаар сард баталсан “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” зэрэг олон улсын түүхэн баримт бичигт дэвшүүлсэн зорилтууд манай оронд хэрхэн хэрэгжиж байгааг дүгнэх зорилгоор энэхүү судалгааг явуулсан болно. Хүүхдийн төлөө Дэлхийн дээд хэмжээний 1990 оны уулзалтаас дэвшүүлсэн амлалтыг хэрэгжүүлэх зорилгоор дээр дурдсан баримт бичгийг баталсан.

Улс орнуудын Засгийн газар хүүхдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулахын төлөө дээрх зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх явцыг хянаж байх үүрэг хүлээж, дээрх олон улсын холбогдох гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд НҮБ-ын Хүүхдийн сан тэдгээрийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах үүрэг хүлээсэн юм (Шигтгээ 1).

Шигтгээ 1. Үйл ажиллагааны амлалт: Үндэсний болон олон улсын түвшинд тайлагнах үүрэг хариуцлага

“Мянганы тунхаглал”, “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглал, “Үйл ажиллагааны хөтөлбөр”-т нэгдэж гарын үсэг зурсан Засгийн газрууд дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хянаж байгаа амласан. Үүнд:

“Бид хөгжлийн төлөө зорилтуудыг хангах үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дэлхий нийт, бүс нутаг, үндэсний түвшинд үнэлж, үндэсний болон боломжтой бол орон нутгийн түвшинд тогтмол хянах болно. Үүний тулд Үндэсний статистикийн байгууллагын хувьд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хүйс, нас, бусад ялгавартай шинж тэмдгүүдээр илэрхийлэх, хүчин зүйлүүдээр задлан мэдээлэх боломжийг сайжруулж, хүүхдэд чиглэсэн судалгаа шинжилгээг өргөн хүрээтэй дэмжих болно. Бид статистикийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төлөвлөлт, үнэлгээ, хяналтанд оролцох олон нийтийн чадавхийг бүрдүүлнэ. (“Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц”, 60-р зүйл) “... Үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, түүнийг хурдасгахын тулд хөгжлийн төлөө дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийн явц, байдлыг үндэсний болон орон нутгийн түвшинд тогтмол хугацаанд авч үзэж байна”. (“Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц”, 61-р зүйл) Үйл ажиллагааны хөтөлбөрийн (61-р зүйл) үйл явцын тайланг бэлтгэхэд НҮБ-ын Хүүхдийн санг тусгайлан оролцохыг уриалахдаа:

Тунхаглалын болон үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай мэдээллийг бэлтгэх, тархаахад холбогдох байгууллага, хөтөлбөр, Засгийн газруудтай нягт хамтран ажиллахыг хүүхдийн төлөө дэлхий нийтийн тэргүүлэх байгууллагынх нь хувьд НҮБ-ын Хүүхдийн Сангаас хүссэн.

Үүний адилаар Мянганы тунхаглал (31-р зүйл)-д дээрх үйл явцын талаар тухай бүр мэдээлж байх доорх заалтыг тусгасан юм. Үүнд:

“Бид Ерөнхий нарийн бичгийн даргаас, энэхүү Үйл ажиллагааны Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар Ерөнхий Ассамблейд тогтмол илтгэж байхыг хүсч байна” гэжээ.

НҮБ–ын тусгай чуулганаар “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалыг хэрэгжүүлэх үйл явцын талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг 2007 онд хэлэлцэх болсонтой уялдуулан үндэсний илтгэлийг бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, аж байдал, тэдний эрхийн хэрэгжилтийг гүнзгийрүүлэн судлах, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002–2010)” болон Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн явц, байдлыг хянах шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэх, үнэлгээ өгөх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, НҮБ–ын Хүүхдийн Сантай хамтран энэхүү судалгааг явууллаа.

Энэхүү тайланд уг судалгаанд хамрагдсан сэдэв, үзүүлэлтийн үр дүнг та бүхэнд танилцуулах болно.

Судалгааны зорилго

Монгол Улсад явуулсан “Хүүхэд хөгжил 2005” судалгааны анхдагч зорилго нь дараах зүйлд оршино. Үүнд:

- ✦ Монгол Улсын хүүхэд, эмэгтэйчүүдийн аж байдал, эрхийн хэрэгжилтийг үнэлэх шинэ мэдээлэл цуглуулах;
- ✦ “Мянганы тунхаглал”, “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” баримт бичигт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хянах, цаашдын үйл ажиллагааг төлөвлөх суурь мэдээллийг бүрдүүлэх;
- ✦ Энэ талаарх Монгол Улсын мэдээлэл, хяналтын системийг сайжруулахад хувь нэмэр оруулж, уг системийн загварыг бий болгох, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх дадлага, туршлагыг нэмэгдүүлэхэд оршино.

II

Түүвэрлэлт

Хүүхэд хөгжил 2005 судалгааны түүвэрлэлт хүүхэд, эмэгтэйчүүдийн байдлын талаарх үзүүлэлтийг үндэсний түвшинд, хот, хөдөө, бүс нутгаар тооцож гаргах зорилгоор хийгдсэн юм.

Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар гэсэн 5 бүсийг түүврийн бүлэг болгон авч, өрхийн түүвэрлэлтийг хийхдээ бүсээс сонгогдох өрхийн тоог тухайн бүсийн хүн амын тоонд пропорционалиар хуваарилж, 2 шатат түүврийн аргыг ашиглав. Баг, хорооны¹ өрх, хүн амын мэдээлэл жил бүр шинэчлэгдэж байгааг харгалзан баг, хороог түүврийн анхан шатны нэгжээр сонгосон бөгөөд түүврийн анхан шатны нэгж дэх өрхийн тоог ойролцоо байлгах зорилгоор олон өрхтэй баг, хороог 2–3 түүврийн нэгж болгон хуваасан.

Түүврийн анхан шатны нэгж болох баг, хороог пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгож, сонгогдсон баг, хорооны өрхийн жагсаалтаас тус бүр 25 өрхийг системчилсэн цикл түүврийн аргаар сонгон авч судалсан болно.

Судалгааны түүвэрт 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотыг төлөөлөх түүврийн 253 анхан шатны нэгжээс нийт 6325 өрхийг сонгож түүвэрт сонгогдсон өрхүүдээс мэдээллийг цуглуулж, судалгааны үр дүнгийн боловсруулалтыг үндэсний түвшинд хийхдээ түүврийн жинг ашигласан. Түүвэрлэлтийн талаарх нарийвчилсан мэдээллийг хавсралт I–ээс үзнэ үү.

Асуулга

Судалгааны асуулгыг боловсруулахдаа судалгааны зорилго, хамрах хүрээг харгалзан НҮБ–ын Хүүхдийн Сангийн санал болгосон 3 төрлийн загвар асуулгыг ашиглалаа. Үүнд:

1. Өрхийн сууцны хангамж, ахуй нөхцөл, өрхийн гишүүдийн талаарх өрхийн асуулга;
2. Өрхийн 15–49 насны эмэгтэйчүүдийн талаарх асуулга;
3. Тухайн өрхийн тав хүртэлх насны хүүхдийн асуулгыг хамарсан болно.

Дээрх 3 төрлийн асуулгын бүтцийг харуулбал:

Өрхийн асуулга	Эмэгтэйчүүдийн асуулга (15-49 насны)	5 хүртэлх насны хүүхдийн асуулга
Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл	Эмэгтэйн талаарх ерөнхий мэдээлэл	Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл
Боловсрол	Хүүхдийн эндэгдэл	Сургуулийн өмнөх боловсрол олголт
Ундны ус, ариун цэврийн байгууламж	Эх болон нярайн эрүүл мэнд	Хүүхдийн хөгжил
Өрхийн шинж төрх	Гэрлэлт	“А” амин дэмийн хэрэглээ
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт	Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн хэрэглээ	Эхийн сүүтээр хооллолт
Хүүхдийн хүмүүжил	Гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага	Өвчлөл, сувилгаа, дархлаажуулалт
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг	Хүүхдийн өсөлтийн үзүүлэлт
Иоджуулсан давсны хэрэглээ		

¹Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд 21 аймаг, нийслэлд, аймаг нь сумдад, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагддаг.

I. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ, АРГА ЗҮЙ

Судалгаанд өөрийн орны онцлогийг тусгасан зарим бүлэг, асуултыг, тухайлбал өрхийн асуулгын “Иоджуулсан давсны хэрэглээ” гэсэн бүлэгт эрдэс амин дэмээр баяжуулсан гурилын хэрэглээний талаарх асуулт, “Хүүхдийн хүмүүжил” бүлэгт хүүхдийн төлөвшил, хэв зуршлын асуудлаарх дэд бүлгийг судалгааны ажлын хэсэг, Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу нэмж оруулав.

Өрхийн асуулгыг өрхийн талаар сайн мэдэх, өрхийн насанд хүрсэн аль нэг гишүүнээс, эмэгтэйчүүдийн асуулгыг өөрөөс нь, 5 хүртэлх насны хүүхдийн асуулгыг хүүхдийн эх эсвэл асрамжлагчаас асууж, хүүхдийн жин, өндрийн хэмжилтийг хийсэн болно.

Судалгаанд хамрагдсан өрхийн хүнсэндээ хэрэглэж байгаа давсны иоджилтыг хурдавчилсан шалгуур ашиглан тогтоолоо.

Асуулгын хуудасны асуултууд хүмүүст хэр ойлгогдож байгаа, асуулт хоорондын уялдаа холбоо, нэг өрхөөс судалгаа авахад зарцуулах хугацааг тодорхойлох, программыг турших зорилгоор туршилтын судалгааг Төв аймгийн Эрдэнэ суманд 2005 оны 9 сард зохион байгуулж явуулсан. Энэ туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан асуулгын томъёолол, найруулга, асуултуудын хоорондын уялдаа холбоог сайжруулан боловсруулав.

Сургалт, мэдээлэл цуглуулалт

Судалгааны ажилтнуудад зориулсан сургалтыг ҮСГ–т 2005 оны 10, 11–р саруудад 10 хоногийн хугацаатай зохион байгуулж, судалгааны асуулгад орсон бүлэг тус бүр дээр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хичээл заалгаж, дадлага хийлгэн сургалтад оролцогчдоос шалгалт авч судалгаанд ажиллах ажилтнуудыг сонгон шалгаруулж авсан болно.

Судалгаанд баг бүрийг нэг ахлагч, нэг хянагч ба засварлагч, 5 ярилцлага авагч бүгд 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх нийт 11 багийг зохион байгуулж ажиллуулав.

Мэдээллийг 2005 оны 11, 12 дугаар сард цуглуулсан. Энэ ажлын явц, чанарт ҮСГ, НҮБ–ын Хүүхдийн Сангийн ажилтан нар, судалгааны Удирдлагын Зөвлөлийн гишүүд хяналт тавин ажиллаж, гарсан ололт, дутагдлыг тухай бүр танилцуулж, шаардагдах арга хэмжээг авч ажилласан.

Мэдээлэл боловсруулалт

“Хүүхэд хөгжил 2005” судалгааны цуглуулсан мэдээллийг стандарт программ (CSPPro)–ыг ашиглан компьютерт оруулсан. Мэдээллийг компьютерт оруулах ажлыг 7 персональ компьютерт 2005 оны 12–р сараас эхлэн 2 сарын хугацаанд шивж оруулсан. Мэдээллийн чанарыг баталгаажуулахын тулд бүх мэдээллийг давтан шивж, үзүүлэлт хоорондын уялдааг шалгасан бөгөөд технологийн дарааллын дагуу боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн.


Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ SPSS–14 програм хангамж, НҮБ–ын ХС–гаас судалгаанд зориулан боловсруулсан стандарт синтакс болон үр дүнгийн хүснэгтийн загварыг ашиглалаа.

III

Судалгааны хамралт

Судалгааны түүвэрт сонгогдсон 6325 өрхөөс 6220 нь ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 98.3 хувь байв. Судалгаанд хамрагдсан өрхүүдэд эмэгтэйчүүдийн асуулгад хамрагдвал зохих 15–49 насны 8057 эмэгтэй бүртгэгдсэнээс 7459 эмэгтэй ганцаарчилсан ярилцлагад хамрагдаж, хамрагдалтын түвшин 92.6 хувь байлаа. Дээрх өрхүүдэд хүүхдийн асуулгад хамрагдвал зохих 5 хүртэлх насны 3568 хүүхэд бүртгэгдсэний 99.4 хувь буюу 3547 хүүхэд судалгаанд хамрагдсан байна (Зураг III.1).

Зураг III.1: Судалгаанд хамрагдсан өрх, 15–49 насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхдийн тоо, хамрагдалтын хувь, Монгол Улс, 2005 он



Судалгаанд хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдийн 91.0 хувь; 5 хүртэлх насны хүүхдийн 97.8 хувь нь ярилцлагад хамрагдсан байна (Хүснэгт НН.1).

Өрх, хүн амын байдал

Судалгаагаар 6220 өрхөд амьдарч буй 26713 хүний талаарх мэдээллийг цуглуулсан байна. Хамрагдсан өрхийн тоог Хүснэгт НН.3–т бүс нутгаар үзүүлэв. Судалгаанд хамрагдсан өрхийн 57.4 хувь буюу 3570 өрх нь хотын, 42.6 хувь буюу 2650 нь хөдөөгийн өрх байна. Хүн амын суурьшил, нягтралаас хамаарч түүвэрт сонгогдсон өрхийн 34.8 хувь нь Улаанбаатар хотынх байгаа нь бүс нутгийн дунд хамгийн их хувийн жин эзэлж, харин хамгийн бага буюу 8.1 хувийг Зүүн бүс эзэлж байна.


Өрхүүдийг ам бүлийн тоогоор авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт өрхийн 50.2 хувь нь 4–5 ам бүлтэй байна. Харин 2–3 ам бүлтэй өрх 30 хувийг, 6–7 ам бүлтэй өрх 15 хувийг, нэг ам бүлтэй өрх 1.2 хувийг, 8–аас дээш тооны ам бүлтэй өрх 3.5 хувийг тус тус эзэлж байна. Судалгаанд хамрагдсан өрхийн дүнгээс үзэхэд нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 4.3 байна. Нийт өрхийн 17.6 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна.

Судалгаанд 6220 өрхийн 26713 гишүүн хамрагдсанаас 47.9 хувь буюу 12790 нь эрэгтэй, 52.1 хувь буюу 13923 нь эмэгтэй байв.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 34 хувь нь 15 хүртэлх насны, 64 хувь нь 15–64 насны эмэгтэйчүүд байхад нийт эрэгтэйчүүдийн 38 хувийг 15 хүртэлх насны, 60 хувийг 15–64 насны эрэгтэйчүүд эзэлж байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн нас ахих тутам нийт хүн амд эзлэх хувийн жин буурч, 65–аас дээш насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд судалгаанд хамрагдагчдын дөнгөж 2–3 хувийг эзэлж байна. Нийт хүн амын 43 хувь

III. СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, ӨРХ ХҮН АМЫН БАЙДАЛ

Зураг III.2. Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүд, насны бүлгээр, хувиар, Монгол Улс, 2005 он



нь 17 хүртэлх насны, 57 хувь нь 18-аас дээш насны насанд хүрсэн иргэд байна. Хүйс, насны бүлгээр нарийвчлан авч үзвэл аль ч насны бүлэгт эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо, онцгой ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд харин 20-44 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс, 0-19 насны эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хамрагдсан байгаа нь ажиглагдаж байна. Судалгааны дүнгээс үзэхэд өрхүүдийн 88 хувь нь 18 хүртэлх насны нэгээс доошгүй хүүхэдтэй, 95 хувь нь 15-49 насны нэг болон түүнээс дээш тооны эмэгтэйтэй, 48 хувь нь 5 хүртэлх насны нэг хүүхэдтэй өрх байна.

Судалгаанд 15-49 насны нийт 7459 эмэгтэй хамрагдсан бөгөөд тэдний 17 хувь нь 15-19 насны, 16 хувь нь 20-24 насны, 18 хувь нь 25-29 насны эмэгтэйчүүд байв. Эмэгтэйчүүд нас ахих тутам тэдний эзлэх хувийн жин нь буурч, 45-49 насны эмэгтэйчүүд дөнгөж 9 хувийг л эзэлж байна (Зураг III.2).


Судалгаанд 15-49 насны нийт 7459 эмэгтэй хамрагдсан бөгөөд тэдний 17 хувь нь 15-19 насны, 16

Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь гэр бүлтэй буюу хамтран амьдрагчтай, 75 хувь нь хүүхэд төрүүлсэн байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 4 хувь нь боловсролгүй, 10 хувь нь бага, 26 хувь нь бүрэн бус дунд, 25 орчим хувь нь бүрэн дунд, 9 хувь нь мэргэжлийн анхан шатны, 26 хувь нь дипломын дээд болон түүнээс дээш боловсролтой байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо буурч, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо өсчээ.

Судалгаанд 5 хүртэлх насны нийт 3547 хүүхэд хамрагдлаа. Тав хүртэлх насны хүүхдийн тооны харьцааг тэдний хүйс, насны бүлэг, байршил болон эхийн боловсролын түвшингээр Хүснэгт НН.5-д харуулав.

Зураг III.3. Судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, хувиар, Монгол Улс, 2005 он



Судалгаанд хамрагдсан тав хүртэлх насны хүүхдүүдийн 52 хувь нь хөвгүүд, 48 хувь нь охид байв. Харин тав хүртэлх насны хүүхдийн эхчүүдийн 4 хувь нь боловсролгүй, 8 хувь нь бага, 25 хувь нь бүрэн бус дунд, 29 хувь нь бүрэн дунд боловсролтой, 33 хувь нь мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш боловсролтой байна.

III. СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, ӨРХ ХҮН АМЫН БАЙДАЛ

Мэдээллийн ангилал

Судалгааны үр дүнг улсын дундаж болон бүс нутаг, өрхийн байршил, хот хөдөөгөөр эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, өрхийн аж байдлын индексийн 5 тэнцүү бүлгээр гаргалаа.

Бүс нутаг: Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар

Байршил: Нийслэл хот, аймгийн төв, сумын төв, хөдөө гэж тус тус ангилж авч үзсэн.

Хот, хөдөө: Нийслэл хот, аймгийн төвийг “хот”, сумын төв, хөдөөг “хөдөө” хэмээн тооцсон.

Боловсролын түвшин: Эхийн боловсролыг боловсролгүй (бага боловсрол эзэмшээгүй), бага, бүрэн бус дунд, бүрэн дунд, мэргэжлийн анхан шатны, дипломын дээд ба түүнээс дээш боловсролтой гэсэн 6 түвшингээр авч үзсэн.

Аж байдлын индекс: Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхэд ашигласан өөр нэг чухал хүчин зүйл бол өрхийн аж байдал юм.

Өмнө нь уламжлалт аргаар өрхийн орлого, зарлагын мэдээллийг үндэслэн өрхийн эдийн засгийн байдлыг тодорхойлж байсан. Энэ аргаар мэдээлэл цуглуулахад цаг хугацаа их шаардах (өрхийн гишүүн бүрийн орлогыг эх үүсвэр тус бүрээр асуухад олон асуулт асуух шаардлагатай болдог) бөгөөд мэдээллийг дутуу цуглуулах (ярилцлага өгч байгаа хүн өрхийн бусад гишүүдийн орлого, зарлагын талаар тодорхой мэдэхгүй байх), өрхийн үйлдвэрлэл, тогтмол бус болон өндөр орлогыг тооцож оруулахад хүндрэл бэрхшээлтэй байдаг гэх зэрэг бэрхшээл тулгардаг.

Иймээс энэ судалгаанд өрхийн аж байдлыг хэмжих “Аж байдлын индекс” үзүүлэлтийг тооцож ашигласан. Аж байдлын индексийг тооцоход цөөн тооны, төвөгтэй бус асуулт шаардлагатай бөгөөд өөр зорилгоор асуусан асуулт (ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, сууцны төрөл, сууцны материал, цахилгаан гэрэлтэй эсэх г.м)-ыг авч ашиглах боломжтой юм.


Энэхүү судалгааны үр дүнг өрхийн аж байдлын индексийн 5 тэнцүү бүлгээр гаргасан бөгөөд сууцны төрөл, нөхцөл, ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан байдал, цахилгаан гэрэлтэй эсэх, өрхийн хэрэглээний эд зүйл (харилцаа холбооны болон тээврийн хэрэгсэл, гэр ахуйн цахилгаан бараа гэх мэт) байгаа эсэх гэсэн үзүүлэлтийг сонгон авч судалсан. Дээрх үзүүлэлтүүдийг ашиглан өрхүүдэд оноо ногдуулж оноогоор нь ядуугаас чинээлэг гэсэн зэргээр эрэмбэлсэн. Ингээд онооны эрэмбээр нийт өрхийг 5 тэнцүү бүлэгт хувааж ядуу (I), ядуувтар (II), дунд зэрэг (III), дундаас дээш (IV), чинээлэг (V) гэж ангилан гаргалаа.

IV

Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн нас баралтыг бууруулах нь Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ), Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалын тэргүүн зорилтуудын нэг юм. Тухайлбал, Мянганы хөгжлийн зорилтод 2015 гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 оны түвшингээс гуравны хоёроор бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хянах, үнэлэх нэн асуудал чухал бөгөөд төвөгтэй гэдгийг ч тэмдэглэх нь зүйтэй. Хүүхдийн эндэгдлийг хэмжих нь хялбар мэт санагдах боловч “Танай өрхөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд нас барсан хүн бий юу?” гэсэн энгийн асуултаар тодорхойлох нь учир дутагдалтай. Харин төрөлтийн түүхийг судалсны үндсэн дээр шууд аргуудын тусламжтай эндэгдлийн үзүүлэлтүүдийг тооцох нь өртөг өндөр, цаг хугацаа ихээхэн шаарддаг улмаар гүнзгийрүүлсэн сургалт, нарийн мэргэжлийн чадвар шаарддаг. Энэхүү тооцоог хийх өөр нэг боломж нь шууд бус аргуудыг ашиглах явдал бөгөөд эдгээр аргуудаар үзүүлэлтүүдийг нилээд нарийвчлалтай тооцох боломжтой байдгийн зэрэгцээ бусад эх үүсвэрүүдтэй харьцуулах боломжийг мөн олгодог байна. Шууд бус аргуудыг ашиглах нь судалгаанд хариулагч буруу ташаа мэдээлэл өгөх, тодорхойлолт, ойлголтын зөрүү гарах зэрэг эрсдлээс хамгаалах төдийгүй асуулга авах өндөр чадавхи шаарддаггүй онцлогтой.

Нялхсын эндэгдлийн түвшин нь нэг нас хүрэлгүй нас барах магадлалыг, харин тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нь таван нас хүрэлгүй нас барах магадлалыг

Зураг IV.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, сонгосон үзүүлэлтээр, Монгол улс, 2005 он



илэрхийлдэг үзүүлэлт юм. Тус ХХС 2005–д нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тооцохдоо Брассын шууд бус аргыг хэрэглэсэн болно (НҮБ, 1983; 1990а; 1990б). Энд 15–49 насны эмэгтэйчүүдийн таван насны бүлгээр өгөгдсөн төрүүлсэн хүүхдийн дундаж тоо болон нийт төрүүлсэн хүүхдийн тоонд эндсэн хүүхдийн эзлэх хувийн жин зэрэг мэдээллийг ашигласан. Тооцооны энэхүү аргань нас баралтын хэв маяг насжилтын тодорхой загварыг дагана гэсэн төсөөлөлтэйгээр дээрх мэдээллийг хүүхдийн эндэх эрсдэл болон энэхүү эрсдэлд өртөх хугацаа аль алиныг нь нас барах магадлал болгон хувиргадаг юм. Монгол улсын хүн амын

IV. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

нас баралтын талаарх өмнөх үеийн тоо мэдээллийг үндэслэн насжилтын хүснэгтийн Баруун загварыг ашиглахаар сонгосон болно.

Хүснэгт СМ.1-д хүүхдийн эндэгдлийг зарим сонгосон үзүүлэлтээр харуулсан бөгөөд Хүснэгт СМ.2-т эдгээр үзүүлэлтүүдийг тооцоход ашигласан тоо, мэдээллийг харуулав. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 40, харин тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 51 байна. Эдгээр үзүүлэлтийг тооцохдоо 20–29 насны эмэгтэйчүүдийн мэдээлэлд үндэслэсэн бөгөөд 2002 оны сүүл үед хамаарна. Нялхас, хүүхдийн нас баралт хүйсээр ялгаатай байгаа үр дүн гарч байна. Тухайлбал, нялхас болон тав хүртэлх насны эрэгтэй хүүхдүүдийн нас барах эрсдэл охидын нас барах эрсдлээс ойролцоогоор 20–25 хувиар өндөр байна.

Нялхас, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хот, хөдөө, эхийн боловсролын түвшин, өрхийн аж байдлаар авч үзэхэд багагүй ялгаатай байна (Зураг IV.1).

Хүүхдийн эндэгдэл хөдөөд хоттой харьцуулахад 2 дахин өндөр байна.


Нялхсын (5 хүртэлх насны хүүхдийн) эндэгдлийн түвшинг эхийн боловсролын түвшингээр авч үзвэл боловсролгүй болон бага боловсролтой эхчүүдийн хүүхдийн хувьд хамгийн өндөр 1000 амьд төрөлтөд 66 (90) ногдож байхад дээд боловсролтой эхчүүдийн хүүхдийн хувьд 18 (22) байна.

Аж байдлаар чинээлэг 40 хувьд багтах өрхийн нялхас, хүүхдийн эндэх магадлал 25(30) байгаа нь улсын дунджаас нилээд доогуур байна.

Нялхсын (5 хүртэлх насны хүүхдийн) эндэгдлийн түвшинг өрхийн аж байдлаар авч үзэхэд ядуу 60 хувьд багтах өрхүүдийн хувьд 46 (60) байгаа нь чинээлэг өрхүүдтэй харьцуулахад даруй 2 дахин өндөр байна.

Зураг IV.2-т тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1980-аад оны дундаас хойшхи 20 жилд гарсан өөрчлөлтийн хандлагыг ялгаатай эх үүсвэрүүдээр харуулахыг зорьсон. ХХС 2005 болон бусад эх үүсвэрээс гарсан үр дүнгээс харахад тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 20 жилийн хугацаанд буурсаар иржээ. ХХС 2005-ын үр дүнгээр гарсан нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын түвшинг Эрүүл мэндийн бүртгэлийн үр

Зураг IV.2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, эх үүсвэрээр, Монгол Улс, 1984-2005 он



дүнтэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл 10–20-иор өндөр байна. Гэхдээ 2000, 2005 онуудад хийгдсэн ХХС-ны үр дүн болон 1998, 2003 оны НҮЭМС-ны дүн өөр хоорондоо харьцангуй ойролцоо байгааг тэмдэглэх нь зүйтэй (Зураг IV.2).

Хэдийгээр эрүүл мэндийн бүртгэлд үндэслэсэн тооцоог харахад буурч байгаа хандлага байгаа боловч ХХС 2005-ын үр дүнгээр гарсан нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын түвшин харьцангуй өндөр байгаа зарим нэг шалтгааны талаар энд авч үзье.

1. Албан ёсны бүртгэлийн мэдээтэй харьцуулсан байдал ба нярайн эндэгдлийн дутуу бүртгэл

Монгол Улсын хувьд судалгааны болон бүртгэлийн мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгаа нь шилжилтийн эдийн засагтай бусад орнуудтай төстэй байгаа юм. Эдгээр орнуудад хүүхдийн эндэгдлийн талаарх судалгааны дүн болон албан ёсны бүртгэлийн мэдээлэл нь хоорондоо нэлээд зөрүүтэй буюу судалгааны мэдээлэл нь албан ёсны тоо мэдээнээс хэд дахин өндөр байх тохиолдол илэрдэг (Алешиа, Редмонд, 2003).

Шилжилтийн эдийн засагтай орнуудад ялгаатэй эх үүсвэрээс гарсан мэдээлэл яагаад зөрүүтэй байгаа шалтгааныг судалсан судлаачид бүртгэлийн мэдээлэлд нярайн эндэгдэл дутуу бүртгэгддэг болохыг тогтоосон байна. Үүнд:

1. Амьд төрөлтийг тодорхойлох тодорхойлолт зөрүүтэй байх
2. Жирэмслэлтийг эрүүл мэндийн байгууллагуудад дутуу бүртгэх
3. Хүүхдийн төрөлт болон нялхсын нас баралтыг эцэг, эхчүүд бүртгүүлэхгүй байх зэрэг болно.

Шигтгээ 2. Хүүхдийн эндэгдлийн ангилал

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (<5 нас)			
Нялхсын эндэгдэл (<1нас)			
Нярайн эндэгдэл (0-28 хоног)		Нярайн дараах эндэгдэл (29-365 өдөр)	Хүүхдийн эндэгдэл (1-4 нас)
Нярайн эрт эндэгдэл (0-6 өдөр)	Нярайн хожуу эндэгдэл (7 – 28 өдөр)		

Амьд төрөлтийн тодорхойлолт бол нялхсын эндэгдлийг тооцох гол ойлголт юм. Гэтэл жирэмслэлт үр дүн муутайгаар төгсөж, хүүхэд амьд төрмөгцөө нас барсан тохиолдлыг нялхсын эндэгдэлд оруулж тооцдоггүй нь дээрх ойлголтын ач холбогдлыг бууруулдаг байна.

Монгол улсад энэ байдал шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын адил нилээд тохиолддог. Ер нь Монгол улсад 2003 он хүртэл социалист системийн орнуудад хэрэглэж байсан тодорхойлолтыг ашиглаж байсан бөгөөд энэ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын амьд төрөлтийн тодорхойлолтоос нилээд явцуу юм. Дээрх тодорхойлолтоор нэгдүгээрт, хүүхэд төрөөд зөвхөн амьсгалсан бол амьд төрөлт (өөр ямар нэгэн шинж тэмдэг гаргаагүй) гэж үздэг. Хэрэв хүүхэд нас барахаасаа өмнө ямар нэгэн шинж тэмдэг үзүүлсэн тохиолдолд үүнийг нярайн эрт эндэгдэл гэхээсээ илүү амьгүй төрөлт гэж бүртгэдэг.

Нялхсын олонхи эндэгдэл дөнгөж төрсний дараа тохиолддог учир тодорхойлолтуудын ялгаатай байдал нялхсын эндэгдлийн бүртгэлд ихээхэн нөлөөлдөг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа (1998, 2003 он)-нуудаас харахад (төрөлтийн түүх, түүн дээр үндэслэсэн хүүхдийн эндэгдлийн талаарх гүнзгийрүүлсэн шинжилгээ) Монголд нялхсын эндэгдлийн бараг тэн хагас нь (100 эндэгдэл тутмын 45) төрөөд эхний 7 хоногийн дотор эндсэн байна². Нярайн эндэгдлийн ихэнх нь (75 хувь) эхний 7 хоногт, ихэвчлэн хэдхэн цагийн дотор эсвэл хэдхэн өдрийн хугацаанд тохиолдсон байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн гуравны нэг буюу 32 хувь нь төрөөд долоо хоногийн дотор тохиолджээ³.

²НҮЭМС-ны тайлан, УСГ, НҮБХАС, 2004

³НҮЭМС, Нялхас, хүүхдийн нас баралтад нөлөөлж байгаа хүчин зүйлс, УСГ, НҮБХАС, 2001

IV. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Нярайн эндэгдлийг дутуу бүртгэж байгаа өөр нэг шалтгаан нь эндэгдлийг санаатайгаар ихэсгэх эсвэл мэдлэг дутуугаас санамсаргүйгээр дутуу бүртгэх явдал юм. Хуучин тодорхойлолтоор жирэмслэлт, биеийн жин, урт гэсэн хэд хэдэн шалгуураар амьд төрөлтийг тооцдог байсан учир тооцоог анхааралтай хийх шаардлагатай байсан. Эрүүл мэндийн ажилтнууд эрүүл мэндийн үндэсний зорилтуудыг хангахын тулд харьяалж байсан хүүхдийн нас баралтыг дутуу бүртгэх, нярайн эрт эндэгдлийг амьгүй төрөлт хэмээн бүртгэх явдал гардаг байна. Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээ сайн байлгахын тулд дээрхтэй төстэй хандлага зарим аймаг, сумдад ч тохиолдож болох талтай.

Нярайн эндэгдэл дутуу бүртгэгдэх өөр нэгэн шалтгаан нь хүүхдийнхээ төрөлт, нас баралтыг бүртгүүлдэггүй эцэг, эхийн хандлага гэж тодорхойлж болно. Хэдийгээр Монгол Улсад нэгээс дээш насны хүүхдийн бүртгэл нилээд сайн гэх хэдий ч нэг хүртэлх насны хүүхдийн хувьд бүртгэл тэр хэмжээнд хүрдэггүй байна. “Хүүхэд хөгжил 2005” судалгааны дүнгээс харахад нэг хүртэлх насны хүүхдийн 93 хувь нь бүртгүүлсэн байсан бол энэ хувь хүүхдийн “сар” бага байх тутам дээрх хувь хэмжээнээс доогуур байна.

Хүүхдийг төрснөөс хойш нэг сарын дотор бүртгүүлэхээр хуульд заасан байдаг хэдий ч цаг хугацаанд нь бүртгүүлэх явдал дутагдалтай хэвээр байна.

Нярайн эндэгдлийг дутуу бүртгэх нь нийт хүүхдийн эндэгдлийн дотор нярайн эрт эндэгдлийн эзлэх хувь зонхилж, нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн зөрүүг улам ихэсгэхэд хүргэдэг.

2. НҮЭМС-тай харьцуулсан байдал

НҮЭМС (2003)-аар шууд аргаар тооцсон 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 29.5, шууд бус⁴ аргаар тооцсон эндэгдэл 34 байсан бол ХХС 2005-ын үр дүнгээр энэ үзүүлэлт 40 байна. Шууд бус аргад үндэслэсэн 2003 оны НҮЭМС-ны нялхсын эндэгдлийн түвшинг 15–19 насны залуу эмэгтэйчүүдийн төрөлт, хүүхдийн нас баралтын түвшинд үндэслэн тооцсоны зэрэгцээ “Ойрхи Дорнод” загварыг сонгон ашигласан.

НҮБ-ын Хүүхдийн Сангаас боловсруулсан ХХС 2005-ын ерөнхий зөвлөмжид 20–35 насныхны мэдээллийг ашиглахыг санал болгосон хэдий ч Монголын хувьд төрөлтийн огцом бууралт явагдсан учир 20–29 насны эмэгтэйчүүдийн төрөлт, хүүхдийн нас баралтын түвшинд үндэслэн тооцохыг илүү тохиромжтой гэж үзсэн. Ийнхүү 2003 оны НҮЭМС (15–19 нас) болон ХХС 2005 (20–29 нас) –д ашигласан эмэгтэйчүүдийн насны бүлгийн ялгаатай байдлаар энэ 2 судалгааны нялхсын нас баралтын ялгааг тайлбарлаж болох юм.

⁴Шууд бус арга хэрэглэсэн үед нас баралтын түвшин шууд арга хэрэглэснээс өндөр гарах нь нэлээд ховор байдаг. Шууд болон шууд бус аргад хэрэглэж буй таамаглалууд ялгаатай учир үр дүнг шууд харьцуулах боломжгүй. Шууд арга нь дутуу болон бүртгэгдээгүй эндэгдлээс ихээхэн хамаардаг бол шууд бус арга нь төрөлтийн огцом бууралтын нөлөөг тооцоогүйн улмаас хүүхдийн эндэгдлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг.

V

Хоол, тэжээлийн байдал



Хүүхдийн хоол, тэжээлийн байдал нь тэдний эрүүл мэндийн толь юм. Хүүхэд хоол хүнсээр бүрэн хангагдвал өвчлөлд тэр бүр өртөгдөхгүйн дээр томчуудын асаргаа сувилгаа сайн байж чадвал тэд эрүүл энх өсч бойжих бололцоотой болдог.

Хоол тэжээлийн дутал нь дэлхий дээрх хүүхдийн нас баралтын талаас илүү хувьд нөлөөлсөн нэг гол шалтгаан юм. Хоол тэжээлийн дутлын шалтгаанаар нас барсан дөрвөн хүүхдийн гурав нь хөнгөн болон дунд хэлбэрийн тураалтай байгаа нь дээрхийн тод жишээ юм.

Мянганы хөгжлийн зорилт бол 1990–2015 онд өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийн тоог хоёр дахин бууруулах, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалын зорилт нь тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдож буй хоол тэжээлийн дутлын тархалтыг наад зах нь гуравны нэгээр бууруулах (2000–2010 оны хооронд), ялангуяа хоёр хүртэлх насны хүүхдэд илүү анхаарал хандуулах явдал юм. Хоол тэжээлийн дутлын тархалтыг бууруулах нь хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилтыг хангах нэг гол түлхэц болох юм.

Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжилтийн хэвийн байдлыг үнэлэх хүүхдийн өндөр, жингийн тархалтын стандарт гэж байдаг. Хүүхдийн хоол тэжээлийн дутлыг үнэлэхдээ стандарттай харьцуулж гаргадаг. Энэхүү тайланд хэрэглэгдсэн стандарт бол НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-аас зөвлөмж болгосон ДЭМБ/Америкийн Эрүүл Мэндийн Статистикийн Үндэсний Төвийн боловсруулсан стандарт юм. Хоол, тэжээлийн байдлын гурван шалгуур үзүүлэлт тус бүр стандарт голч утгаас хэлбэлзэх стандарт хазайлтаар (z утгууд) тодорхойлогдоно.

1. Тухайн насанд байвал зохих биеийн жин бол хоол тэжээлийн хурц ба архаг (урт хугацааны) дутлыг хэмжих үзүүлэлт юм. Тухайн насны хүүхдийн биеийн жин нь стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал *дунд зэргийн*, 3 стандарт хазайлтаар доогуур байвал *тураалын хүнд хэлбэр* гэж үздэг.
2. Тухайн насанд байвал зохих биеийн өндөр бол өсөлтийн хэмжүүр юм. Тухайн насны хүүхдийн өндрийн хэмжээ нь стандарт өндрийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал *дунд хэлбэрийн*, 3 стандарт хазайлтаар доогуур байвал *өсөлтийн хоцролтын хүнд хэлбэр* гэж тооцдог.
3. Тухайн өндөрт байвал зохих биеийн жин нь стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал *дунд хэлбэрийн*; 3 стандарт хазайлтаар доогуур байвал *туранхайн хүнд хэлбэр* гэж үздэг. Туранхай байна гэдэг нь ихэвчлэн хоол, тэжээлийн дутлын үр дүн байдаг. Энэ үзүүлэлт нь хоол хүнсний хангамж, өвчлөлийн тархалтын өөрчлөлттэй холбоотой улирлын хэлбэлзлийг харуулж болох юм.


ХХС 2005–д тав хүртэлх настай хүүхдүүдийн өндөр, биеийн жинг НҮБ-ын Хүүхдийн сангаас зөвлөмж болгосон хүүхдийн өндөр, жинг хэмжих багажийг ашиглан хэмжсэн ба үр дүнг энэхүү хэмжилтэд үндэслэн гаргалаа.

V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

Хүснэгт NU.1-д судалгааны мэдээлэл цуглуулах явцад антронометр багажаар хэмжсэн хэмжилтийн үр дүнг дээрх шалгуур үзүүлэлт тус бүрээр судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувийн жингээр харуулав. Мөн энэ хүснэгтэд тухайн хүүхдийн биеийн өндөрт байвал зохих жин нь стандарт хүн амын голчоос 2 болон түүнээс дээш стандарт хазайлтаар дээгүүр байгаа илүүдэл жинтэй хүүхдийн хувийн жинг оруулсан.

Биеийн жин болон өндөр нь хэмжигдээгүй, хэмжилтэд хамрагдсан ч хэмжүүрийн утга боломжит утгаас хэт хэлбэлзэлтэй хүүхдүүдийг Хүснэгт NU.1-д үзүүлсэн мэдээлэлд оруулаагүй болно.

Зураг V.1. Тураал, өсөлтийн хоцролттой болон туранхай хүүхдийн эзлэх хувь, Монгол Улс, 2005 он




Монгол улсын таваас доош насныхүүхдүүдийн борчимхувь нь дунд хэлбэрийн тураалтай, бараг таван хүүхэд тутмын нэг (21 хувь) нь дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой буюу тухайн насандаа байвал зохих өндөрт хүрэхгүй хэт намхан, үүнээс 6 хувь нь хүнд хэлбэрийн өсөлтийн хоцролттой байна (Хүснэгт NU.1). Харин 5 хүртэлх насны хүүхдүүдийн 2 хувь нь дунд хэлбэрийн буюу биеийнхээ өндөрт байвал зохих жингээс бага жинтэй буюу хэтэрхий туранхай байна.

Баруун бүсийн хүүхдүүдийг бусад бүсийн хүүхдүүдтэй харьцуулахад тураал болон

өсөлтийн хоцролт ихтэй байна. Харин Улаанбаатарт туранхай хүүхдүүдийн эзлэх хувийн жин хамгийн өндөр байна. Хөвгүүд бага зэрэг өсөлтийн хоцролттой байхад охидын хувьд тураал болон туранхай байх явдал илүү байна. Тураалтай болон өсөлтийн хоцролттой хүүхдийг эхийн боловсролын түвшингээр авч үзвэл эхийн боловсрол дээшлэх тутам тураал, өсөлтийн хоцролттой хүүхдийн хувь багасч байна.

Зураг V.2. Тураал, өсөлтийн хоцролттой болон туранхай хүүхдийн эзлэх хувь, хүүхдийн насаар, Монгол Улс, 2005 он



Хоол тэжээлийн дутлын байдлыг хүүхдийн насаар зураг V.2-т харуулав. Ерөнхийдөө, 6 сараас доош сартай буюу хөхөөр хооллож буй хүүхдүүдийн хувьд бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад тураал, өсөлт хоцролт, туранхай байх явдал харьцангуй бага байна. Дунд хэлбэрийн тураал 24-35 сартай хүүхдүүдийн дунд түгээмэл байгаа нь ажиглагдлаа. Гэхдээ 48-59 сартай хүүхдүүдийн хувьд хүнд хэлбэрийн тураал илүү байна. 12-23 сартай хүүхдүүд өсөлтийн хоцролтын түвшингээрээ хамгийн өндөр хувь (26 хувь)-ийг эзэлж байна. Нөгөө талаас, хүнд хэлбэрийн өсөлт хоцролт 36-47 сартай хүүхдүүдийн (9 хувь) дунд илүү түгээмэл байгаа нь

харагдлаа. Хүүхдийн хоол, тэжээлийн дутлын байдлыг өрхийн аж байдлаар авч үзэхэд ядуу өрхийн хүүхдүүд тураал, өсөлтийн хоцролтод өртөх нь чинээлэг өрхийн хүүхдүүдээс 2 дахин их байна (Хүснэгт NU.1).

Зураг V.3. Тураал болон өсөлтийн хоцролтод хүүхдийн эзлэх хувь, хүүхдийн тоогоор Монгол Улс, 2005 он



Хүүхдийн хоол, тэжээлийн дутлын байдалд нөлөөлж байгаа өөр нэг хүчин зүйл бол өрхөд байгаа бага насны хүүхдийн тоо юм.

Өрхөд байгаа таваас доош насны хүүхдүүдийн тоо болон тураал, өсөлтийн хоцролтын тархалтын хооронд эерэг хамаарал байгаа нь Зураг V.3-аас харагдаж байна. Өрхөд амьдарч буй хүүхдийн тоо өсөх тусам өсөлтийн хоцролт болон тураалтай хүүхдийн хувийн жин нэмэгдэж байна. Тухайлбал, тураал 3 орчим пунктээр, өсөлтийн хоцролт 20 орчим пунктээр өсчээ.

Судалгааны дүнгээр 10 хүүхэд тутмын нэг нь илүү жинтэй байгаа нь харагдлаа. Ялангуяа 6 хүртэлх сартай хүүхдийн 25 хувь буюу дөрвөн хүүхдийн нэг нь илүүдэл жинтэй байсан бөгөөд хүүхдийн хөдөлгөөн нэмэгдэж эхлэх үеэс эрс буурч, 4–5 насны хүүхдийн хувьд 5 хувь болж байна.

Чинээлэг өрхийн тав хүртэлх насны хүүхдийн 14 хувь нь, мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш боловсролтой эхчүүдийн хүүхдийн 11–13 хувь нь жин ихтэй байна.

Бүс нутгаар авч үзвэл Улаанбаатарын хүүхдийн 15 хувь, Зүүн бүсийн хүүхдийн 14 хувь нь илүүдэл жинтэй байгаа нь бусад бүсүүд (6–9 хувь)-тэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Эхийн сүүгээр хооллолт

Хүүхдийг эхийн сүүгээр хооллосноор тэднийг халдвараас хамгаалан, шим тэжээлт бодисуудаар хангах боломж бүрддэг. Гэсэн хэдий ч олон эхчүүд хэт эрт хүүхдээ эхийн сүүгээр хооллохоо зогсоож байгаа нь хүүхдийн хоол эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүнээр солигдож, хүүхдийн өсөлтийн явц буурч, бичил тэжээлийн бодисуудын дуталд ороход нөлөөлж байна.

Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц тунхаглалд хүүхдийг эхний зургаан сард нь дан эхийн сүүгээр хооллож, аюулгүй, тохирсон, зохистой найрлага бүхий нэмэгдэл хоолонд оруулж, хоёр нас хүртэл нь үргэлжлүүлэн эхийн сүүгээр хооллоно гэж заасан байдаг.

ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сан хүүхдийг эхийн сүүгээр хооллох талаар дараах зөвлөмжийг өгч байгаа юм. Үүнд:

- ✦ Хүүхдийг төрсний дараах 1 цагийн дотор амлуулах
- ✦ Төрсний дараах эхний зургаан сард нь зөвхөн эхийн сүүгээр хооллох
- ✦ 6 сартайгаас нь аюулгүй, тохирсон, зохистой нэмэгдэл хоол өгч эхлэх
- ✦ Хүүхдийг хоёр ба түүнээс дээш настай болтол нь нэмэгдэл хоолны зэрэгцээ үргэлжлүүлэн эхийн сүүгээр хооллох
- ✦ Нэмэгдэл хоолыг өдөрт тодорхой давтамжтайгаар: 6–8 сартай хүүхдэд өдөрт 2 удаа, 9–11 сартай хүүхдэд өдөрт 3 удаа өгч байх


V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

Түүнчлэн хүүхдийг төрөнгүүт нэг цагийн дотор ангир уургаар амлуулахыг зөвлөдөг.

Хүүхэд хооллох дадлыг дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:

- ✘ Дан эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн хувь (<6 ба <4 сартайд нь)
- ✘ Хугацаанд нь нэмэгдэл хоолонд оруулсан хувь (6–9 сартайд нь)
- ✘ Үргэлжлүүлэн эхийн сүүгээр хооллож байгаа хувь (12–15 ба 20–23 сартайд нь)
- ✘ Хугацаанд нь ангир уургаар амлуулсан хувь (төрснөөс хойш 1 цагийн дотор)
- ✘ Нэмэгдэл хоолны давтамж (6–11 сартайд нь)
- ✘ Нялхсын зохистой хооллолтын байдал (0–11 сартайд нь)

Зураг V.4. Төрсний дараах 1 цаг ба 1 өдрийн дотор хөхөө амлуулсан эхчүүд, бүс нутгаар, хот, хөдөөгөөр, Монгол Улс, 2005 он



Монгол Улсад “Хүүхдийг эхийн сүүгээр хооллох” бодлогыг хэрэгжүүлж байгаа боловч сүүлийн жилүүдэд эхийн сүүг орлуулагч бүтээгдэхүүний хэрэглээ, борлуулалт, сурталчилгаа ихэссэнээс эхийн сүүгээр хооллолтын үзүүлэлт буурч байна. “Хүн амын хоол, тэжээлийн байдал” үндэсний 2-р судалгаа (1999 он)-гаар төрсний дараах 30 минутын дотор ангир уургаа амалсан хүүхдийн хувь 93.4 хувь байсан бол 2004 онд явуулсан “Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол, тэжээлийн байдал” үндэсний 3-р судалгаагаар энэ үзүүлэлт 83.5 хувь болсон байна.

Сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эхчүүдээс хүүхдээ амлуулсан хугацааг 1-рт төрсний дараах 1 цагийн дотор,

2-рт нэг өдрийн дотор гэж ангилан Зураг V.4-д харуулав.

Зургаас харахад сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 78 хувь нь төрсний дараах 1 цагт, 91 хувь нь 1 хоногийн дотор хөхөө амлуулжээ. Энэ үзүүлэлт хөдөөд 81 хувь ба 94 хувь, хотод 75 хувь ба 89 хувь байна.

Бүс нутгаар авч үзвэл Улаанбаатар хот (72 хувь ба 89 хувь), Баруун бүсийн аймгуудын үзүүлэлтийг (74 хувь ба 94 хувь), Хангай (85 хувь ба 93 хувь), Төв (83 хувь ба 92 хувь) болон Зүүн бүсийн (78 хувь ба 90 хувь) аймгуудынхтай харьцуулахад бага зэрэг доогуур байна.

Монгол Улсын Засгийн Газар 1992 оноос хойш хүүхдийг 4 сар хүртэл нь дан эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлж байсан бөгөөд 2000 оноос эхлэн 6 сар хүртэл нь дан эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлж байгаа юм. Судалгаанд хамрагдсан 0–5 сартай хүүхдүүдийн дан эхийн сүүгээр хооллолтыг авч үзэхэд 57 хувь, энэ үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод 55 хувь байхад хөдөөд арай өндөр 60 хувь байна.

Хүснэгт NU3-д эхийн сүүгээр хооллолтын түвшинг сүүлийн 24 цагийн дотор хүүхдийн хэрэглэсэн хүнс, хоол болон шингэний талаар эх/асрамжлагчаас авсан ярилцлага дээр үндэслэн харуулав. Дан эхийн сүүгээр хооллолтыг гаргахдаа хүүхэд зөвхөн эхийн сүүгээр хооллодог, аминдэм болон бичил тэжээлийн бодисуудыг нэмэлтээр хэрэглэсэн, эм уусан гэсэн хариултыг үндэслэсэн болно.


V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

Энэ хүснэгтэд эхний 6 сарын турш дан эхийн сүүгээр хооллолт (0–3 сартайд болон 0–5 сартайд), 6–9 сартайд нь нэмэгдэл хоолонд оруулсан байдал, 12–15 сартай болон 20–23 сартай хүүхдийг эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллосон байдлыг тус тус харуулав.

6–9 сартай хүүхдүүдийн 57 хувь нь эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоол хэрэглэж байна. Түүнчлэн 12–15 сартай хүүхдүүдийн 82 хувь, 20–23 сартай хүүхдүүдийн 65 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байна.

Хүүхдээ эхийн сүүгээр дагнан хооллож байгаа байдлыг эхийн боловсролын түвшингээр авч үзвэл боловсролгүй болон бага боловсролтой (64%, 73%) эхчүүдтэй харьцуулахад мэргэжлийн анхан шатны болон дээд боловсролтой (53%, 51%) эхчүүд хүүхдээ 6 сар хүртэл нь дан эхийн сүүгээр хооллох явдал бага байна.

Зураг V.5. Нэг хүртэлх насны хөхүүл хүүхдийн хооллолт, сафар, Монгол Улс, 2005 он



Нэг хүртэлх насны хүүхдийн хооллолтын хэлбэрийг зөвхөн хөхөө хөхөж буй хүүхдийн дүнгээр авч үзлээ (Зураг V.5).

Зураг V.5-аас харахад 0–1 сартай хүүхдийн 3.3 хувь нь эхийн сүүтэй хамт ус, 6.6 хувь нь эхийн сүүтэй хамт бусад шингэнийг хэрэглэж байгаа нь эцэг, эх болон асрамжлагчийн хүүхдээ хооллох мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлт 2–3 сартай болон 4–5 сартайд нэмэгдэж байна.

Хүснэгт NU.4-т 12 хүртэлх сартай хүүхдийн зохистой хооллолтын байдлыг харууллаа. Нэмэгдэл хоолны нэр төрөл, хэмжээг хүүхдийн насанд тохируулж сонгон өгөх ёстой байдаг. Тухайлбал, 0–5 сартай хүүхдэд тохирсон хоол нь дан эхийн сүү юм. Харин 6–8 сартай хүүхдэд эхийн сүүнээс гадна нэмэгдэл хоолыг өдөрт доод тал нь 2 удаа, 9–11 сартай хүүхдэд эхийн сүүтэй хамт нэмэгдэл хоолыг өдөрт доод тал нь 3 удаа авч байгааг хангалттай давтамжтайгаар хооллож байна гэж үздэг.

Хүснэгт NU.4-өөс 12 хүртэлх настай хүүхдийн хооллолтын байдлыг насны бүлгээр авч үзвэл 0–5 сартай хүүхдүүдийн 57 хувь нь эхийн сүүгээр дагнан хооллож, 6–8 сартай хүүхдүүдийн 31 хувь нь сүүлийн 24 цагийн дотор эхийн сүүгээр дагнан хооллохын зэрэгцээ нэмэгдэл хоолыг доод тал нь 2 удаа, 9–11 сартай хүүхдүүдийн 12 хувь нь мөн хугацаанд эхийн сүүгээр хооллохын зэрэгцээ өдөрт доод тал нь 3 удаа нэмэгдэл хоол авсан байна. Эдгээр үр дүнг үндэслэн зохистой хооллож байгаа хүүхдийн эзлэх хувийг тооцоход энэ үзүүлэлт 6–11 сартай хүүхдүүдийн хувьд 22 хувь, 0–11 сартай хүүхдүүдийн хувьд 40 хувь байна. Хүүхдийн зохистой хооллолтыг сонгосон үзүүлэлтээр авч үзэхэд бараг ялгаагүй байна.

Иоджуулсан давсны хэрэглээ

Дэлхий дахинд иод дутлын эмгэг (ИДЭ) нь хүүхдийн бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлдөг өвчлөлд тэргүүлэх байранд байна. Иод дутлын эмгэгийн хамгийн хүнд хэлбэр нь кретинизм буюу одойрох шинж тэмдэг юм. Жирэмсэн эмэгтэйчүүдэд иод дутвал ураг дутуу болон амьгүй төрөх, үр зулбах хүндрэлийг нэмэгдүүлнэ. Иод дутлын үед бамбай булчирхай томрох нийтлэг шинж тэмдэг илрэх бөгөөд хүүхдэд оюун ухааны хөгжил саатах, сурлагаар хоцрох, сэтгэн бодох чадвар муудах, хөдөлмөрлөх чадвар буурах зэрэг хэлбэрээр илэрдэг. Иймээс 2005 он гэхэд дэлхий нийтээрээ иод дутлын эмгэгийг устгах

V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

зорилт тавьсан. Энэхүү зорилтын хэрэгжилтийг иоджуулсан давс (давсан дах иодын хэмжээ >15 ppm) хэрэглэдэг өрхийн эзлэх хувь гэсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг.

Иодын дутлын эмгэгээс сэргийлэх хамгийн хямд, найдвартай, боломжит арга нь иоджуулсан давс хэрэглэх гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн. Монгол Улс 1995 оноос хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэж эхэлсэн. Монгол Улсын Засгийн газраас 1996 онд “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөр, 2002 онд “Иод дутлын эмгэгтэй тэмцэх” Үндэсний шинэчилсэн хөтөлбөр, 2003 онд “Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай” Монгол Улсын хууль батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд 2005 оны 6 сард Мэргэжлийн хяналт эрхэлсэн сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавих журам”, “Иоджуулсан давсны чанар, аюулгүй байдалд хяналт тавих, дээж авах заавар”, “Хүнсний давсанд иоджуулалт хийх аргачилсан заавар” болон бусад стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн иоджуулсан давсны хэрэглээг тодорхойлохдоо хурдавчилсан шалгуур ашигласан. Тухайн өрхийн давснаас бага зэргийг таслан авч шалгуур уусмалаас дусааж үзэхэд давсны өнгө хувирч хөх туяатай болж буй эсэхээр нь уг давсыг “иоджуулсан”, “иоджуулаагүй” хэмээн үнэлгээ өгсөн болно. Иодын нэгдлүүдээс хамгийн тогтвортой нь Калий Иодат бөгөөд ДЭМБ-аас хүнсэнд хэрэглэх давсны иодын хэмжээг 15 ppm-ээс багагүй байхаар зөвлөсөн. Нэг тонн давсанд нэг грамм иод байх нэгжийг саяны нэг буюу ppm гэсэн нэгжээр илэрхийлдэг.

Зураг V.6. Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь, бүс нутгаар, хот, хөдөөгөөр, Монгол Улс, 2005 он



Судалгаанд хамрагдсан айл өрхийн 98 хувь нь давстай байв. Зураг V.6-аас харахад Монгол Улсын хэмжээнд нийт өрхийн 83 хувь нь иоджуулсан давс хэрэглэж байна.

Гэхдээ Хүснэгт NU.5-аас харахад айл өрхийн иоджуулсан давсны хэрэглээний түвшин бүс нутаг, өрхийн байршил, өрхийн аж байдлаар харилцан адилгүй байна.

Бүсээр авч үзвэл Баруун бүсэд хамгийн бага буюу нийт өрхийн 58 хувь, Улаанбаатарт хамгийн их, нийт өрхийн 97 хувь нь иоджуулсан давс хэрэглэж байна. Баруун бүсэд иоджуулсан давсны хэрэглээ доогуур байгааг байгалийн давсны орд элбэг байгаатай холбон

тайлбарладаг. Мөн иоджуулсан давсны хэрэглээ бүс нутгаар харилцан адилгүй байгаа нь иоджуулсан давсны хангамж зах зээлийн үнийн зөрүүтэй байдал, бүс нутгийн газар зүйн онцлог, хүн амын хэрэглээний дадал заншил зэрэг олон хүчин зүйлтэй холбоотойг хоол судлалын төвийн удаа дараагийн судалгаагаар баталсан байдаг.

Эрдэс, аминдэмээр баяжуулсан гурилын хэрэглээ

Төмрөөр баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнийг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох нь бага насны хүүхэд болон эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог төмөр дутлын цус багадалтаас сэргийлэх хамгийн хямд бөгөөд үр дүнтэй арга юм. 2002 оноос эхлэн Ядуурлыг бууруулах Японы сан (JFPR)-гийн хөрөнгөөр Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй буцалтгүй тусламжийн “Эх хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах JFPR 9005” төсөл, түүний үргэлжлэл болох “Хүнсний тогтвортой баяжуулан нийгмийн эрүүл мэндийг сайжруулах JFPR 9052” төслийн хүрээнд гурилыг эрдэс, аминдэм (төмөр оролцуулан)-ээр баяжуулах технологийг манай улсын зарим гурилын үйлдвэрүүдэд нэвтрүүлсэн. Одоогийн байдлаар том болон дунд оврын 6 үйлдвэрт уг технологийг


V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

бүрэн нэвтрүүлж, бага оврын 20 үйлдвэрт баяжуулсан гурил үйлдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Баяжуулсан гурил үйлдвэрлэхтэй холбогдсон хууль эрх зүйн баримт бичиг, стандартууд батлагдсан. Эдгээртэй зэрэгцэн хүн амын дунд баяжуулсан гурилын хэрэглээг бий болгох, түүнийг өргөжүүлэх мэдээлэл, сурталчилгааг хийж байна.

Судалгааны өрхийн асуулганд хариулсан өрхийн гишүүдийн 55 хувь нь баяжуулсан гурилын талаар сонсож байсан бөгөөд уг гурилыг судалгаанд хамрагдсан нийт өрхийн 36 хувь нь тогтмол, 31 хувь нь хааяа хэрэглэдэг байна (Хүснэгт NU.5A).

Баяжуулсан гурилын талаарх мэдлэг хотод (59 хувь) хөдөөгийнхөөс өндөр байна. Ийм гурилыг хотын өрхийн 42 хувь нь байнга (26 хувь нь хааяа) хэрэглэдэг байхад хөдөөгийн өрхийн 30 хувь нь байнга (26 хувь нь хааяа) хэрэглэдэг байна

Зураг V.7. Баяжуулсан гурил хэрэглэдэг өрхийн эзлэх хувь, бүс нутгаар, Монгол Улс, 2005 он



Зураг V.7-оос харахад Баруун бүсийн өрхийн 27 хувь, Хангайн бүсийн 66 хувь, Төвийн бүсийн 64 хувь, Зүүн бүсийн 70 хувь, Улаанбаатарын 78 хувь нь баяжуулсан гурилыг ямар нэгэн хэмжээгээр хэрэглэдэг болжээ. Эндээс дүгнэхэд Улаанбаатар хотод баяжуулсан гурилын хэрэглээ бусад бүс нутгийнхнаас өндөр, харин Баруун бүсэд хамгийн бага байна.

А аминдэм

А аминдэм нь нүдний хараа болон дархлалын системийн үйл ажиллагааг хэвийн байлгахад нөлөөлдөг маш чухал аминдэм юм. Энэ нь сүү, элэг, өндөг, улаан болон улбар шар өнгөтэй жимс, хар ногоон навчит ургамал зэрэг хүнсний бүтээгдэхүүнд илүүтэй агуулагддаг. Хэдийгээр, хөгжиж буй орнуудад А аминдэмийг агуулсан жимс, ногоог өргөн хэрэглэдэг ч энэ

нь тэдний хоногийн хэрэгцээг төдийлөн хангаж чаддаггүй байна. Энэ хэрэгцээ шаардлага нь хүүхдийн өсөж хөгжих, өвдөх, халдварт өвчинд өртөхөд илүү их шаардлагатай. Иймээс хөгжиж буй орнуудад А аминдэмийн дутал их, ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт өндөртэй орнуудад бүр ч их байдаг байна.

1990 онд хуралдсан Хүүхдийн төлөө Дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаас 2000 он гэхэд А аминдэмийн дутал түүний хор уршиг ялангуяа хараагүй болох явдлыг бүрмөсөн устгах зорилт тавьсан. 1991 оны “Далд өлсгөлөнг устгая” олон улсын чуулган, 1992 оны Олон улсын хоол тэжээлийн бага хурал, 2002 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас гарсан шийдвэр зорилтуудаар батлагдсан.

А аминдэмийн хүүхдийн эрүүл мэнд болон дархлалын системийн үйл ажиллагаанд гүйцэтгэдэг маш чухал үүрэг бол хүүхэд амьдрахад шаардлагатай анхдагч бичил элементүүдийн дутлыг хянах явдал юм. Иймд Мянганы хөгжлийн 4 дэх зорилт: 2015 он гэхэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах зорилтод хүрэхэд А аминдэмийн хэрэглээ их тус болох юм.


Монгол Улс 2005 онд “Эх, хүүхдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги”-ийг батлан мөрдөж байна. Манай улс 1998 оноос эхлэн НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр, ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу өндөр тунт А аминдэмийн тосон бэлдмэлээр 6–59 сартай хүүхдийг жилд 2 удаа, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг төрсний дараах 8 долоо хоногийн дотор хангаж байна.

V. ХҮҮХДИЙН ХООЛ, ТЭЖЭЭЛ

Судалгаанд хамрагдсан 6–59 сартай нийт хүүхдийн 65 хувь нь А аминдэмийг сүүлийн 6 сард уусан байв. А аминдэмийг уусан хүүхдүүдийн 17 хувь нь аминдэмжүүлэх товлосоос бусад үед уусан байсан бөгөөд 4 хувь нь хэзээ уусныг санахгүй байна гэж хүүхдийн эх/асрамжлагч нь хариулсан байна.

12–23 сартай хүүхдүүдийн А аминдэмжүүлэлтэнд хамрагдсан хувь хамгийн өндөр байгаа бөгөөд энэ хувь хэмжээ хүүхэд том болох тутам буурчээ. 12–23 сартай хүүхдийн хамрагдалт 48–59 сартай хүүхдийнхээс 17 пунктээр, 6–11 сартай хүүхдийнхээс 9 пунктээр дээгүүр байна.

Зураг V.8. Тав хүртэлх насны хүүхдийн А аминдэмжүүлэлтэнд хамрагдалт, хувиар, бүс нутгаар, Монгол Улс, 2005 он



Тав хүртэлх насны хүүхдийн А аминдэмжүүлэлтэнд хамрагдалтын хувийг бүс нутгаар нь авч үзвэл Баруун болон Зүүн бүсэд (55–57 хувь) хамрагдалт бусад бүс (61–73 хувь)–ээс доогуур байна (Зураг V.8).

Судалгаанд хамрагдсан, сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 56 хувь нь төрсний дараах саруудад А аминдэм уусан байна. А аминдэмжүүлэлтэнд хамрагдсан эхчүүдийг бүс нутгаар авч үзвэл харьцангуй жигд буюу 50–60 хувийн хооронд байна.

Бага жинтэй төрөлт

Хүүхдийн төрөх үеийн жин нь эхийн эрүүл мэнд болон хоол, тэжээлийн хангамжийн гол үзүүлэлт төдийгүй нярай хүүхдийн амьдрах боломж, өсөлт хөгжил, эрүүл мэндийн гол хүчин зүйл юм. Бага жинтэй төрөлт нь (2500 граммаас доош) хүүхдийн эрүүл мэндийг ноцтой эрсдэлд хүргэнэ. Ийм хүүхдийн дархлаа сул байдаг бөгөөд энэ нь өвчлөх эрсдэлийг ихэсгэнэ. Тухайлбал хүүхэд хоол, тэжээлийн дуталд илүүтэй өртөж, түүний үр дагаврын улмаас амьдралын явцад зүрх, судасны болон чихрийн шижин өвчнөөр өвдөх эрсдэл өндөр байдаг.

Хоол, тэжээлийн дуталтай төрсөн хүүхдийн оюуны чадамж (IQ)–ийн түвшин доогуур, танин мэдэхүйн болон суралцах чадвар сул байдаг. Хөгжиж буй орнуудад бага жинтэй хүүхэд төрөх асуудлыг яаралтай шийдвэрлэх хэрэгтэй гэж үздэг.

Бага жинтэй хүүхэд төрүүлэхэд гол нөлөө үзүүлж буй гурван хүчин зүйл байна. Үүнд эхчүүдийн хоол, тэжээлийн байдал муу, жирэмсэн үедээ хоол тэжээлийн дуталтай байх, хэт намхан (эмэгтэйчүүд хүүхэд байхдаа халдварт өвчнөөр өвдөх, ихэвчлэн хоол, тэжээлийн дуталтай байх), жирэмсний явцадургийн жингийн өсөлт хангалтгүй байх зэрэг юм.

2500 граммаас доош жинтэй төрөлтийн хувийн жинг асуулгын хуудасны 2 төрлийн мэдээлэл дээр үндэслэн тооцсон. Үүнд төрүүлсэн хүүхдийн жингийн талаарх эхчүүдийн өөрсдийн үнэлгээ (маш бага, дундаас доогуур, дунд зэрэг, дундаас дээгүүр, маш том) болон хүүхдийн жингийн талаар эхээс асууж авсан мэдээлэл, эрүүл мэндийн дэвтэр дээр бүртгэгдсэн (хэрэв төрөх үедээ жинлүүлсэн бол) төрөх үеийн жингийн хэмжээ эдгээр болно.

Судалгаагаар сүүлийн 2 жилд төрсөн нийт хүүхдийн 98 хувийг төрсөн даруйд нь жинлэсэн, харин Баруун бүсийн аймгуудад хүүхдийг төрсөн даруй жинлэх асуудал бусад бүсийнхтэй харьцуулахад бага буюу 93 хувьтай байна.

Нийт жинлүүлсэн хүүхдийн 5.5 хувь нь бага жинтэй төрсөн бөгөөд энэ нь Баруун бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад бага зэрэг илүү байна.

VI

Дархлаажуулалт



Мянганы хөгжлийн зорилт (4)-од хүүхдийн эндэгдлийг 2015 он гэхэд 1990 оны түвшнээс гуравны хоёроор бууруулах зорилтыг дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилтыг ханган биелүүлэхэд дархлаажуулалт гол үүрэг гүйцэтгэнэ. Дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийг 1974 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн нь сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд сая сая хүүхдийг эсэн мэнд өсөж торних нөхцлийг бүрдүүлсэн юм. Гэсэн хэдий ч дэлхий дээр 27 сая хүүхэд дархлаажуулалтанд хамрагдаж чадахгүй байгаагаас вакцинаар урьдчилан сэргийлэх боломжтой халдварт

өвчнөөр жилд 2 сая гаруй хүүхэд эндэж байна.

Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалын нэг зорилт бол нэг хүртэлх насны хүүхдийн бүх төрлийн дархлаажуулалтанд хамрагдалтыг үндэсний түвшинд 90 хувь, орон нутгийн түвшинд хамгийн доод тал нь 80 хувь хамруулах явдал юм.

НҮБ-ын Хүүхдийн Сан болон ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу хүүхэд бүр төрснөөс хойш 11 сар 29 хоног дотор сүрьеэгийн эсрэг (БЦЖ) вакцинд нэг удаа, сахуу-хөхүүл ханиад, татран (СХХТ), саагийн эсрэг вакцинд тус бүр 3 удаа, мөн улаанбурханы эсрэг вакцинд хамрагдах ёстой. Судалгаанд хамрагдсан өрхийн тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрээс вакцинд хамрагдсан тухай мэдээллийг судалгаанд авч ашиглалаа. Тэрчлэн судалгаанд хамрагдсан өрхийн 5 хүртэлх насны нийт хүүхдийн 80.5 хувийнх нь вакцинд хамрагдалтыг эрүүл мэндийн дэвтрээс вакцины төрөл тус бүрээр, эрүүл мэндийн дэвтрэгүй (дэвтрийг үзэх боломжгүй байсан) хүүхдүүдийн вакцинд хамрагдалтыг эх, асрамжлагчаас нь хүүхэд ямар вакцинд, хэдэн удаа хамрагдсан тухай мэдээллийг асууж тэмдэглэх аргаар вакцинд хамрагдалтын мэдээллийг цуглуулж авсан.

Судалгаанд хамрагдсан 12–23 сартай хүүхдүүдийн вакцинд хамрагдалтыг вакцины төрөл тус бүрээр Хүснэгт СН.1-д үзүүлэв. Уг хүснэгтийн судалгааны өмнөх аль нэг хугацаанд вакцинд хамрагдалтыг тооцож гаргахдаа судалгааны өмнөх аль нэг хугацаанд вакцинд хамрагдсан хүүхдийн тоог (эрүүл мэндийн дэвтэр дээрх бичилт болон эхийн хариулсанаар) вакцинд бүрэн хамрагдсан байх ёстой 12–23 сартай хүүхдийн тоонд, нэг нас хүрэхээс өмнөх вакцинд хамрагдалтыг тооцож гаргахдаа нэг нас хүрэхээсээ өмнө хамрагдвал зохих вакцинд хамрагдсан хүүхдийн тоог вакцинд бүрэн хамрагдсан байх ёстой 12–23 сартай хүүхдийн тоонд харьцуулсан болно.

Манай улсад хүүхдийн бүх төрлийн вакцинд хамрагдалтын түвшин нилээд өндөр байдаг. Энэ хувь хэмжээ өнгөрсөн 5 жилийн хугацаанд бага зэрэг нэмэгдсэн байна (Зураг VI.1). Судалгааны үеэр эрүүл мэндийн дэвтрийн бичилтээр вакцинд хамрагдалтыг бүртгэсэн тохиолдол өмнөх судалгаатай харьцуулахад буурч, харин эхийн хариулснаар вакцинд хамрагдалтыг бүртгэсэн тохиолдол бага зэрэг нэмэгдсэн байна.

VI. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг тухайн өрхөд хадгалах ёстой боловч дэвтрийг хаяж үрэгдүүлэхээс болгоомжлон өрхийн эмнэлэг дээр хадгалах тохиолдол түгээмэл байна. Энэ байдлаас шалтгаалан судалгааны үеэр бүх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрээс вакцинд хамрагдалтыг харж бичиж авах боломжгүй байсан хэдий ч судалгааны баг дэвтэр нь гэрт байхгүй хүүхдийн хувьд аль болохоор өрхийн эмнэлгийн ажилтан нарт байгаа хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх бичилтээр вакцинд хамрагдалтыг бүртгэж авсан болно.

Хүүхдэд төрснөөс хойш 24 цагийн дотор хийдэг сүрьеэгийн вакцинд хамрагдалтын түвшин хамгийн өндөр (97.6 хувь) байна.


Вакцинд хамрагдалтын түвшин хүүхдийн нас ахих тутам бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна (Зураг VI.2).

Сахуу-хөхүүлханиад-татран(СХХТ)-гийн I тунд хамрагдалт 92.6 хувь, II тунд хамрагдалт 94.0 хувь, III тунд хамрагдалт 93.0 хувь байна. Харин саагийн I ба III тунгийн хамрагдалт 98.0 хувиас 94.0 хувь болж буурсан байна. Хэдийгээр саа болон сахуу-хөхүүл ханиад-татрангийн вакциныг нэг зэрэг (2 сартайд, 3 сартайд, 4 сартайд нь) хийдэг ч саагийн вакцинд хамрагдалтын түвшин сахуу-хөхүүл ханиад-татрангийн вакцинд хамрагдалтаас бүх тунгийн хувьд өндөр байна.

Дээр дурдсан вакцинууд (сүрьеэ, сахуу-хөхүүл ханиад-татрангийн I-III тун, саагийн I-III тун)-ын хувьд 1 хүртэлх насандаа хамрагдсан, судалгааны өмнөх хугацаанд вакцинд хамрагдсан хүүхдийн хувь бараг ойролцоо байна.


Дээрх вакцинуудыг товлосон хугацааны дагуу хүүхдийг төрснөөс хойш 4 сартай болох хугацаанд хийж дуусгах ёстой учраас товлосон хугацаанаас бага зэрэг хоцорсон ч 1 нас хүртэлх хугацаанд хийлгээгүй байх тохиолдол бараг байхгүй байна.

Зураг VI.2. Нэг нас хүрэхээс өмнө болон судалгааны өмнөх хугацаанд вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2005 он



Улаанбурханы вакцинд хүүхдүүд товлосон хугацаанаас хоцорч хамрагдаж байгаа нь "хугацаандаа, бүрэн" хамрагдалтын түвшин гэдэг үзүүлэлт доогуур гарахад хүргэж байна.

Зураг VI.1. Судалгааны өмнөх хугацаанд вакцинд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2000, 2005 он



Харин улаанбурханы эсрэг вакцинд хамрагдалт бусад вакцинаас харьцангуй доогуур байна. Товлолын дагуу хүүхэд бүр 8-11 сартайдаа улаанбурханы эсрэг вакцинд хамрагдах ёстой боловч тэдний зөвхөн 76 хувь нь нэг нас хүрэхээсээ өмнө, 88 хувь нь судалгааны өмнөх аль нэг хугацаанд хамрагдсан байна. Ийнхүү товлосон хугацаанаас хоцорч хамрагдсан хүүхдийн зарим нь 2005 оны 8-11 сарын хооронд улсын хэмжээгээр улаанбурханы вакцин тасарснаас үүдэлтэйгээр товлосон хугацаанаас хоцорч хамрагдсан байж болох юм.

Нэг нас хүрэхээс өмнө хамрагдвал зохих бүх төрлийн вакцинд хугацаандаа бүрэн хамрагдсан хүүхэд 68 хувь байна.

Хамрагдвал зохих 8 төрлийн вакцинд товлот хугацаанаас хоцорсон боловч бүрэн хамрагдсан 12–23 сартай хүүхдийн хувьд дээрх үзүүлэлт 82 хувь болж байна.

Шингэн сэлбэх эмчилгээ

Суулгалт өвчин нь дэлхий дээрх 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын 2 дахь гол шалтгаан болдог. Суулгалтаас шалтгаалсан нас баралтын ихэнх нь хүүхэд их хэмжээний шингэн алдсанаас тохиолддог. Суулгалт өвчнийг шингэн сэлбэх давс (ШСД)-ны уусмал болон гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэнээр эмчлэх арга нь хүүхдийг энэ өвчний улмаас эндэхээс сэргийлдэг.

Хүүхдийг шингэний болон хоол тэжээлийн дуталд орохоос сэргийлж шингэнийг их хэмжээгээр уулгаж, хоолыг сойхгүй үргэлжлүүлэн өгөх нь суулгалт өвчнийг эмчлэх гол арга юм.


Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд 2010 он гэхэд суулгалт өвчнөөс шалтгаалсан 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтыг 2000 онтой харьцуулахад хоёрны нэгээр бууруулах, Мянганы хөгжлийн зорилтод 2015 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтыг 1990 оныхоос гуравны хоёроор бууруулах зорилтуудыг дэвшүүлсэн. Мөн Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд суулгалт өвнөөр өвчлөх тохиолдлыг 25 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн юм.

Эдгээр зорилтын хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүд нь:

- ✦ Суулгалт өвчний тархалтын түвшин
- ✦ Шингэн сэлбэх эмчилгээ (ШСЭ)
- ✦ Суулгалт өвчний гэрийн эмчилгээ
- ✦ ШСЭ ба шингэнийг ихээр хэрэглэж үргэлжүүлэн хооллолт зэрэг болно.

Судалгааны асуулгаар хүүхэд сүүлийн 14 хоногт суулгалт өвчнөөр өвчилсөн эсэхийг эх, асрамжлагчаас асууж, хэрвээ өвчилсөн бол хүүхэд эрүүл байх үетэй харьцуулахад хоол болон шингэнийг ямар хэмжээгээр хэрэглэсэн зэрэг асуулт тавьж, хариулт авсан болно.

Зураг VI.3. Суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн 0-59 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2005 он



Судалгаанд хамрагдсан тав хүртэлх насны хүүхдүүдийн 7 хувь нь сүүлийн хоёр долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөнөөс (Хүснэгт СН.3) 6–11 сартай хүүхдийн 11 хувь, 12–23 сартай хүүхдийн 10 хувь нь суулгалт өвчнөөр өвдсөн нь бусад насны бүлгийн хүүхдүүдээс өндөр байна. Улаанбаатар хотын хүүхдүүдийн 4.2 хувь нь өвдсөн нь бусад бүсээс хамгийн цөөн, харин Хангай (8.7 хувь), Баруун (7.4 хувь), Зүүн (7.2 хувь) бүсэд өвчлөл хамгийн их байна. Суулгалт өвчнөөр өвчилсөн хүүхдүүдийг хот хөдөөгөөр авч үзвэл хөдөөний хүүхдүүд (8 хувь) хотынхоос (5 хувь) ядуу амьдралтай айлын

VI. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

хүүхдүүд (8 хувь) чинээлэг амьдралтай айлын (5 хувь) хүүхдүүдээс илүү их өвдсөн байна. Суулгалт өвчнөөр өвдсөн хүүхдүүдийн 63 хувь нь шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн байна.

Шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн байдлыг бүсээр авч үзвэл Баруун бүсэд хамгийн доогуур 52 хувь нь харин Хангайн бүсийн хүүхдүүдийнх 78 хувь байна. Мөн суулгалтаар өвчилсөн үедээ шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн байдлыг эхийн боловсролын түвшингээр авч үзэхэд нилээд ялгаатай байгаа нь Зураг VI.3-аас харагдаж байна.

Суулгалт өвчнөөр өвчилсөн хүүхдүүдийн 38 хувь нь шингэн сэлбэх давсны уусмалыг, 30 хувь нь зөвлөмжийн дагуу гэрийн нөхцөлд бэлтгэсэн шингэний эмчилгээ хийлгэсэн байна.


Энэ өвчнөөр өвчилсөн хүүхдүүдийн 63 хувь нь шингэн сэлбэх ямар нэг эмчилгээ (шингэн сэлбэх давсны ууталсан бэлдмэл, гэрийн нөхцөлд бэлтгэсэн уусмал) хийлгэсэн байхад 37 хувь нь огт хийлгээгүй байна.

Суулгалт өвчний үед хоолыг сойхгүй үргэлжлүүлэн хооллох ДЭМБ-ын зөвлөмжийг Монгол Улсад хэрэгжүүлж байна. Суулгалтаар өвчилсөн хүүхдүүдийн дөрөвний гурав нь голдуу ердийн үеийнхтэй ойролцоо хэмжээгээр хооллож байна

Хүүхдээ суулгалт өвчнөөр өвчилсөн үед эхчүүдийн зөвхөн 33 хувь нь шингэнийг их хэмжээгээр хүүхэддээ өгсөн, харин 65 хувь нь бага хэмжээтэй өгсөн гэж хариулсан байна. Хүүхдүүдийн 72 хувь нь ердийн үеийнхтэй ойролцоо хэмжээгээр, харин 28 хувь нь маш бага буюу хоолоо огт идээгүй байна (Хүснэгт СН.4).

Суулгалт өвчнөөр өвчилсөн нийт хүүхдийн дөнгөж 21 хувь нь үргэлжлүүлэн хооллож, ердийнхөөс илүү хэмжээгээр шингэн зүйл уусан байна. Хүснэгт СН.4-ийн мэдээллийг шингэн сэлбэх эмчилгээг харуулсан хүснэгт СН.3-тай нэгтгэж үзэхэд шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн эсвэл шингэнийг ихээр уухын зэрэгцээ үргэлжлүүлэн хооллосон хүүхэд нийт өвчилсөн хүүхдүүдийн 47 хувийг эзэлж байна.

Зураг VI.4. Суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ үргэлжлүүлэн хооллож, ердийнхөөс илүү шингэн уусан 0-59 сартай хүүхдийн хувь, Монгол Улс, 2005 он



Өвчлөх үед “Үргэлжлүүлэн хооллож, ердийнхөөс илүү шингэн уусан болон шингэн сэлбэх эмчилгээ хийлгэсэн 0-59 сартай хүүхдүүдийг хот, хөдөө болон бүс нутаг, эхийн боловсролын түвшингээр авч үзвэл харилцан адилгүй байна.

Хөдөөгийн хүүхдүүдийн 49 хувь нь суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ гэрийн эмчилгээ хийлгэсэн байхад хотын хүүхдүүдийн 42 хувь нь хийлгэсэн байна. Бүсээр авч үзвэл Баруун бүсэд дөнгөж 38 хувь нь дээрх эмчилгээг хийлгэсэн бол Төв ба Зүүн бүсийн хүүхдүүдийн 2 хүүхэд тутмын нэг нь хийлгэсэн байна.

Уушигны хатгалгааны антибиотикийн эмчилгээ, тусламж авсан байдал

Уушигны хатгалгаа нь хүүхдийн эндэгдлийн голлох шалтгааны нэг бөгөөд үүний гол эмчилгээ нь антибиотик эмчилгээ юм.

Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд амьсгалын замын цочмог халдварт өвчнөөс шалтгаалсан хүүхдийн эндэгдлийг гуравны нэгээр бууруулахаар заасан.

Хүүхэдханиадхүрсэнүедээцээжньяхатнах,хамарньбитүүрсэнээсшалтгаалахгүйгээр түргэн бөгөөд бэрхшээлтэй амьсгалах шинж тэмдэг илэрсэн бол уушигны хатгалгаа өвчнөөр өвчилсөн байж болзошгүй гэж авч үзсэн.

Үзүүлэлтүүд:

- ✦ Болзошгүй хатгалгаа өвчний тархалтын түвшин
- ✦ Болзошгүй хатгалгааны үед бусдад хандсан байдал
- ✦ Болзошгүй хатгалгааны антибиотик эмчилгээ
- ✦ Хатгалгааны аюултай шинж тэмдгийн талаарх мэдлэг

Судалгааны өмнөх хоёр долоо хоногт судалгаанд хамрагдсан 0–59 сартай хүүхдүүдийн 9 орчим хувьд нь уушигны хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн байна. Энэ үзүүлэлтийг бүсээр авч үзвэл Хангайн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад арай өндөр 12 хувь, бусад бүсүүдэд 7–8 хувь байна. Өвчилсөн хүүхдүүдийг эхийн боловсролын түвшингээр авч үзвэл боловсролгүй, бага боловсролтой эхчүүдийн хүүхдүүд түүнчлэн аж байдлын түвшин доогуур өрхийн хүүхдүүд өвчлөх нь илүү байна.

Хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрсэн хүүхдүүдийн 63 хувь нь эмнэлэгт үзүүлсэн ба үүнээс 28 хувь нь өрхийн эмнэлэгт, 27 хувь нь сум, багийн эмчид, 5 хувь нь нэгдсэн эмнэлэгт хандаж үзүүлэн зөвлөгөө, тусламж авсан байна.

Хүснэгт СН.6–д уушигны хатгалгаа өвчний шинж тэмдэг илэрч, антибиотик эмчилгээ хийлгэсэн тав хүртэлх насны хүүхдүүдийг хүйс, нас, бүс нутаг, байршил болон өрхийн аж байдлын үзүүлэлтээр харуулав.

Судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхдүүдийн 9 орчим хувь нь судалгаа явагдахаас өмнөх 2 долоо хоногт ханиад хүрч, хатгалгааны шинж тэмдэг илэрсэн байна. Эдгээр хүүхдүүдийн 71 хувь нь антибиотик хэрэглэжээ. Антибиотикийн хэрэглээ улс орон даяар жигд тархсан байдалтай байна.

Баруун бүсэд таван хүүхэд тутмын дөрвийг Хангайн бүсэд таван хүүхэд тутмын гурвыг антибиотикоор эмчилжээ. Бүс нутгийн хувьд ийм ялгаатай байгаа хэдий ч Баруун, Зүүн болон Хангайн бүсэд өвчилсөн хүүхдийн тоо харьцангуй цөөн байна.

Харин антибиотикийн хэрэглээг хот, хөдөөгөөр болон өрхийн байршлаар (нийслэл хот, аймгийн төв, сумын төв, хөдөө) авч үзвэл бараг ялгаагүй байна.

Хүүхдээ өвчилсөн үед яаралтай тусламж үзүүлэх талаар эхийг зохих хэмжээний мэдлэгтэй болгох нь хүүхдийн өвчлөлийн цогц удирдлага хөтөлбөрийн нэг чухал хэсэг болно. Хүүхэд хөгжил судалгаагаар өвчний ямар шинж тэмдэг илэрсэн үед хүүхдээ эмнэлэгт үзүүлдэг вэ гэсэн асуултыг эх, асрамжлагчдаас асуусан юм.

Хамгийн нийтлэг хариулт бол эх, асрамжлагчдын 85.6 хувь нь хүүхдээ халуурахад эмнэлэгт ханддаг гэжээ (Хүснэгт СН.6А). Өөр нэг шинж тэмдэг бол хүүхдээ өвдөж байна гэж үзсэн тохиолдолд эхчүүдийн 36 хувь нь хүүхдийн амьсгал олширсон (21 хувь) эсвэл амьсгал саадтай байгаа (23 хувь) нөхцөлд эмнэлэгт үзүүлдэг байна. Харин судалгаанд

VI. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

хамрагдсан эх, асрамжлагчдын ердөө 8 хувь нь хатгалгаа өвчний 2 гол шинж тэмдэг (амьсгал олширсон ба амьсгал саадтай байгаа)–ийг мэддэг байна.


Эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатайг тодорхойлох шинж тэмдгүүдийн талаархи эхийн мэдлэг болон тэдний боловсролын түвшингийн хооронд тодорхой хамаарал харагдахгүй байна. Баруун болон Төвийн бүсийн эхчүүдийн 10–12 хувь нь хатгалгааны 2 шинж тэмдгийг мэддэг байхад Хангай болон Зүүн бүсийн эхчүүдийн 4–7 хувь, мөн нийслэл хотын (5 хүртэлх насны хүүхдүүдтэй) эхчүүдийн 8 хувь нь мэддэг байна. Энэ нь эмнэлгийн тусламж шаардлагатайг тодорхойлох шинж тэмдгүүдийн талаархи эхийн мэдлэг бүс нутгуудын хооронд нилээд ялгаатай байгааг харуулж байна. Харин хот, хөдөөгийн хооронд бараг ялгаагүй байна.

Хатуу түлшний хэрэглээ

Хатуу түлш хэрэглэн хоол хүнсээ хийх нь гэр болон өрөөний агаарыг маш ихээр бохирдуулдаг бөгөөд дэлхий дээр хүний эрүүл мэндийг хордуулдаг, ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчний зонхилох шалтгаан болж байна.

Монгол Улсын нийт өрхийн дөрөвний гурваас илүү (76.5%) нь хоол, хүнсээ бэлтгэхдээ хатуу түлш хэрэглэж байна.

Зураг VI.5. Хоолоо хийхдээ хэрэглэдэг түлшний төрөл, Монгол Улс, 2005 он




Хүснэгт СН.7–д хатуу түлшний төрлийг байршлаар, өрхийн аж байдал болон бусад сонгосон үзүүлэлтүүдээр харууллаа.

Хатуу түлшийг хэрэглэх явдал хотынхоос (61%) хөдөөд (98%) илүү байна (Зураг VI.6).

Хатуу түлшний хэрэглээг бүсээр авч үзвэл хоорондоо нилээд ялгаатай юм. Ийм түлш хамгийн ихээр хэрэглэж байгаа бүс нь Баруун болон Хангайн бүс бөгөөд 10 өрх тутмын 8 нь хоол ундаа бэлтгэхдээ хатуу түлш хэрэглэж байна. Улаанбаатар хотын өрхүүд хатуу түлшийг хамгийн бага хэрэглэж байгаа нь Улаанбаатар хотын нийт өрхийн 1/3 нь тохилог орон сууцанд амьдардагтай холбоотой.

Зураг VI.6. Хатуу түлшний хэрэглээ, бүс нутгаар, Монгол Улс, 2005 он



Хатуу түлшний хэрэглээг төрлөөр авч үзвэл хамгийн их хэрэглэгддэг нь мод (33%) бөгөөд Хангайн (58%) бүсэд энэ түлш зонхилдог байна. Хоёр дахь гол түлш бол аргал хөрзөн (23%), тухайлбал Баруун болон Зүүн бүсэд нийт түлшний 42–43 хувийг аргал хөрзөн эзэлж байна.

Харин нүүрс нийт хатуу түлшний хэрэглээний 20 хувийг эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн Улаанбаатар хотын гэр хорооллынхон (42 хувь) нүүрс түлдэг байна.

VII

Ундны усны хангамж



Ундны усны аюулгүй эх үүсвэр нь эрүүл амьдрахын үндсэн нэг нөхцөл мөн. Бохирдсон ундны ус нь холер, гэдэсний хижиг зэрэг халдварт өвчний нянг тараадаг. Түүнчлэн ундны ус нь хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг хими, физикийн болон радио идэвхт бодисоор бохирдох явдал тун элбэг. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хувьд ундны усны хангамж, хүртээмж ялангуяа хөдөө орон нутагт ихээхэн чухал. Учир нь тэд усаа авах зөөхөд голлох үүргийг гүйцэтгэдэг.

Мянганы хөгжлийн зорилтод 2015 он гэхэд ундны цэвэр усны хүртээмжгүй, ариун цэврийн наад захын байгууламжгүй хүн амын эзлэх хувийг 1990 оны түвшнээс 2 дахин бууруулах, Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц тунхаглалд шаардлага хангасан ариун цэврийн байгууламж болон аюулгүй ундны усны эх үүсвэрээр хангагдаагүй өрхийн тоог доод тал нь гуравны нэгээр бууруулах зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

Хүүхэд хөгжил судалгаагаар дараах үзүүлэлтүүдийг тооцсон болно:


Ундны усны хангамж:

- ✦ Сайжруулсан ундны усны хэрэглээ, эх үүсвэрээр
- ✦ Усыг ариутгах арга
- ✦ Ундны усаа авахдаа зарцуулдаг хугацаа
- ✦ Ундны усанд явдаг хүн

Ариун цэврийн байгууламжийн хангамж:

- ✦ Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээ
- ✦ Хүүхдийн ялгадсыг зайлуулж буй байдал

Зураг VII.1. Хүн амын ундны усны хангамж, эх үүсвэрээр, Монгол Улс, 2005 он



Хүн амын ундны усны хангамжийн эх үүсвэрийг Хүснэгт EN.1 болон Зураг VII.1–д үзүүлэв. Ундны усны дараах эх үүсвэрийг “Ундны усны сайжруулсан эх үүсвэр” гэж авсан. Үүнд: Хоолойгоор түгээдэг ус, нийтийн усан сан, насостой худаг, хамгаалалттай худаг, хамгаалалттай булаг болон бороо, цасны ус.

Монгол Улсын хүн амын 72 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдсан байна.

VII. УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

Энэ үзүүлэлт хотын хүн амын хувьд 91 хувь, хөдөөгийн хүн амын хувьд 46 хувь байна. Хамгаалалттай худаг, булаг, усан сан нь хамгийн түгээмэл ундны усны эх үүсвэр бөгөөд нийт хүн амын 50 хувь нь ундны усны дээрх эх үүсвэрээс усаа авч байна.

Ундны усны хангамжийн байдал хот, хөдөөгөөр, мөн бүс нутгаар нилээд ялгаатай байна (Хүснэгт EN.1). Баруун болон Хангайн бүсийн хувьд бусад бүс нутгаас нилээд доогуур буюу хүн амын 50 орчим хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдсан байхад гадаргын ус хэрэглэдэг хүн амын эзлэх хувь Зүүн бүсэд 14 хувь, Төвийн бүсэд 6 хувь байгаа нь бусад бүстэй харьцуулахад хамгийн бага байна.

Ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдсан байдлыг өрхийн байршлаар авч үзвэл хөдөөгийн хүн амын 41 хувь нь хангагдсан байна.

Усаа хэрхэн ариутгадаг байдлыг Хүснэгт EN.2–т харуулав. Өрхүүдээс ундны усаа ариутгах зорилгоор буцалгах, ариутгалын бодис хэрэглэх, шүүх, ус цэвэршүүлэгч хэрэглэх зэрэг аргуудыг хэрэглэдэг эсэхийг асуусан бөгөөд эдгээр аргуудыг ундны ус ариутгах зохистой аргууд гэж үзсэн. Ундны усаа ариутгахдаа зохистой арга хэрэглэж буй өрхүүдийг сайжруулсан болон сайжруулаагүй эх үүсвэрээр тус тусад нь болон нийтэд нь харуулсан болно. Хүснэгтээс харахад, ундны усны эх үүсвэр сайжруулсан болон сайжруулаагүйгээс үл хамааран өрхүүд усаа ариутгаж хэрэглэдэг бөгөөд хамгийн түгээмэл хэрэглэдэг арга нь буцалгах арга байна.

Ундны усаа авахад зарцуулдаг хугацааг Хүснэгт EN.3–д харин хэн голдуу усаа авдаг талаарх мэдээллийг хүснэгт EN.4–т харууллаа. Үүнд зөвхөн нэг удаа ус аваад буцаж ирэхэд зарцуулдаг хугацааг асуусан бөгөөд ус авах давтамжийг асуугаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт EN.3–аас харахад нийт өрхийн 22 хувь төвлөрсөн усан хангамжтай гэжээ. Бусад өрхүүдийн хувьд 47 хувь нь ус авахдаа 30–аас илүүгүй минут зарцуулдаг ба харин өрхүүдийн 11 хувь ус авахад нэг цагаас илүү хугацаа зарцуулдаг байна. Төвлөрсөн усан хангамжаар хангагдсанаас бусад өрх ундны усаа авахдаа дунджаар 31 минут зарцуулдаг байна. Хөдөөгийн хүн ам хотын хүн амтай харьцуулахад ус авахад дунджаар 18 минут илүү зарцуулдаг гэжээ. Ялангуяа алслагдсан хөдөөд ус авахад багагүй хугацаа зарцуулдаг бөгөөд дундаж хугацаа 44 минут байна.

Хүснэгт EN.4–ийг харахад дийлэнх тохиолдолд буюу зөөврийн ус хэрэглэдэг өрхийн 49 хувьд нь насанд хүрсэн эрэгтэй хүн, 32 хувьд нь насанд хүрсэн эмэгтэй хүн усанд явдаг байна. Харин бусад өрхийн хувьд насанд хүрээгүй охид, хөвгүүд ус авдаг гэжээ (7 хувь, 3 хувь).

Ариун цэврийн байгууламж

Хүний ялгадсыг сайтар зайлуулж, цэвэрлээгүй, хувийн ариун цэвэр сахиагүйгээс суулгалт, саа зэрэг хэд хэдэн төрлийн өвчин дэлгэрэх нөхцөл бүрддэг. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид бохирын системд холбогдсон бие засах газар, ариутган цэвэрлэх төхөөрөмж, татуургын устай бие засах газар, гадна жорлонг хамааруулав.

Монгол Улсын хүн амын 77 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна (Хүснэгт EN.5). Ердийн нүхэн жорлон нь хамгийн түгээмэл ариун цэврийн байгууламж бөгөөд нийт өрхийн бараг тал нь энэ төрлийн байгууламжтай байна.

Ариун цэврийн байгууламжийн хангамж Баруун болон Хангайн бүсэд бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур ажээ. Хүснэгтээс харахад сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байдал өрхийн аж байдлаас ихээхэн хамаардаг бөгөөд хот хөдөөгийн зөрүү нэлээд их байна. Хотод сайжруулсан ариун цэврийн байгууламжтай

VI. УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

өрхийн хувь 95 байхад хөдөөд дөнгөж 53 хувь байна. Түүнчлэн хөдөөгийн өрхүүдийн багагүй хувь (29 хувь) нь ариун цэврийн байгууламжгүй байна. Харин хотын хүн амын гуравны нэг нь бохирын системд холбогдсон ариун цэврийн байгууламжтай ажээ. Хамгийн ядуу 20 хувийн зөвхөн 29 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай байгаа нь улсын дунджаас 3 дахин доогуур байна.

Хүүхдийн ялгадсыг аюулгүй газарт зайлуулсан гэсэн үзүүлэлтийг хамгийн сүүлд хүүхдийн ялгадсыг хэрхэн зайлуулсан бэ гэсэн асуултаар тодорхойлсон бөгөөд ариун цэврийн байгууламж руу асгаж зайлуулсан тохиолдлыг аюулгүй гэж үзсэн. 0–2 настай хүүхдийн ялгадсыг хэрхэн зайлуулсан байдлыг Хүснэгт EN.6–д харуулав. Хүснэгтээс харахад дийлэнхдээ буюу нийт хүүхдүүдийн 60 хувийн ялгадсыг аюулгүй газарт зайлуулсан байна.

Хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамжийг Хүснэгт EN.7–д нэгтгэн харуулав. Монгол Улсын нийт хүн амын 63 хувь нь ундны ус, ариун цэврийн байгууламжийн сайжруулсан эх үүсвэрээр үндсэндээ хангагджээ.

Өрхийн аж байдал, хот, хөдөө болон бүс нутгаар нилээд ялгаатай байгаа нь харагдаж байна. Ундны ус болон ариун цэврийн байгууламжийн сайжруулсан хангамжтай хүн амын эзлэх хувь ядуу өрхүүдийн хувьд 11 хувь байхад чинээлэг өрхүүдэд 99 хувь байна. Хотын нийт хүн амын 87 хувь нь ундны усны сайжруулсан эх үүсвэрээс ундны ус хэрэглэж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байхад хөдөөд дөнгөж 30 хувь байна. Алслагдсан хөдөөд энэ хувь хамгийн бага буюу 21 байгаа бөгөөд бүс нутгаар авч үзэхэд, Баруун болон Хангайн бүсэд дээрх хувь хэмжээ 40 орчим хувь байгаа нь хамгийн доогуур үзүүлэлт юм.

VIII

Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгсэл

Гэр бүл төлөвлөлтийн зохистой аргыг сонгон хэрэглэх нь 1-рт хэт залуудаа болон хэт орой хүүхэд төрүүлэхээс урьдчилан сэргийлдэг, 2-рт төрөлт хоорондын зайг уртасгадаг 3-рт хүссэн тоогоор хүүхэдтэй болох боломж олгодог тул эх, хүүхдийн аль алины эрүүл мэндэд тустай юм. Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц тунхаглалын нэг зорилт нь бүх хосуудыг хэт эрт, хэт орой болон олон жирэмслэхээс хамгаалах талаар мэдээлэл болон үйлчилгээгээр хангах явдал юм.

Судалгаагаар гэр бүлтэй болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 66 хувь нь одоогийн байдлаар жирэмслэхээс хамгаалах ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байна (Хүснэгт РН.1). Монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь ерөндөг бөгөөд нийт эмэгтэйчүүдийн 29 хувь тус аргыг хэрэглэдэг гэжээ. Үүний дараагаар эм (12 хувь) болон тариа (11 хувь) тус тус орж байна. Түүнчлэн, хорин эмэгтэйн нэг нь бэлгэвч хэрэглэдэг гэжээ. Мөн эмэгтэйчүүдийн таван хувь нь түр тэвчих /хуанли/, гадуур тавих, хүүхдээ хөхөөр хооллох зэрэг уламжлалт аргыг хэрэглэдэг байна.

ЖХАХ-ийн хэрэглээг бүсээр авч үзвэл харьцангуй бага ялгаатай байгаа бөгөөд Төвийн бүсэд хэрэглээ хамгийн өндөр (72 хувь) харин Баруун бүсэд хамгийн бага (61 хувь) байна. Сонирхол татсан нэг үзүүлэлт бол хөдөөгийн эмэгтэйчүүдийн ЖХАХ-ийн хэрэглээ хотын эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд энэ хэрэглээ нь тарианы хэрэглээний зөрүүгээр тайлбарлагдаж байна. Учир нь тариа хэрэглэж байгаа хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувь хотын эмэгтэйчүүдтэй харьцуулахад хоёр дахин өндөр байна. Ахимаг насны бүлгийн буюу 40–49 настай эмэгтэйчүүдийн ЖХАХ-ийн хэрэглээ залуу насны бүлгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад доогуур, тухайлбал, 45–49 насны эмэгтэйчүүдийн хэрэглээ 38 хувь байна.

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр байхын хирээр ЖХАХ-ийн хэрэглээ өндөр байна. Боловсролгүй эмэгтэйчүүдийн 54 хувь нь, бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн 65 хувь нь ЖХАХ хэрэглэдэг гэжээ. Гэхдээ боловсрол доогуур болон боловсролтой эмэгтэйчүүдийн энэ зөрүү бүсийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага байгааг тэмдэглэх нь зүйтэй. Орчин үеийн арга хэрэгслийн хэрэглээ ч ижил хэв маягтай нь ажиглагдаж байна. Харин арга тус бүрээр үзэхэд зарим ялгаатай байдал харагдаж байв. Тухайлбал, эм хэрэглэх нь боловсрол өндөр болон чинээлэг эмэгтэйчүүдийн дунд илүү түгээмэл байхад ядуу болон боловсрол багатай эмэгтэйчүүдийн тариа хэрэглэж байгаа хувь чинээлэг болон боловсрол өндөр эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Өөр нэгэн сонирхолтой үр дүн нь хамгийн чинээлэг бүлэгт багтах эмэгтэйчүүд уламжлалт арга хэрэглэх нь харьцангуй түгээмэл байгаа явдал юм.

Жирэмслэхээс хамгаалах арга, хэрэгслийн дутагдаж буй хэрэгцээ

ЖХАХ-ийн дутагдаж буй хэрэгцээ нь одоогоор жирэмслэхээс хамгаалах ямар нэгэн арга хэрэглэдэггүй мөртлөө хүүхэд төрүүлэхийг хүсэхгүй байгаа, мөн хожуу жирэмслэхийг хүсч байгаа тохиолдлыг хэлнэ. Энэ судалгаанд ЖХАХ-ийн дутагдаж буй хэрэгцээг ЖХАХ-ийн одоогийн хэрэглээ, жирэмслэх чадавхитай эсэх, төрөлтийн сонголтын талаарх багц асуултуудын тусламжтайгаар тодорхойлов.

Жирэмслэхээ хойшлуулах (тодорхой хугацаагаар жирэмслэхгүй байх)-ыг хүсч байгаа, ЖХАХ-ийн дутагдаж буй хэрэгцээтэй эмэгтэйчүүд гэдэгт гэр бүлтэй, бэлгийн идэвхитэй амьдралд байгаа, жирэмслэх чадавхитай (судалгаа явагдах үед жирэмсэн

эсвэл өөрсдийгөө жирэмслэх чадвартай гэж үзэж байгаа), ЖХАХ-ийг хэрэглэхгүй байгаа жирэмслэхээ хойшлуулахыг хүсч байгаа эмэгтэйчүүдийг тус тус хамруулсан. Түүнчлэн жирэмсэн бус эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлэх хүсэлтэй ч наад зах нь 2 жил хүлээх бодолтой байгаа болон гэр бүлтэй болсны дараа хүүхэдтэй болохыг хүсч байгаа эмэгтэйчүүд гэж ангилан авч үзлээ.

Жирэмслэхээ зогсоохыг хүсч байгаа (цаашид жирэмслэхийг хүсэхгүй байгаа), ЖХАХ-ийн дутагдалтай эмэгтэйчүүд гэдэгт гэр бүлтэй, бэлгийн идэвхитэй амьдралд байгаа, жирэмслэх чадавхитай, ЖХАХ-ийг хэрэглэхгүй байгаа, жирэмслэхээ зогсоохыг хүсч байгаа эмэгтэйчүүдийг хамруулав. Мөн судалгаа явуулж буй үед жирэмсэн байсан боловч жирэмсэн болохыг хүсээгүй байсан, жирэмсэн биш боловч хүүхэдтэй, дахин хүүхэдтэй болохыг хүсэхгүй байгаа эмэгтэйчүүдийг хамруулан авч үзсэн.

ЖХАХ-ийн нийт дутагдаж байгаа хэрэгцээ гэдгийг одоогоор жирэмслэхээс хамгаалах ямар нэгэн арга хэрэглэдэггүй мөртлөө жирэмслэхээ хойшлуулахыг хүсч байгаа, мөн хүүхэд төрүүлэхийг хүсэхгүй байгаа эмэгтэйчүүдийн хэрэгцээний нийлбэр гэж ойлгож болно.

Энэхүү судалгааны ЖХАХ-ийн хэрэглээ болон дутагдаж байгаа хэрэгцээний талаарх мэдээллийг ашиглан ЖХАХ-ийн хангагдсан хэрэгцээний хувийг тооцсон юм. ЖХАХ-ийн хангагдсан хэрэгцээ гэдэг нь нийт гэр бүлтэй эмэгтэйчүүдээс ЖХАХ-ийг хэрэглэж байгаа хувиар тодорхойлогддог. Харин ЖХАХ-ийн нийт хэрэгцээ гэдэг нь судалгаа явагдах үед ЖХАХ-ийн дутагдаж буй хэрэгцээтэй байгаа (жирэмслэхээ хойшлуулах болон зогсоох) болон ЖХАХ хэрэглэж буй эмэгтэйчүүдийн нийлбэр юм.

Хүснэгт РН.2-т ЖХАХ-ийн хэрэглээ, дутагдаж буй хэрэгцээ, хангагдсан хэрэгцээний талаарх судалгааны үр дүнг харуулав. Судалгааны дүнгээс харахад нийт эмэгтэйчүүдийн 14 хувийнх нь ЖХАХ-ийн хэрэгцээ нь хангагдаагүй гэсэн бөгөөд тэдний дийлэнх нь дахин төрөх хүсэлгүй байна. Улмаар, ЖХАХ дутагдаж байгаа эмэгтэйчүүдийн хувь ахимаг буюу 40-өөс дээш насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр байна. Тухайлбал, 40-44 болон 45-49 насны бүлгийн эмэгтэйчүүдийн дунд ЖХАХ-ийн дутагдаж байгаа хэрэгцээтэй эмэгтэйчүүдийн хувь 17 ба 22 хувь байна. Өмнө хөдөөгийн эмэгтэйчүүдийн ЖХАХ-ийн хэрэглээ хотын эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байна гэж тэмдэглэсэн. Гэхдээ дутагдаж байгаа хэрэгцээг авч үзэхэд хот, хөдөөгийн эмэгтэйчүүд бараг ялгаагүй байна. Түүнчлэн, дутагдаж байгаа хэрэгцээтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь боловсрол багатай эмэгтэйчүүдийн дунд илүү өндөр байна. Бүсийн ялгаатай байдлыг харахад дутагдаж байгаа хэрэгцээтэй эмэгтэйчүүд Баруун бүсэд хамгийн өндөр (16 хувь) байгаа бөгөөд үүний дараа Зүүн бүс (15 хувь) орж байна.

Жирэмсэн үеийн хяналт

Төрөхийн өмнөх үе нь жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд болон хүүхдийн эрүүл мэндэд маш чухал нөлөө үзүүлдэг билээ. Үр хөврөлийн өсөлт, хөгжил эхийн эрүүл мэндтэй ямар харилцан хамааралтай байдаг талаарх ойлголт мэдлэг нэмэгдсэн нь жирэмсэн үеийн хяналт эхийн болон хүүхдийн эрүүл мэндэд ямар ач холбогдолтой болохыг ойлгож үүнд ихээхэн анхаарал хандуулдаг болсон. Тухайлбал, жирэмсэн эмэгтэй болон тэдний гэр бүлд жирэмсэн үеийн болон төрөх үеийн хүндрэлийн талаар ойлголт, мэдлэг өгөх нь жирэмсэн үедээ мэргэжлийн эмчийн хяналтанд хамрагдаж улмаар эмчийн хяналтанд төрөх ач холбогдлыг ойлгуулж, жирэмсний хяналтанд хамрагдалтыг нэмэгдүүлдэг.

Түүнчлэн жирэмсний хяналтын үеэр нялхсын эсэн мэнд төрж, өсөхөд нөлөө үзүүлдэг хүчин зүйл болох төрөлт хоорондын зайны талаар мэдлэг мэдээллийг ч мөн олгодог юм. Цус багадалт болон БЗДХ-ыг эрт илрүүлж эмчилснээр эх хүүхдийн эрүүл мэндэд чухал нөлөөллийг үзүүлэх ач холбогдолтой. Цаашилбал, бага жинтэй хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх хосолсон арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ. Үүнд, эхийн хоол тэжээлийн байдлыг дээшлүүлэх, бусад халдвар тухайлбал, БЗДХ авахаас сэргийлэх гэх мэт.

VIII. НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

Мөн сүүлийн үед ХДХВ эхээс хүүхдэд дамжин халдварлахаас сэргийлэхийн тулд жирэмсний хяналтын үеийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах болсон.

Жирэмсэн үеийн хяналтын хэд хэдэн загварыг харьцуулан судалсны үндсэн дээр ДЭМБ-аас жирэмсний хяналтанд доод тал нь 4 удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгодог. Түүнчлэн ДЭМБ жирэмсний хяналтын үед дараах үйлчилгээг үзүүлэхийг удирдамж болгодог. Үүнд:

- Цусны даралт хэмжих
- Шээсний шинжилгээ хийх
- Цусны шинжилгээ хийх
- Биеийн жин/биеийн өндрийг хэмжих зэрэг багтана.

Жирэмсэн үеийн хяналтанд хамрагдах үйл явц Монгол улсад нэлээд өндөр буюу сүүлийн 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь дор хаяж нэг удаа жирэмсэн үеийн хяналтанд хамрагдсан байна. Бүсээр авч үзэхэд Зүүн бүсэд хамрагдалт хамгийн бага буюу 97 хувь байна. Хамрагдалтын түвшинг сонгосон үзүүлэлтээр авч үзэхэд маш бага ялгаатай байна. Харин эмэгтэйчүүдийн насны бүлгээр бага зэрэг ялгаатай байна. Үүнд залуу буюу 15–19 насны эмэгтэйчүүдийн жирэмсэн үеийн хяналтанд хамрагдсан хувь бусад насны бүлгийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад бага буюу 96 хувь байлаа.

Судалгаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрсөн 15–49 насны эмэгтэйчүүдийн жирэмсэн үеийн хяналтанд хамрагдсан байдал болон үйлчилгээг хэн үзүүлсэн болохыг Хүснэгт RH.3–т харуулав. Үр дүнг харахад, бараг бүх эмэгтэйчүүд (99 хувь) эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтанд хамрагдсан байна. Үүнд дийлэнх эмэгтэйчүүд их эмчийн (83 хувь) үүний дараагаар бага эмч/эх баригчийн хяналтанд (13 хувь) хамрагдсан дүн гарчээ. Түүнчлэн боловсролын түвшин өндөр (дээд боловсролтой эмэгтэйчүүдийн 90 хувь), чинээлэг (хамгийн чинээлэг 20 хувийн 96 хувь) болон хотын эмэгтэйчүүд (92 хувь), тэр дундаа Улаанбаатарт оршин суудаг эмэгтэйчүүд (95 хувь) их эмчийн хяналтанд хамрагдах магадлал илүү өндөр байна. Харин бага эмчийн хяналтанд Баруун болон Зүүн бүсийн эмэгтэйчүүд, хөдөө, тэр дундаа алслагдсан хөдөө амьдардаг, бүрэн дундаас бага боловсролтой болон ядуу 40 хувьд багтах эмэгтэйчүүд илүү хамрагдсан байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд ямар төрлийн үйлчилгээ үзүүлснийг Хүснэгт RH.4–т нэгтгэн харуулав. Дээр тайлбарласан үр дүнгээс харахад жирэмсэн үеийн хяналтанд хамрагдалт өндөр, сонгосон үзүүлэлтээр авч үзэхэд ялгаа харьцангуй бага байгаа ч үзүүлж буй үйлчилгээний төрлөөр үзэхэд багагүй ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал жирэмсэн эмэгтэйчүүдийн 89 хувь нь цусны болон шээсний шинжилгээ өгсөнгэж хариулжээ. Эдгээр үйлчилгээний төрөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь Баруун бүсэд хамгийн бага буюу харгалзан 66 ба 67 хувь байна. Түүнчлэн, ядуу эмэгтэйчүүд, боловсролын түвшин доогуур болон хөдөө амьдардаг эмэгтэйчүүдийн цус болон шээсний шинжилгээ өгсөн хувь улсын дундаж болон бусад сонгосон үзүүлэлтийн үр дүнтэй харьцуулахад доогуур байна.

Хүснэгт RH.4–өөс харагдаж буй өөр нэгэн сонирхол татсан зүйл бол биеийн жин хэмжсэн гэсэн хариулт өгсөн эмэгтэйчүүдийн хувь бусад гурван төрлийн үйлчилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувиас хамгийн бага байгаа юм. Харин цусны даралт үзүүлсэн тухай асуултанд эмэгтэйчүүдийн 95–аас дээш хувь хариулсан нь хамгийн түгээмэл үзүүлсэн үйлчилгээний төрөл болж байна.

Төрөх үеийн тусламж

Эхийн эндэгдлийн дөрөвний гурав нь жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалдаг. Төрөлтийг эх барих чадвартай эмнэлгийн ажилтан эх барих, шаардлага гарвал эх барихын яаралтай тусламж үзүүлэхэд унааны боломжтой байдал нь эсэн

мэнд амаржихуйн үндсэн чухал зүйл юм. “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” тунхаглалын зорилго нь эмэгтэйчүүдийг төрөх үедээ эмнэлгийн мэргэжлийн хүний хяналтанд байх боломжоор хангахыг баталгаажуулах явдал юм. Үүнийг төрөх үедээ эмнэлгийн мэргэжлийн ажилтнаас тусламж авсан эхчүүдийн хувь, мөн эмнэлгийн төрөлтийн хувийн жингийн үзүүлэлтээр тодорхойлдог. 1990–2015 оны хооронд эхийн эндэгдлийг 1990 оны түвшнээс дөрөвний гурваар бууруулах Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийг хянахад эмнэлгийн мэргэшсэн ажилтны тусламжтай төрсөн эхчүүдийн хувь гэсэн энэ үзүүлэлтийг мөн ашигладаг.

Мэргэжлийн ажилтны тусламжтай төрөлтийн талаарх мэдээллийг гаргахын тулд энэхүү судалгаанд нэлээд олон төрлийн асуултуудыг оруулсан юм. Энд эмч, эх баригч нарыг мэргэжлийн ажилтнуудад багтаан үздэг.

Судалгаа явуулахаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 99 хувь нь эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудын хяналтанд хүүхдээ төрүүлсэн байна (Хүснэгт RH.5). Нийт төрөлтийн 70 хувь нь их эмчийн, 29 хувь нь бага эмч/эх баригчийн хяналтанд явагдсан байна. Бүс нутаг болон хот, хөдөөгөөр зарим ялгаа ажиглагдаж байв. Тухайлбал, их эмчийн хяналтанд хүүхдээ төрүүлсэн эхчүүдийн хувь Улаанбаатарт хамгийн өндөр буюу 80 хувь байхад Баруун бүсэд хамгийн бага буюу 58 хувь байлаа. Мөн хотын эмэгтэйчүүд их эмчийн хяналтанд төрөх нь илүү түгээмэл байна. Түүнчлэн боловсролын түвшин өндөр болон чинээлэг эмэгтэйчүүдийн их эмчийн хяналтанд төрсөн хувь харьцангуй өндөр байна.

IX

Хүүхдийн амьдралын эхний 3–4 жилд тархи, ой ухаан хамгийн хурдан хөгждөг байна. Иймд энэ үед гэр бүлийн зүгээс үзүүлэх халамж, дэмжлэг нь хүүхдийн хөгжлийг тодорхойлох гол хүчин зүйл болдог билээ. Үүнтэй холбогдон томчуудын зүгээс хүүхэдтэйгээ ажиллах, зөв төлөвшүүлэх, хүүхдийг халамжлах нөхцлийг бий болгох зэрэг нь гэр орны зүгээс хүүхдэд тавьж буй халамжийн чанарыг хэмжих чухал үзүүлэлт болдог байна. Хүүхдэд Ээлтэй Дэлхий Ертөнц тунхаглалын зорилтод “Хүүхэд бие эрүүл, ухаан саруул, сэтгэл санааны дарамтгүй, аюулгүй, нийгмийн талын чадавхитай, сурч мэдэхэд бэлэн байх ёстой” гэсэн байдаг.

Энэ удаагийн судалгаагаар хүүхдийг багаас нь зөв төлөвшүүлэхэд бэлтгэж, дэмжлэг үзүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулсан юм. Судалгаагаар хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд томчуудын зүгээс хэрхэн оролцож буй талаарх мэдээлэл юуны өмнө ном унших эсвэл номын зургийг тайлбарлаж өгөх, үлгэр ярьж өгөх, дуу дуулах, хүүхдийг гадуур авч гарах, хүүхэдтэйгээ тоглох, тоо тоолох, зураг зурах, юмыг зааж нэрлэх зэрэг үйл ажиллагааг хамруулан тодотгосон болно.

Судалгааны өмнөх 3 өдөрт 5 хүртэлх насны хүүхдүүдийн 55 хувийнх нь гэр бүлийн гишүүд, томчууд тэднийг сургах, сургуульд бэлтгэхэд 4 болон түүнээс дээш үйл ажиллагаа явуулж, дэмжлэг үзүүлсэн байна (Хүснэгт CD.1).

Гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдүүдэд анхаарал тавин, дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны дундаж тоо 4 байна. Хүснэгтээс харахад хүүхдүүдтэйгээ ажиллахад эцгийн оролцоо харьцангуй бага байв. Эцэг нь хүүхдээ суралцах, сургуульд бэлтгэхэд нэг ба түүнээс дээш үйл ажиллагаанд оролцсон хүүхдийн хувь 44 байна. Тав хүртэлх насны 5 хүүхэд тутмын нэг нь эцэгтэйгээ хамт нэг гэрт хамт амьдардаггүй байна. Томчуудын зүгээс хүүхдүүдээ дэмжиж хамтран ажиллахад хүйсийн ялгаатай байдал ажиглагдаагүй боловч эцэг нь эрэгтэй хүүхэдтэйгээ (45 хувь) эмэгтэй хүүхдүүдээсээ (42 хувь) арай илүү их ажилладаг байна. Хүүхдүүдийг суралцах, сургуульд бэлтгэхэд томчуудын зүгээс анхаарал халамж тавьж дэмжих нь хотод (58 хувь) хөдөөнөөс (52 хувь) илүү байна.

Хүүхэддээ тавьж буй халамж, дэмжлэгийг өрхийн шинж байдлаар үзэхэд нилээд ялгаатай байна. Хүүхэдтэйгээ ажиллаж, дэмжих нь Төвийн бүсэд (60 хувь) хамгийн өндөр байхад Зүүн бүсэд (49 хувь) хүүхэддээ тавих анхаарал хамгийн сул байна. Чинээлэг амьдралтай өрхүүд хүүхэддээ (60 хувь) илүү анхаарал тавьдаг бол ядуу өрхийн хүүхдүүдийн 46 хувь нь л эцэг, эхийн зүгээс дэмжлэг авдаг байна. Мөн эцгийн зүгээс хүүхэддээ тавих анхаарал, дэмжлэг үзүүлж буй байдалд зарим ялгаа харагдаж байна. Жишээ нь хөдөөгийн болон Баруун бүсийн өрхүүдийн хувьд аавуудын оролцоо илүү байв. Түүнчлэн, хүүхэддээ тавих анхаарал, дэмжлэг эцэг, эхийн боловсрол болон амьжиргааны түвшин дээшлэх тутам илүү сайн байгаа хандлага ажиглагдаж байна.

Хүүхэд гэртээ номтой байх нь тэднийг сургуульд суралцахад төдийгүй оюун ухааны чадамжид чухал нөлөөлдөг зүйл юм.

Монгол Улсад 5 хүртэлх насны хүүхдүүдийн 53 хувь гэртээ 3 ба түүнээс дээш тооны хүүхдийн бус номтой өрхөд амьдарч байна (Хүснэгт CD.2). Харин энэ насны хүүхдүүдийн дөнгөж 26 хувийнх нь гэрт 3 ба түүнээс дээш тооны хүүхдэд зориулагдсан ном бий гэж хариулжээ. Өрхөд байгаа хүүхдийн бус номын голч тоо 4 байхад хүүхдэд зориулсан номын голч тоо 0 байна.

Хотын хүүхдүүдийн хувьд хүүхдийн болон хүүхдийн бус номтой харьцах боломж хөдөөгийнхнөөс илүү өндөр байна. Энэ насны хотын хүүхдүүдийн 63 хувь 3 ба түүнээс олон хүүхдийн бус номтой өрхөд амьдардаг байхад хөдөөгийн хүүхдүүдийн 42 хувь 3 ба түүнээс олон хүүхдийн бус номтой өрхөд амьдардаг гэжээ. Харин 5 хүртэлх насны хүүхэдтэй гурваас дээш хүүхдийн номтой өрхийн эзлэх хувь хотод 36 хөдөөд 16 хувь байв. Өрхөд байгаа хүүхдэд зориулсан болон хүүхдийн бус номны тоо нь хүүхдийн настай эерэг хамааралтай байна. 24–59 сартай хүүхдүүдтэй өрхийн 55 хувь нь 3 ба түүнээс дээш хүүхдийн бус номтой байхад энэ үзүүлэлт 2 хүртэлх насны хүүхэдтэй өрхүүдийн хувьд 50 хувь байна. Хүүхдийн номтой өрхүүдийн хувьд илүү их ялгаатай байна.

Хүснэгт CD.2–оос харахад 2 хүртэлх насны хүүхдүүдийн дөнгөж 4 хувь нь гурав ба түүнээс олон төрлийн тоглоомтой, 8 хувь нь тэдний эх, асрамжлагчийн хариулснаар ямар ч тоглоомгүй ажээ. Тус судалгаанд тоглоом гэдэгт гэрийн эд зүйлс (аяга, таваг, ваар, цэцгийн сав г.м), гэрийн гадна байгаа эд зүйлс (саваа мод, чулуу, юмны сав г.м), гэртээ хийсэн тоглоом, дэлгүүрээс худалдаж авсан тоглоомыг хамруулсан. Сонирхолтой нь хүүхдүүдийн 82 хувь нь дэлгүүрээс авсан тоглоомоор тоглодог бол үлдэх 26–аас бага хувь нь бусад тоглоомоор тоглодог байна. Эрэгтэй хүүхдүүдийн 7 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 5 хувь нь 3 ба түүнээс олон төрлийн тоглоомтой байна. Бас нэг анхаарал татсан зүйл бол хөдөөгийн хүүхдүүдийн 8 хувь нь 3 ба түүнээс олон төрлийн тоглоомтой байхад хотын хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт дөнгөж 4 хувь байгаа нь тэдэнд тоглоомыг орлох өөр хүчин зүйл хөдөөгийнхөөс илүү байдагтай холбоотой байж болох юм. Баруун бүсэд 3 ба түүнээс дээш тоглох зүйлтэй хүүхдийн хувь 12 байхад Зүүн бүсэд хамгийн бага буюу дөнгөж 1 хувь, харин нийслэл Улаанбаатарт 3 хувь байна.

Бага насны хүүхдийг ганцааранг нь болон хүүхдээр харуулж үлдээх нь тэдний гэмтэх, ахуйн осолд өртөх эрсдэлийг ихэсгэдэг. Хүүхэд хөгжил судалгаанд судалгааны өмнөх 7 хоногт 5 хүртэлх насны хүүхдээ гэртээ ганцааранг нь эсвэл 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжинд үлдээсэн эсэхийг хүүхдийн эх, асрамжлагчаас асуусан.

Хүснэгт CD.3–аас харахад, 5 хүртэлх насны хүүхдийн 12 хувийг гэрт нь 10 нас хүрээгүй хүүхдийн асрамжинд, 3 хувийг ганцааранг нь үлдээжээ. Эдгээр үзүүлэлтийг нэгтгэн тооцоо хийхэд нийт хүүхдийн 13 хувь нь судалгаанаас өмнөх 7 хоногт насанд хүрсэн хүний хараа хяналтгүй (зохих хяналтгүй) үлдсэн байна. Хүйсээр болон хот, хөдөөгөөр ялгаа бага байна.

Харин насанд хүрсэн хүний хараа хяналтгүйгээр гэртээ үлдсэн хүүхдийг хүүхдийн нас, эхийн боловсролын түвшингээр авч үзвэл бараг ялгаагүй байна. Харин бүс нутаг болон өрхийн аж байдлаар нилээд ялгаатай байна. Тухайлбал Баруун бүсэд тав хүртэлх насны таван хүүхэд тутмын нэг нь насанд хүрсэн хүний хяналтгүй үлдсэн байхад Улаанбаатарт энэ үзүүлэлт хоёр дахин бага 9 орчим хувь байна. Өрхийн аж байдал доогуур байх тусам хүүхдийг зохих хяналтгүй үлдээх нь нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Аж байдлаар хамгийн ядуу өрхийн зургаан хүүхэд тутмын нэг нь, харин чинээлэг өрхийн 12 хүүхэд тутмын нэг нь судалгаанаас өмнөх 7 хоногт зохих хяналтгүй үлдсэн байна.

Х

Сургуулийн өмнөх боловсрол



Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын байгууллагуудын хэрэглэж байгаа боловсролын хөтөлбөр хүүхдийг сургуульд орох бэлтгэлийг хангахад чухал түлхэц өгдөг. Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд бага насны хүүхдийг сургах системийг бэхжүүлэх зорилт дэвшүүлсэн байдаг.

Хүүхэд хөгжил 2005 судалгааны дүнгээс үзэхэд 36–59 сартай нийт хүүхдийн 37 хувь нь сургуулийн өмнөх боловсролд (цэцэрлэгт) хамрагдсан байна (Хүснэгт ED.1). Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын байдал хот, хөдөөгөөр болон бүс нутгаар нэлээд ялгаатай байна. Хөдөөгийн хүүхдүүдийн 25 хувь нь энэ хөтөлбөрт хамрагдаж

байхад хотын хүүхдүүдийн 50 хувь нь хамрагджээ.

Өрхийн байршлаар авч үзвэл хөдөөгийн 36–59 сартай хүүхдүүдийн 20 хувь нь энэ хөтөлбөрт хамрагдаж байхад сумын төвд 43 хувь, аймгийн төвд 52 хувь, нийслэл хотод энэ үзүүлэлт 48 хувьтай байна. Энэ нь хот, суурин газарт амьдарч байгаа хүүхдүүдэд дээрх хөтөлбөрт хамрагдах боломж илүү байгааг харуулж байна.

Сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдүүдийн хувьд хүйсийн ялгаа бараг байхгүй, харин өрхийн аж байдлаар авч үзвэл дээрх хамрагдалтын хувь нэлээд ялгаатай (хүснэгт ED.1) байна. Судалгаанд хамрагдсан чинээлэг өрхийн 36–59 сартай хүүхдүүдийн 73 хувь нь сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт хамрагдсан байхад ядуу өрхийн хүүхдүүдийн дөнгөж 11 хувь нь хамрагджээ.

Судалгааны дүнгээс харахад дээд боловсролтой эхийн хүүхдүүд энэ хөтөлбөрт хамрагдах нь бага боловсролтой эхийнхээс бараг 4 дахин их байна. Энэ нь эхийн боловсрол дээшлэх тусам бага насны хүүхэддээ боловсрол олгоход илүү их анхаарал тавьдгийг харуулж байна. Мөн 36–47 сартай хүүхдүүдийн 31 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байхад 48–59 сартай хүүхдүүдийн 43 хувь нь хамрагдаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 1–р ангийн сурагчдаас өмнөх хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн эзлэх хувийг хүснэгт ED.1–д харуулав. Энэ нь хүүхэд сургуульд суралцахад хэрхэн бэлтгэгдсэнийг илэрхийлэх үзүүлэлт юм. 1–р ангийн сурагчдын 81 хувь нь сургуулийн өмнөх боловсрол олгох ямар нэг хөтөлбөрт хамрагдсан байна. Энэ үзүүлэлт хөвгүүдийн хувьд 82 хувь байхад охидын хувьд 79 хувь байна. Аймгийн төв, нийслэлд амьдардаг 1–р ангид суралцагчдын 80–92 хувь нь дээрх хөтөлбөрт хамрагдсан бол хөдөөгийн хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт нь 73 хувь байна. Энэ үзүүлэлтийг бүс нутгаар авч үзвэл Улаанбаатарт хамгийн өндөр буюу 92 хувь байхад Хангай болон Төвийн бүсэд 70–73 хувь байна. Өрхийн аж байдлаар авч

үзвэл сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь ядуу ба чинээлэг бүлэгт хамаарах өрхийн хүүхдийн хувьд 68–91 хувийн хооронд байна.

Бага болон дунд сургуульд хамрагдалт

Хүүхдэд суурь боловсрол олгох нь Мянганы хөгжлийн зорилт болон Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалын нэн чухал зорилтын нэг юм. Боловсрол нь ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, хүүхдийг хөдөлмөр, түүний аюултай тэвчишгүй хэлбэр болон хүчирхийллээс хамгаалах, ардчилал, хүний эрхийг хангах, хүн амын өсөлтөд нөлөөлж байгаа хүрээлэн буй орчныг хамгаалах чухал нөхцөл билээ.

Бага болон дунд сургуульд хамрагдалтыг хянах үзүүлэлтүүдэд:

- ✦ Бага сургуульд элсэлтийн цэвэр жин
- ✦ Бага сургуульд хамрагдалтын цэвэр жин
- ✦ Дунд сургуульд хамрагдалтын цэвэр жин
- ✦ Дунд сургуулийн насны хүүхдийн бага сургуульд хамрагдалтын цэвэр жин
- ✦ Боловсрол дахь охид, хөвгүүдийн харьцаа (жендерийн тэгш байдлын индекс)

Сурах явцыг хянах үзүүлэлтүүдэд:

- ✦ 5–р анги хүртэл суралцсан хүүхдийн эзлэх хувь
- ✦ Дунд сургуульд дэвшин суралцсан хүүхдийн эзлэх хувь
- ✦ Бага сургууль төгсөлтийн цэвэр жин зэргийг хамруулан авч үзлээ.

Монгол Улсад ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа 2005–2006 оны хичээлийн жилээс 11 жилийн тогтолцоонд шилжсэн. Ингэснээр ЕБС–д 7 настай хүүхдийг элсүүлэн суралцуулах болов. “Хүүхэд хөгжил 2005” судалгааны дүнгээс харахад (хүснэгт ED.2) бага сургуульд 7 настай элсэгчдийн эзлэх хувийн жин 80 хувь байна. Бага сургуульд 7 настай охидын 82 хувь нь, хөвгүүдийн 78 хувь нь элсэн суралцсан байна.

ЕБС–д элсэгчдийг бүсээр авч үзвэл Төвийн бүсэд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 88 хувь байгаа бол Баруун бүсэд 73 хувьтай байна.

Бага сургуульд хамрагдалтын цэвэр жинг хүснэгт ED.3–т харуулав. Судалгаанд хамрагдсан бага ангид суралцах насны хүүхдийн 95 хувь нь сургуульд хамрагдсан байна

Бага сургуульд суралцагчдын цэвэр жин охидын хувьд 96 хувь, хөвгүүдийн хувьд 94 хувь байна.

Баруун бүсэд амьдарч буй хүүхдийн бага ангид хамрагдалт 92 хувь байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага, хөдөө амьдарч буй хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 93 хувь байгаа нь нийслэл хот, аймгийн төв, сумын төвийнхтэй харьцуулахад доогуур байна. Сургуульд хамрагдалтыг өрхийн аж байдлаар авч үзэхэд чинээлэг өрхийн хүүхдийн 98 хувь нь бага сургуульд хамрагдаж байхад ядуу өрхийн хүүхдийн 93 хувь нь хамрагдсан байна. Энэ нь Монгол Улсын боловсролын мастер төлөвлөгөөнд “Хүүхдийн сурч боловсрох эрхийг хамгаалж, бүх хүүхдэд чанартай бага, дунд боловсрол эзэмших бололцоо нөхцлийг бий болгоно” гэж заасан заалт үр дүнтэй хэрэгжиж байгааг харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад сургуульд хамрагдалтын түвшингээр сумын төвд амьдарч буй хөвгүүд (98 хувь) болон хөдөө амьдарч буй хөвгүүд (92 хувь)–ийн хооронд нэлээд

Х. ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ

ялгаа байна. Охидын сургуульд хамрагдалт өрхийн байршлын хувьд хөвгүүдийнхээс бага зэрэг илүү байна.

Дунд сургуульд хамрагдсан байдлыг хүснэгт ED.4-д харуулав. Боловсролын шинэ тогтолцоогоор энэ нь 6–9-р ангид суралцагчдад хамааралтай болно. Судалгааны дүнгээс үзэхэд дунд сургуульд суралцах насны хүүхдүүдийн 85 хувь нь зохих шатны сургуульд хамрагдан суралцаж байна. Энэ үзүүлэлт нь бага сургуульд хамрагдалтын түвшингээс 10 орчим пунктээр доогуур байна. Нийслэл хотын хүүхдүүдийн 91 хувь нь дунд сургуульд хамрагдаж байгаа бол хөдөөгийн хүүхдүүдийн хувьд энэ нь 74 хувьтай байна. Хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүдийн 26 хувь нь дунд сургуульд хамрагдахгүй байгаагийн шалтгааныг малчин өрхүүд хүүхдээ сургуулиас гарган авч, мал маллах ажилдаа туслуулж байна гэж дүгнэж болох юм. Энэ хүснэгтээс дээрх дүгнэлтийг баталгаажуулж буй бас нэг үзүүлэлт нь 12 настай (бага сургууль төгсөх нас) хүүхдүүдийн сургуульд хамрагдалт бусад насны хүүхдүүдийнхээс хамгийн бага буюу 77 хувь байгаа явдал юм. Монголын Хүний хөгжлийн илтгэлд тодорхойлсноор хөвгүүдийн сургууль завсардаж байгаа хамгийн гол шалтгаан нь малчин өрхүүд хүүхдээ сургуулиас гаргах явдал ихэссэн, нөгөө талаас мэргэжлийн сургалтын төвүүдийн үйл ажиллагаа бараг л байхгүй болоод байгаа зэргээс үндсэндээ хамаарсан байх талтай⁵.

Дунд сургуульд хамрагдалтын цэвэр жин охидын хувьд (88 хувь) хөвгүүдийнхээс (83 хувь) дээгүүр байна. Түүнчлэн дунд сургуульд хамрагдалтын цэвэр жин Улаанбаатарт 91 хувь байхад бусад бүсүүдэд 80–84 хувь байна.

Энэ үзүүлэлтийг өрхийн аж байдлаар авч үзэхэд чинээлэг өрхийн дунд сургуульд суралцах насны хүүхдийн 96 хувь нь сургуульд хамрагдаж байхад ядуу өрхийн хүүхдийн 67 хувь нь хамрагдаж байна.

1-р ангид элсээд 5-р анги хүртэл суралцсан хүүхдүүдийг анги дэвшилт бүрээр нь харьцуулсан хувийг хүснэгт ED.5-д харуулав. Судалгааны ажилтнууд судалгаанд хамрагдсан өрхийн тухайн насны хүүхдүүд судалгаа явагдах үед сургуульд хамрагдсан эсэх, өмнөх жилд хэддүгээр ангид сурч байсан зэргийн талаар асуулт асууж мэдээллийг цуглуулсан юм.

Судалгааны дүнгээс харахад бага сургуулийн нэгдүгээр ангид элсэн орсон хүүхдүүдийн 96 хувь нь 5 дугаар ангид дэвшин суралцаж байгаагаас хотод энэ үзүүлэлт 99 хувьтай байгаа бол хөдөөд 94 хувь байна. Харин хүйсийн хувьд онцгой ялгаа байхгүй, өрхийн аж байдлын хувьд нь авч үзвэл чинээлэг өрхийн хүүхдүүд 5 дугаар ангид 100 хувь дэвшин суралцаж байгаа бол ядуу өрхийн хүүхдүүдийн 91 хувь нь 5-р ангид дэвшин суралцжээ.

Бага сургууль төгсөлтийн цэвэр жин болон дунд сургуульд дэвшин суралцсан хүүхдийн эзлэх хувийг хүснэгт ED.6-д харуулав. Бага сургууль төгсөх насны (11 настай) хүүхдүүдийн 94 хувь нь бага сургуулиа дүүргэсэн байна. Энэ үзүүлэлт нь охидын хувьд 95 хувь, хөвгүүдийн хувьд 92 хувь байна. Харин өмнөх жилд бага сургуулийн төгсөх ангид сурч байсан хүүхдүүдийн 98.4 хувь нь дунд сургуульд дэвшин суралцсан байна. Энэ үзүүлэлтийн хувьд хүйс, бүс нутаг болон байршлаар ялгаа төдийлөн ажиглагдахгүй байна.

Бага болон дунд боловсролын сургуульд суралцагч охид, хөвгүүдийн харьцааг хүснэгт ED.7-д үзүүлэв. Энэ харьцааг хүйсийн тэгш байдлын индекс гэж нэрлэдэг.

Бага сургуульд хөвгүүдийн 94 хувь нь хамрагдаж байхад охидын 96 хувь нь хамрагдсан байна. Боловсролын шат ахих тусам хөвгүүдийн тоо цөөрч байна. Ерөнхий боловсролын дунд сургуульд хөвгүүдийн 83 хувь, охидын 88 хувь нь хамрагдаж байна. Суралцагчдын хүйсийн тэгш байдлын индексийг тооцохдоо охидын сургуульд хамрагдалтын цэвэр жинг

⁵Монголын Хүний хөгжлийн илтгэл, НҮБХХ, Монгол Улсын Засгийн газар, 2003

Х. ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ

хөвгүүдийн хамрагдалтын цэвэр жинд харьцуулж тооцдог. Өөрөөр хэлбэл энэ харьцаа 1–д ойр байх тутам охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшин ойролцоо байна гэсэн үг. Жендерийн тэгш байдлын индекс бага сургуулийн хувьд 1.02, харин дунд сургуулийн хувьд 1.07 байна. Энэ нь бага (дунд) сургуулийн 100 эрэгтэй сурагчид 102 (107) эмэгтэй сурагч ногдож байгааг харуулж байна.

Хүн амын бичиг үсгийн мэдлэг

Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал болон Мянганы хөгжлийн зорилтын чухал үзүүлэлтийн нэг нь хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин юм.

“Хүүхэд хөгжил 2005” судалгаанд зөвхөн эмэгтэйчүүд хамрагдсан учраас бичиг үсгийн мэдлэгийг тооцохдоо 15–24 насны эмэгтэйчүүдийн мэдээлэл дээр үндэслэсэн болно. Бичиг үсгийн мэдлэгийг дээрхи насны эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтыг асууж, сургуульд огт сурч байгаагүй эсвэл бага боловсрол эзэмшээгүй эмэгтэйчүүдээс асуулганд байгаа богино хэмжээний өгүүлбэрийг уншиж чадаж байгаа эсэхийг шалгах аргаар тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан 15–24 насны эмэгтэйчүүдийн 95 хувь нь бичиг үсэг мэддэг гэсэн дүн гарч байна (Хүснэгт ED.8).

XI

Төрсний бүртгэл

Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцид хүүхэд бүр нэр авах, яс үндсээ тогтоолгох, бие хүнийх нь бодит байдлыг үгүйсгэхээс хамгаалуулах эрхтэй гэдгийг тунхагласан билээ. Төрсний бүртгэл нь хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн хэрэгсэл болдог.

Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунахаглалд хүүхэд бүрийг төрөхөд нь буюу төрснийх нь дараахан бүртгэж, үндэсний болон олон улсын зохих баримт бичгийн дагуу нэртэй, иргэний харьяалалтай болох эрхийг нь хангах системийг бий болгох зорилтыг дэвшүүлсэн байдаг. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хянах үзүүлэлт нь төрснийг нь бүртгэсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь юм.

Хүснэгт CP.1–д тав хүртэлх насны хүүхдийн төрөлтийг бүртгэсэн байдлыг хүйс, нас, эхийн боловсролын түвшин, өрхийн байршлаар үзүүллээ. Хүснэгтээс харахад тав хүртэлх насны хүүхдийн 98 хувь нь бүртгүүлж төрсний гэрчилгээ авсан байна.

Судалгаанд хамрагдсан 0–59 сартай хүүхдийн эх/асрамжлагч нь хүүхдийн төрсний гэрчилгээг судалгааны ажилтанд үзүүлсэн (86 хувь) болон үзүүлээгүй боловч гэрчилгээгээ авсан гэж хариулсан (13 хувь) мэдээллийн үндсэн дээр энэ үзүүлэлтийг тодорхойлов.

“Иргэний бүртгэлийн тухай” хуульд зааснаар хүүхдийг төрснөөс хойш төв, суурин газарт 15 хоног, алслагдсан сум, багт 30 хоногийн дотор бүртгүүлэх ёстой. Хүүхдээ бүртгүүлж гэрчилгээ авсан байдлыг өрхийн байршлаар авч үзэхэд бараг ялгаагүй (98 хувь) байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Хүүхдийн эрхийг хамгаалах конвенцийн 32 дугаар зүйлд: “Конвенцид нэгдсэн гишүүн улсууд хүүхдийг эдийн засгийн аливаа мөлжлөг, нэн ялангуяа түүнд хор хохирол учруулсан болон хүүхдийн боловсрол эзэмших үйл явцад саад тотгор болж буй аливаа ажил, хөдөлмөр эсвэл хүүхдийн эрүүл мэнд, бие болон оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахууны өсөлт, эсвэл нийгэмшлийн хөгжилд хор учруулсан хөдөлмөр эрхлэхээс хамгаалагдсан байх хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч байна...” хэмээн заасан байдаг. Мөн Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд хүүхдийн хөдөлмөр эрхлэхтэй тэмцэх 9 стратегийг дэвшүүлсэн. Монгол Улс 1999 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай НҮБ–ын 182 дугаар конвенцид нэгдсэнээр энэ чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдаж, тодорхой үйл ажиллагааг явуулж байна. Иймд “Хүүхэд хөгжил 2005” судалгааны асуулгад хүүхдийн хөдөлмөртэй холбогдсон, тухайлбал, 5–17 насны хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үйл ажиллагаатай холбогдолтой хэд хэдэн асуултыг оруулсан юм.

Судалгааны асуулга авах үед буюу эсвэл түүний өмнөх долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үзэхээр судалгаанд заасан. Үүнд:

- ✦ 5–11 насны хүүхдийн хувьд долоо хоногт эдийн засгийн зорилгоор наад зах нь нэг цагийн хөдөлмөр эрхэлсэн эсвэл 28 цагаас дээш цагаар гэрийн ажилд тусалсан буюу гэрийн ажил хийсэн хүүхэд;

XI. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

- ✦ 12–17 насны хүүхдийн хувьд долоо хоногт эдийн засгийн зорилгоор наад зах нь 14 цагийн хөдөлмөр эрхэлсэн, эсвэл 28 цагаас дээш цагаар гэрийн ажилд тусалсан буюу гэрийн ажил хийсэн хүүхэд;

Хүүхдэд үл тохирох ажил, хөдөлмөрийн төрлийг тодорхойлох зорилготойгоор хүүхдийн хийдэг ажлаас хүүхдийн хөдөлмөрийг тусад нь зааглан ялгахад чиглэсэн тодорхойлолтыг судалгаанд авч хэрэглэв. Тиймээс энд толилуулж буй тооцооллын аргачлал нь хүүхдийн хөдөлмөрийн хүрээнд давамгайлж буй наад захын доод хязгаарт тулгуурлахыг оролдсон.

Судалгаанд хамрагдсан 5–17 насны нийт хүүхдийн 84 хувь нь гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж байгаа нь “Хүүхэд хөгжил 2000” болон 2002–2003 онд явагдсан Монголын хүүхдийн хөдөлмөрийн анхны түүвэр судалгааны дүнтэй ойролцоо гарсан байна (Зураг XI.1). Охидууд хөвгүүдээс илүүтэйгээр гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг XI.1. 5-17 насны нийт хүүхдэд гэрийн ажилд тусалж байгаа хүүхдийн эзлэх хувь, хүйсээр, Монгол Улс, 2005 он



“Хүүхэд хөгжил 2005” судалгааны дүнгээр 5–17 насны нийт хүүхдээс сүүлийн 7 хоногт өрхөөс гадуур ажил хөдөлмөр эрхэлсэн, гэрийнхээ ажилд тусалсан, өөрийн өрхийн аж ахуй, бизнесийн ажилд тусалсан хүүхдийн тоог ангилан хүснэгт CP.2.2–т харууллаа.

Судалгаанд хамрагдсан 5–17 насны нийт хүүхдүүдийн 24 хувь нь ямар нэг ажил хөдөлмөр буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн дотор хүүхдийн нас болон долоо хоногт ажилласан цагийг үндэслэн тооцсон тооцоогоор эдгээр хүүхдийн 22 хувь нь хүүхдийн хөдөлмөр/багасгасан/ эрхэлж

байна⁶. 2002–2003 онд явуулсан Монголын хүүхдийн хөдөлмөрийн анхны түүвэр судалгааны дүнгээс харьцангуй өндөр (тус судалгаагаар судалгаанд хамрагдсан 5–17 насны нийт хүүхдийн 10.1 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа, эдгээрээс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138,182 дугаар конвенцийн зөвлөмжийн дагуу тооцсоноор нийт хүүхдийн 5.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байна гэсэн дүн гарсан) гарч байгаа нь хүүхдийн хөдөлмөрийг тооцож буй аргачлал, үүний дотор эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажилд долоо хоногт 28 цаг ба түүнээс дээш цагаар тусалсан хүүхдийг оруулж тооцсонтой холбоотой юм. Харин судалгааны дүнгээр өрхөөс гадуур хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн 5–14 насны хүүхдийн эзлэх хувь 1.3 хувь байгаа нь “Хүүхэд хөгжил 2000” судалгааны үр дүнтэй ойролцоо /1.4 хувь/ байна.

Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг насны бүлгээр авч үзэхэд 5–11 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дунджаас 7.5 пунктээр бага, харин 12–14 болон 15–17 насныхан улсын дунджаас 3–13 пунктээр илүү байна. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд хүйсийн ялгаа бараг байхгүй, охидын хөдөлмөр эрхлэлт хөвгүүдийнхтэй ойролцоо байна.

⁶“Хүүхэд хөгжил 2005” судалгааны хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоог тооцож байгаа аргачлал, арга зүй “Хүүхэд хөгжил 2000” болон 2002–2003 онд явагдсан Монголын хүүхдийн хөдөлмөрийн анхны түүвэр судалгааныхаас ялгаатай байгаа тул харьцуулахдаа болгоомжтой хандах хэрэгтэй.

XI. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Судалгаагаар 5–17 насны хүүхдийн 0.6 хувь нь гэрээсээ гадуур хөлстэй хөдөлмөр, 1.0 хувь нь хөлсгүй хөдөлмөр, 9 хувь нь өөрийн өрхийн аж ахуй, бизнесийн ажилд орлцож, 14 хувь нь долоо хоногт 28 ба түүнээс дээш цагаар гэрийн ажилд тусалдаг байна. Гэрээсээ гадуур хөлстэй хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн эзлэх хувь хот, хөдөөд адилхан 0.6 хувьтай, харин гэрээсээ гадуур хөлсгүй хөдөлмөр эрхэлдэг хөдөөгийн хүүхдийн эзлэх хувь хотынхоос 1.2 пунктээр илүү байна (Зураг XI.2).

Өрхийнхөө аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцогч хүүхдийн хөдөлмөр эрхлэлт хот, хөдөөгөөр үлэмж ялгаатай, хотод 2.4 хувь байхад хөдөөд 17 хувьтай байна. Долоо хоногт 28 ба түүнээс дээш цагаар гэрийнхээ ажилд тусалдаг хотын хүүхдийн эзлэх хувь хөдөөгийнхөөс 6 пунктээр бага байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа 5–17 насны хүүхдийн эзлэх хувь бүс нутгаар ихээхэн ялгаатай байна. Тухайлбал Хангайн бүсэд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр 34 хувьтай байхад Улаанбаатар хотод хамгийн бага буюу 11 хувь байна.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд эхийнх нь боловсролын түвшин тэр бүр нөлөөлөхгүй байгаа бөгөөд харин өрхийн аж байдлын түвшинтэй нилээд холбоотой байгаа нь ажиглагдаж байна. Ядуу амьдралтай гурван өрх тутмын, харин чинээлэг арван өрх тутмын нэг өрхийн хүүхэд хөдөлмөр эрхэлж байна.

Хүснэгт CP.3–т хөдөлмөр эрхэлж буй сурагч ба сургуульд суралцахын зэрэгцээ хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг харуулсан болно. Хөдөлмөрлөж буй сурагч хүүхэд гэдэгт судалгаа авч байх үед сургуульд суралцахын зэрэгцээ хүүхдийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд татагдан орсон хүүхдийг хамааруулав. 5–17 насны сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн 21 хувь нь хөдөлмөр эрхэлж байна⁷. Сургуульд суралцахын зэрэгцээ хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь хөдөөд харьцангуй өндөр буюу улсын дунджаас 9 пунктээр илүү, харин хотод улсын дунджаас 6 пунктээр доогуур байна.

Хүүхдийн хүмүүжил

“Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” баримт бичигт хүүхэд хүчирхийллийн бүхий л хэлбэрээс хамгаалагдсан байх ёстой...” гэж заасан ба Мянганы Тунхаглалд хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалагдсан байхыг уриалсан билээ. Судалгаанд хүүхэд сахилга бат алдах үед эцэг, эхчүүд тэднийг хүмүүжүүлэх ямар арга замыг сонгон хэрэглэдэг талаар 2–14 настай хүүхдийн эх асрамжлагчдаас хэд хэдэн асуулт асууж тодруулсан.

Хүүхдийн хүмүүжил гэсэн бүлэгт 2–14 насны нэг хүүхдийг өрхөөс санамсаргүйгээр сонгон авч (өрхөд энэ насны нэгээс дээш хүүхэд байгаа тохиолдолд) хамааруулсныг тэмдэглэх хэрэгтэй.

Хүүхдийн хүмүүжлийн талаарх үзэл бодлыг харуулахын тулд 1) бие махбодийн ямар нэг шийтгэл хүлээсэн болон сэтгэл зүйн дарамтанд өртсөн 2–14 насны хүүхдийн тоо 2) хүүхдийг зөв хүмүүжилтэй хүн болгон өсгөхийн тулд тэднийг бие махбодын хувьд шийтгэж болно гэж үздэг 2–14 настай хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдын тоо гэсэн

Зураг XI.2. 5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хот хөдөөгөөр, Монгол Улс, 2005 он



⁷ХХС 2005–ын хөдөлмөр эрхэлж буй тодорхойлолтоор

үзүүлэлтийг ашиглав.

Сүүлийн нэг сард 2–14 насны хүүхдүүдийн 17 хувийнх нь эцэг, эх болон гэр бүлийн гишүүд хүчирхийллийн бус арга (хүүхдийн гаргасан зан ааш нь буруу болохыг тайлбарлаж хэлсэн, шийтгэл болгож ямар нэг ажил хийлгэхээр өгсөн)–ыг судалгаанд сонгогдсон хүүхдийг хүмүүжүүлэхдээ хэрэглэсэн гэж хариулжээ.

Судалгаагаар 2–14 насны хүүхдийн 79 хувь нь сүүлийн нэг сард сэтгэл зүйн болон бие махбодийн ямар нэг шийтгэлийг эх, асрамжлагч эсвэл өрхийн бусад гишүүдийн зүгээс хүлээсэн байна гэсэн дүн гарч байна. Үүний дотор 38 хувь нь бие махбодийн ямар нэг шийтгэлийг хүлээсэн байна.

Хүүхдийн насаар авч үзвэл эрэгтэй хүүхдүүд хүчирхийллийн бус болон бие махбодийн шийтгэлд (15 хувь, 42 хувь) эмэгтэй хүүхдүүдээс (20 хувь, 33 хувь) арай илүү өртсөн байна.

2–14 насны хүүхдүүдийн сүүлийн нэг сард ямар нэг дарамт, шийтгэлд өртсөн байдлыг бүс нутаг, өрхийн байршил, аж байдал, эхийн боловсролын түвшингээр авч үзэхэд бараг ялгаагүй байна.

Судалгаанд хамрагдсан эх, асрамжлагчдын зөвхөн 15 хувь нь хүүхдийг зөв өсгөж хүмүүжүүлэхийн тулд тэднийг бие махбодийн хувьд шийтгэж болно гэж хариулсан байтал амьдрал дээр тэдний 38 хувь нь хүүхэддээ бие махбодийн ямар нэг шийтгэл үзүүлсэн байна.

Хүүхдээ хүмүүжүүлэхдээ бие махбодийн хувьд шийтгэж болно гэж үздэг эх, асрамжлагчдыг боловсролын түвшин, өрхийн аж байдлаар авч үзвэл нилээд ялгаатай байна. Тухайлбал боловсролгүй болон бага боловсролтой, ядуу эхчүүдийн 25 орчим хувь нь дээрхтэй санал нэг байхад дээд боловсролтой, чинээлэг эхчүүдийн хувьд 10 орчим хувь байна.

Эрт гэрлэлт

Хүүхдийн гэрлэлт бол охидын хөгжилд саад учруулж, охид, эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж байгаа бөгөөд үр дагавар нь эрт жирэмслэлт юм. Энэ нь цаашдаа тэдний хөгжих, боловсрох боломжийг багасган, улмаар жендэрт суурилсан ядууралд өртөн, нийгмээс тусгаарлагдах хүчин зүйл болдог. Хэт бага насандаа гэрлэсэн эмэгтэйчүүд ихэвчлэн сургуулиа орхиж, олон хүүхэд төрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл, эхийн эндэгдэлд өртөх нь түгээмэл байдаг.

Хүснэгт CD.5–д 18 хүртэлх насандаа гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болсон эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийг харуулав.


Судалгаанд хамрагдсан 15–49 настай эмэгтэйчүүдийн 8 хувь нь 18 хүртэлх насандаа гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болсон байна. Энэ үзүүлэлтийг сонгосон үзүүлэлтээр авч үзвэл хөдөөд амьдардаг, бага болон боловсролгүй, ядуу эмэгтэйчүүд төв суурин газрын боловсрол өндөртэй, чинээлэг эмэгтэйчүүдтэй харьцуулахад нилээд эрт гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болдог нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан 20–49 настай бага болон боловсролгүй эмэгтэйчүүдийн 18 орчим хувь нь 18 нас хүрэхээс өмнө гэр бүлтэй/ хамтран амьдрагчтай болсон байхад, энэ үзүүлэлт энэ насны дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд дөнгөж 3 хувь байна (Зураг XI.3).

Эрт гэрлэх (хамтран амьдрах) үзэгдэл ихсэх хандлагатай байна. Эрт гэр бүл болсон болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 45–49 настай

XI. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Зураг XI.3. 18 нас хүрэхээс өмнө гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болсон 20-49 настай эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2005 он



эмэгтэйчүүдийн 11 хувь нь 18 хүртэлх настайдаа гэр бүлтэй/хамтран амьдрагчтай болсон байхад 35–39 настай эмэгтэйчүүдийн хувьд 4 хувь болж буураад харин 20–24 настнуудын хувьд 9 хувь болж өссөн байна.

Энэ бүлэгт хамаарах өөр нэг үзүүлэлт бол одоогоор гэр бүлтэй/хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдээс 10 ба түүнээс дээш насаар ах нөхөртэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь юм. Эхнэр, нөхрийн насны ялгааг Хүснэгт СР.6-д харуулав.

Гэр бүлтэй/хамтран амьдрагчтай 15–19 ба 20–24 насны эмэгтэйчүүдийн нөхөр, хамтрагчийн ихэнх нь 0–4 насаар ах (58 хувь, 68 хувь) байна.

15–19 насны эмэгтэйчүүдийн гуравны нэг нь, 20–24 насныхны 21 хувь нь өөрөөсөө 5–9 насаар ах нөхөр,

хамтран амьдрагчтай байна. 20–24 насны эмэгтэйчүүдийн нөхөр/хамтран амьдрагчийн насны ялгааг сонгосон үзүүлэлтээр авч үзэхэд Хангайн бүсийн, хөдөөгийн, боловсролын түвшин доогуур, ядуу эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй өндөр байна.

Гэр бүлийн хүчирхийлэл

Судалгаанд хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдээс ямар тохиолдолд нөхөр нь эхнэр/хамтрагчаа цохиж, зодож болно гэж үздэг талаарх хандлагыг тодорхойлохоор эхнэр нь нөхөртөө хэлэлгүй гэрээс гарч явах, хүүхдэдээ анхаарал тавихгүй байх, нөхөртэйгээ маргалдах, бэлгийн харьцаанд орохоос татгалзах, түлэнхий хоол хийх зэрэг тохиолдолд нөхөр нь эхнэрээ цохиж, зодож болох уу гэсэн асуултыг асуусан. Эдгээр асуултууд нь нөхөр/хамтрагч нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх нь соёл, зан заншилтай холбоотой эсэхийг тодруулах зорилготой юм. Хэрэв эмэгтэй дээрх асуултад зөвтгөх хариу өгч байвал нөхөр/хамтран амьдрагч нь бодит байдал дээр тэднийг цохиж, зоддог байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлж болох юм.

Дээрх асуултын хариултыг Хүснэгт СР.7-д харуулав. 15–49 насны таван эмэгтэй тутмын нэг нь нөхөр нь эхнэр/хамтрагчаа дээр дурьдсаны аль нэг тохиолдолд цохиж, зодож болно гэж үздэг ажээ.

Хамгийн түгээмэл шалтгаан бол хүүхэддээ анхаарал халамж тавихгүй байх (12 хувь), үүний дараагаар нөхөртэйгээ маргалдах тохиолдол (11 хувь) байна. Эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлагыг сонгосон үзүүлэлтээр авч үзвэл нилээд ялгаатай байна. Баруун бүсийн эмэгтэйчүүдийн 33 хувь нь нөхөр нь эхнэрээ цохиж, зодож болно гэж үздэг байхад Улаанбаатарын эмэгтэйчүүдийн 12 хувь нь л ийм үзэл бодолтой байна.

Хөдөөгийн ялангуяа хөдөө багт амьдардаг эмэгтэйчүүд болон насны хувьд ахимаг насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад бүрэн дундаас дээш боловсролтой, залуу насны, чинээлэг эмэгтэйчүүдийн дунд нөхөр нь эхнэрээ цохиж, зодож болно гэж үздэг эмэгтэйчүүдийн хувь 2 дахин бага байна.

Хөгжлийн бэрхшээл

Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглалд зааснаар хүүхдийг хүчирхийлэл, хор хөнөөлт явдал, мөлжлөгийн аливаа үйлдэл болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ялгаварлан гадуурхах явдлаас хамгаалагдах ёстой гэж заасан байдаг.

Судалгаанд хамрагдсан 2–9 настай хүүхдийн эх/асрамжлагчаас хүүхэд хөгжлийн бэрхшээл/согог тухайлбал харах, сонсох болон хэл ярианы гэх мэт ямар нэг бэрхшээл, согогтой эсэхийг асуусан. Энэ арга нь ДЭМБ-аас боловсруулсан хөгжлийн бэрхшээл гэдэг ойлголтод тулгуурласан бөгөөд хүүхдийн хөгжилд нөлөөлж болох согог, бэрхшээлийг илрүүлэх зорилготой юм.

Энэ бүлгийн асуултын үр дүнг Хүснэгт СР.8–д харууллаа. 2–9 настай хүүхдүүдийн 17 хувь нь ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй⁸ гэжээ.

Хүүхдүүдийн 5 хувь нь үеийн хүүхдүүдтэй харьцуулахад оюун ухааны хоцрогдолтой (ойлголт удаан) гэж эх/асрамжлагч нь хариулжээ. Энэ төрлийн согогтой хүүхдүүд Зүүн бүсэд харьцангуй өндөр (13 хувь) байна. Харин сонгосон бусад үзүүлэлтийн хувьд бараг ялгаагүй байна. Үүний дараа орох түгээмэл бэрхшээл бол өөрийнхөө санааг үгээр илэрхийлж ярьж чаддаггүй, тулгуур эрхтний (явах болон, гараа хөдөлгөхөд) ямар нэг бэрхшээлтэй гэж тус бүр 4 хувь нь хариулжээ.

Хүүхдүүдийн 3 хувь нь харах эрхтний бэрхшээлтэй гэж эх/асрамжлагч нь хариулжээ. Хотын, боловсролын түвшин өндөр эхчүүдийн хүүхэд харааны бэрхшээлтэй байх нь илүү түгээмэл байна.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг сонгосон үзүүлэлтээр авч үзэхэд Зүүн бүсэд, хөдөөд, боловсролын түвшин доогуур эхчүүдийн хүүхдэд мөн ядуу өрхийн хүүхдүүдэд бэрхшээлийн ихэнх төрлийн хувьд илүү тохиолдож байна.

⁸“Хөгжлийн бэрхшээл гэдэг ойлголтыг ХХС 2005–д өргөн утгаар авч хэрэглэсэн болно.

ХИ

ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвар хэрхэн халдварладаг, түүнээс хэрхэн сэргийлэх талаар зөв мэдлэгтэй байх нь энэхүү халдвараас сэргийлэх хамгийн чухал нөхцөл юм. Зөв мэдээлэл өгөх нь халдвараас сэргийлэх арга замыг зааж өгөх, мэдлэгийг нэмэгдүүлэх эхний алхам юм. ХДХВ-ийн тухай буруу ойлголт нь залуучуудад эргэлзээ төрүүлэх, урьдчилан сэргийлэх талаарх чармайлтыг сааруулахад хүргэдэг.

